



МАНДАХ
ИХ СУРГУУЛЬ

МАНДАХ ЭРДЭМ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

ISSN: 2663-256X

МАНДАХ ЭРДЭМ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

Дугаар #14, 2025

ISSN: 2663-256X

MANDAKH RESEARCH

INTERNATIONAL SCIENTIFIC JOURNAL

2025/12

Сэтгүүлийн талаар санал, хүсэлтээ доорх хаягаар ирүүлнэ үү.

Мандах Их Сургууль,
Баянгол дүүрэг, 16-р хороо,
Амарсанаагийн гудамж 18/1, Улаанбаатар хот, Монгол,
Шуудангийн хаяг: УБ-16040, ш/х88,
7018-5950, 9918-0487

Цахим шуудан: journal@mandakh.edu.mn

Цахим хуудас: <http://journal.mandakh.org>
<http://mandakh.edu.mn>

Сэтгүүлийн зөвлөл

Дарга:	Г. Нанжид, профессор
Ерөнхий редактор:	Ч. Төрбадрах, Ph.D, профессор
Нарийн бичгийн дарга:	О.Бурмаа, Ph.D, дэд профессор
Гишүүд:	
	Л. Энх-Амгалан, Ph.D, профессор
	Д. Бадарч, Ph.D, профессор
	С. Цолмон, Ph.D, профессор
	Б.Мөнхбат, Ph.D, профессор (ХААИС)
	С.Эрдэнэтуул, Ph.D, профессор (ХИС)
	А.Наранцэцэг, Ph.D, дэд профессор
	С. Ганцэцэг, Ph.D, дэд профессор
	Б. Оюунтунгалаг, Ph.D, дэд профессор (ШУТИС)
	Masaaki Aoki, Ph.D, профессор (Япон)
	Jiang Ailin, Ph.D, профессор (БНХАУ)
	Andrii Kostyryzhev, Ph.D, дэд профессор (Австрали)
	Wisuttorn Jitaree, Ph.D, дэд профессор (Тайланд)
	Andre Eric Shimunek, Ph.D, дэд профессор (БНСУ)

АГУУЛГА

А.Наранцэцэг, Г.Дариймаа

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА, BUS1401	7
--	---

Ц.Номин, Г.Алдаржав

ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН АВТО МАШИН ХУДАЛДАН АВАХ ХҮСЭЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА, BUS1402	20
---	----

М.Жанузах, О.Бурмаа, Р.Чанцалдулам

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНААНЫ ХУВЬСАЛ, BUS1403	34
---	----

Ц.Одгарав, О.Жаргалмаа, Г.Золбоо

ДИЖИТАЛ БИЗНЕСИЙН ЭКОСИСТЕМИЙН ТАЛААРХ СИСТЕМЧИЛСЭН ТОЙМ СУДАЛГАА, BUS1404	50
---	----

М.Ганхөлөг, Н.Далайсайхан, Б.Сайнжаргал

“Z” ҮЕИЙН СОНГОГЧДЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЖЕНДЭРИЙН НӨЛӨӨ, BUS1405	62
--	----

Д.Буяндэлгэр

МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭГ ОНОВЧЛОХ НЬ, BUS1406	74
--	----

С.Ганцэцэг, С.Сайнзаяа

ҮЗЭМЧИН ӨВ СОЁЛЫН ДАРХЛААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА, HUM1401	85
--	----

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА (ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

А.Наранцэцэг^{1a}, Г.Дариймаа^{2b}

¹ Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, дэд профессор, Ph.D

² Мандах Их Сургууль, “Нягтлан бодох бүртгэл” хөтөлбөрийн магистрант

^a narantsetseg@mandakh.edu.mn

^b AC24E012@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Дэлхий нийтээрээ ногоон эдийн засагт шилжиж байгаа өнөө үед хөрөнгө оруулагч болон сонирхогч талууд байгууллагуудын зөвхөн санхүүгийн үзүүлэлт бус санхүүгийн бус үзүүлэлтийг сонирхох болсон бөгөөд үүнийг нэг Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт юм. Энэхүү судалгааны зорилго нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн БОНЗ-ын тайлагнал өнөөгийн нөхцөл байдал ямар түвшинд байгаа болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлоход чиглэгдэнэ. Дэлхийн улс орнуудад IFRS S1, IFRS S2 зэрэг шинэ стандартууд нэвтэрч, ил тод байдлын шаардлага нэмэгдэж байгаа ч Монгол Улсад энэ чиглэлийн хэрэгжилт сул, институтийн болон мэргэжлийн чадавх хангалтгүй байна. Судалгаанд хөрөнгийн биржид бүртгэлтэй 2022–2024 оны 163 компаниас БОНЗ-ын тайлангийн тайлагнасан байдал болоод 78 байгууллагын удирдлагын санал асуулгыг ашиглан өнөөгийн нөхцөл, чиг хандлагыг үнэлэв. Мөн Хөрөнгийн биржид бүртгэлтэй I ба II ангиллын 69 компанийн БОНЗ-ын тайлангийн өгөгдөлд хийсэн логистик регрессийн шинжилгээний үр дүнгээр компанийн ангилал нь БОНЗ тайланг тайлагнах магадлал 6 дахин их байна. Харин санхүүгийн үзүүлэлтүүд тайлагналд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй байгаа нь БОНЗ-ын тайлагнал сайн дурын бус, зохицуулалтын шалтгаантай байгааг харуулж байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт компаниудын зөвхөн 19.02% нь БОНЗ-ын тайлан гаргаж буй нь төлөвшөөгүй байгааг харуулж, цаашид мэргэжлийн чадавх, засаглал, стандартын хэрэгжилт болон салбарын онцлогт суурилсан тайлагналын хөгжил шаардлагатай байна.

ТҮЛХҮҮР ҮГ: Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь хүнсний үйлдвэрлэлийн салбар дахь байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын олон улсын чиг хандлагыг судлан, Монгол Улсад хэрэгжилтийн түвшин ямар байгааг тодорхойлж, хүнсний үйлдвэр, худалдааны салбарын томоохон төлөөлөл компаниудын жишээн дээр тогтвортой байдлын талаарх мэдээлэл хэрхэн бүртгэгдэж, тайлагнагдаж буйг шинжлэх, тухайн тайлангийн чанар, ил тод байдал, цаашид үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжийг тодорхойлох юм.

1. Онолын үндэс судлах- БОНЗ-ын үзэл баримтлал, олон улсын стандартууд (GRI, SASB, TCFD, IFRS S1, IFRS S2)-ын агуулга, зарчим, аргачлалыг судлах
2. Олон улсын туршлагыг шинжлэх- Хүнсний салбарын тэргүүлэгч компаниудын БОНЗ тайлагналын сайн туршлага, хэрэгжүүлж буй аргыг судлах
3. Монголын нөхцөл байдлыг үнэлэх- Хүнсний үйлдвэрлэлийн салбарт БОНЗ-ын тайлагналын өнөөгийн түвшнийг судлах
4. Санал, зөвлөмж боловсруулах- Хүнсний үйлдвэрийн БОНЗ-ын тайлагналын чанарыг сайжруулах

Хүснэгт 1. Дотоод судлагдсан байдал

№	Судлаач / Эх сурвалж	Он	Судалгааны зорилго	Гол агуулга / Дүгнэлт	Судалгаанаас авч ашиглах санаа
1	СТОУС ТБ1, ТБ2 стандартууд	2023	ТБ тайлагналын суурь шаардлагыг тодорхойлох	IFRS S1 – тогтвортой байдлын мэдээллийн ерөнхий шаардлага; IFRS S2 – уур амьсгалын эрсдэл. Ил тод байдал, уялдаа, тайлагналын шинэ шаардлагууд.	Монголын компаниудад ТБ тайлагнал заавал хэрэгжих суурь нөхцөлийг ойлгох
2	Монголын компаниудад зориулсан БОНЗ ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж	2022	БОНЗ тайлагналын үндэс, хэрэглээ	GRI, SASB, IFRS S1/S2 зэрэг олон улсын аргачлалыг танилцуулсан. 30 гол үзүүлэлтийн жагсаалт. Бүх төрлийн байгууллагын үнэлгээ хийх боломж.	Судалгаанд үзүүлэлт сонгоход хэрэглэгдэх үндэс
3	Д.Нямаа, Н.Баярчимэг	2023	ТБ тайлагналын баталгаажуулалтын өнөөгийн байдал	ТБ тайлангийн баталгаажуулалт 4 үе шаттай (хүлээн авах, төлөвлөх, гүйцэтгэл, үр дүн). Монголын нөхцөлд баталгаажуулалт шаардлагатай.	БОНЗ тайлангийн чанарын баталгаажуулалт шаардлагатай гэж үзэх үндэслэл
4	Б.Дугармаа	2022	Уул уурхайн компаниудын БОНЗ үнэлгээ ба зах зээлийн үнэлгээ	БОНЗ үнэлгээ өсөх тусам зах зээлийн үнэлгээ өсдөг. Панел регрессийн шинжилгээг ашигласан. БОНЗ доогуур үнэлгээтэй компани сайжруулсан оноо тутам илүү өсөлттэй.	Судалгаанд БОНЗ-санхүүгийн үзүүлэлтийн хамаарлыг ашиглах

5	Б.Төр-Эрдэнэ	2023	БОНЗ хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх эсэх	үнэлгээ	Монголын хөрөнгө оруулагчдад санхүүгийн мэдээлэл хамгийн чухал; БОНЗ ч мөн эерэг нөлөөтэй. Олон улсын туршлага ба эмпирик загварууд ашигласан.	Судалгаанд хөрөнгө оруулагчийн зан төлөвийг харгалзах
---	--------------	------	--	---------	--	---

Эх сурвалж: Судлагдсан байдал МУ хэмжээнд

Хүснэгт 2. Гадаад судлагдсан байдал

№	Судлаач / Эх сурвалж	Он	Судалгааны зорилго	Гол агуулга / Дүгнэлт	Судалгаанаас авч ашиглах санаа
1	WEF – Global Risks Report	2023	Хүнс, хөдөө аж ахуй ба байгальтай холбоотой эрсдэл	Усны хомсдол, био олон янз байдлын алдагдал, уур амьсгалын эрсдэл хүнсний салбарын гол эрсдэл	Хүнсний салбарын БОНЗ эрсдэлийн суурь
2	FAO – ENCORE, FAIRR, Forest500	2020	Байгальтай холбоотой санхүүгийн эрсдэлийн үнэлгээ	Экосистемийн нөлөөлөл, ус-хөрсний эрсдэл, ой устгалын эрсдэлийг хэмжих олон улсын аргачлал	Судалгааны аргачлал сонгоход ашиглах боломж
3	FAO – SAFA Framework	2014	Хүнсний системийн тогтвортой байдлын үнэлгээ	4 тулгуур (Засаглал, Байгаль орчин, Эдийн засгийн тэсвэр, Нийгмийн сайн сайхан байдлыг үнэлдэг)	Үзүүлэлт тодорхойлох олон улсын стандарт
4	European-listed food firms	2020	БОНЗ тайлагнал ба ашигт ажиллагаа	Байгаль орчны ба нийгмийн мэдээллийн ил тод байдал ашигт ажиллагааг өсгөдөг; Засаглалын мэдээлэл зарим тохиолдолд сөрөг нөлөөтэй	Монголын хүнсний салбарын үнэлгээтэй харьцуулахад ашиглах
5	EU Food Industry ESG Study	2022	БОНЗ ба санхүүгийн гүйцэтгэл (ROA, ROE)	БОНЗ нь санхүүгийн үзүүлэлтэд нийтлэг эерэг нөлөөтэй. Орнуудын ялгаа ажиглагдсан.	Судалгаанд регрессийн шинжилгээ ашиглах суурь
6	High-tech firms – ESG & Dividend Policy	2023	БОНЗ ба ногдол ашгийн бодлого	БОНЗ өндөр байх тусам тогтвортой ногдол ашиг тараах хандлага нэмэгддэг.	ESG-ийн компанийн санхүү-менежментийн шийдвэрт нөлөөлөх байдлын олон улсын нотолгоо

Эх сурвалж: Судлагдсан байдал бусад орнуудын хэмжээнд

Орчин үед дэлхийн нийтээр БОНЗ тайлан гаргалт нь улам бүр нэмэгдэж, тайлан гаргаж буй байгууллагууд нь төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтэд хамрагдах боломж нь нэмэгдэж байна. Ялангуяа байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй бизнест ногоон санхүүжилт олгох, ногоон зээл олгох гэх мэт боломжууд бий болж байна. Иймд дараах таамаглалыг дэвшүүлж байна.

H1: Эрх бүхий байгууллагын шийдвэр нь байгаль орчин, нийгэм, засаглалын тайланг бэлтгэх магадлалыг нэмэгдүүлнэ.

H2: БОНЗ тайлагналын хэрэгжилт нь компанийн санхүүгийн гүйцэтгэлд статистикийн ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг.

НЗ: БОНЗ тайлагналын хэрэгжилт өндөр байх тусам компанийн ашигт ажиллагаа (ROA, ROE) нэмэгдэх хандлагатай байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Монголын хөрөнгийн биржид нийт 169 компани бүртгэлтэй байдгаас энэхүү судалгаанд үйл ажиллагаа тогтвортой явуулж буй, санхүүгийн болон байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн мэдээлэл харьцангуй бүрэн байгаа 1 болон 2-р ангиллын компаниудыг хамруулсан болно. Үүнээс гадна БОНЗ-ын бодлого, хэрэгжилтийн өнөөгийн түвшнийг үнэлэх зорилгоор хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт 78 байгууллагыг асуулгын судалгаанд хамруулсан. Судалгаанд цуглуулсан анхдагч болон хоёрдогч өгөгдлийг SPSS 27.0 статистик программ ашиглан боловсруулж, тоон шинжилгээ хийсэн.

Судалгааны өгөгдлийг дараах эх сурвалжуудаас бүрдүүлэн цуглуулсан. Үүнд:

1. Компаниудын санхүүгийн болон жилийн эцсийн тайлангууд;
2. Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, хэрэгжилт, дотоод чадавх, ажилтнуудын мэдлэг мэдээллийн түвшинг үнэлэх зорилгоор Office 365 Form платформ ашиглан зохион байгуулсан асуулгын судалгаа;
3. Судалгаанд хамрагдсан хүнсний компанийн 2023 болон 2024 оны БОНЗ-ын тайлангууд.

Судалгаанд дараах загварыг ашигласан болно. Үүнд:

$$\text{logit}(P_i) = \beta_0 + \beta_1(\text{ROA}_i) + \beta_2(\text{ROE}_i) + \beta_3(\text{Хөрөнгө}_i) + \beta_4(\text{ӨрийнХарьцаа}_i) + \beta_5(\text{Санхүүжилт}_i) + \beta_6(\text{Ангилал}_i) + \epsilon_i$$

ROA_i	: Нийт хөрөнгийн өгөөж (Return on Assets)
ROE_i	: Өөрийн хөрөнгийн өгөөж (Return on Equity)
Хөрөнгө_i	: Компанийн нийт хөрөнгө
ӨрийнХарьцаа_i	: Өрийн түвшин / Total Debt ratio
Санхүүжилт_i	: Мөнгөн санхүүжилтийн хэмжээ
Ангилал_i	: Компанийн ангилал (1,2 зэрэг категори хувьсагч)
ϵ_i	: Бодит болон таамагласан утгын зөрүү

Судалгаа дараах хязгаарлалтыг агуулна. Үүнд:

- БОНЗ-ын тайлагнал Монгол Улсад харьцангуй шинэ тул байгууллагуудын мэдлэг, ойлголтын түвшин жигд бус байгаа нь харагдаж байна.
- Зарим компанийн тайлангийн мэдээлэл дутуу тайлагналын стандарт харьцангуй шинэ учир стандарт бус байна.

- Судалгаа нь зөвхөн ил тод байршуулсан тайланд тулгуурласан тул бодит хэрэгжилтийн түвшнийг бүрэн илэрхийлэхэд хязгаарлалттай байгаа хэдий ч Монгол Улсад БОНЗ-ын тайлагналын өнөөгийн байдал, хэрэгжилтийн түвшинг үнэлэхэд онолын болон практикийн хувьд ач холбогдолтой гэж үзэв.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ШААРДЛАГУУД СҮҮЛИЙН ҮЕИЙН ХАНДЛАГА

Дэлхийн түвшинд цаг уурын өөрчлөлт, экосистемийн доройтол, байгалийн нөөцийн хомсдол гэх мэт ойрын 10 жилийн хамгийн том эрсдэлийн эхний 4-ийг эзэлж байгаа бөгөөд үүнийг Монгол улсын хувьд авч үзвэл:

- Цөлжилт, ган, усны нөөцийн хомсдол эрчимтэй нэмэгдэж байна.
- Хөрсний доройтол, мал аж ахуйн бэлчээрийн системийн алдагдал, хог, бохирдол, уур амьсгалын эрс тэс үзэгдэл (шуурга, үер, ган) нь эдийн засгийн гол салбарууд (хөдөө аж ахуй, уул уурхай)-т шууд нөлөөлж байна.
- Байгаль орчны доройтол нь хүн амын шилжилт хөдөлгөөн, амьжиргааны бууралт, нийгмийн даралт үүсгэх гол шалтгаан болж байна.

Мөн тэгш бус, ажилгүйдэл, орлогын ялгаа нэмэгдэж, хүмүүсийн амьдралын чанар маш их ялгаатай байна. Залуучуудын ажилгүйдэл, ур чадварын зөрүү, боловсролын түвшин эрс ялгаатай болж хүмүүсийн бухимдлыг нэмэгдүүлэх эрсдэл үүсэж байна. Тэтгэврийн тогтолцоо, ажиллах хүчний хомсдол, цаашлаад олон нийтийн мэдээллийн орчин, ташаа мэдээлэл, мэдээллийн боловсрол, дижитал ёс зүй, хиймэл оюун ухаан (AI)-ны зохицуулалт сул, эдийн засаг, аюулгүй байдлын бодлого, экспорт, импортын түүхий эд, бараа материалын хамаарал их байгаа нь дээрх прогноз манай улсын хувьд ч тулгарах том асуудлууд болоод байгаа нь батлагдаж байна. Тэгэхээр Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд БОНЗ-ын асуудлыг судлах, хөгжүүлэх, хэвшил болгох замаар дэлхийн эрсдэлийг давах шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.

Сүүлийн жилүүдэд хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд нь хариуцлагатай хөрөнгө оруулалт, өгөөжөө нэмэгдүүлэх, эрсдэлээ илүү сайн удирдахад ач холбогдол өгөхөөс гадна БОНЗ-ын хувьд тухайн хөрөнгө оруулалтаас үзүүлэх нөлөөлөлд илүү төвлөрдөг. (Байгаль орчин нийгэм засаглалын гарын авлага, 2022)

ХҮНСНИЙ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, БОНЗ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН БОЛОВСРУУЛАЛТ

БОНЗ-ын шалгуур үзүүлэлт болон хүнсний аюулгүй байдлын шаардлагуудыг хангахын тулд байгууллага өөрийн үйл ажиллагаанд өөрийгөө үнэлэх, түүнчлэн хоёрдогч болон гуравдагч талын хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулах шаардлагатай. Үүнийг хангах зорилгоор хүнсний салбарт зориулсан БОНЗ-ын үнэлгээний удирдамж баримт бичиг боловсруулагдсан. Энэхүү удирдамжийн дагуу байгууллага БОНЗ-ын үнэлгээ хийлгэж, баталгаажуулснаар:

- Ханган нийлүүлэлтийн сүлжээнд БОНЗ-ын зарчмуудыг нэвтрүүлж ажиллаж байгаагаа нотолж чадна.

- Албан ёсны баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээ авах боломжтой болно.
- Салбарын материаллаг асуудлыг удирдахад нөлөөлнө.
- Тогтвортой хөгжлийн хүрээнд ногоон зээлд хамрагдах боломж нэмэгдэнэ.
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж буй асуудлуудыг системтэйгээр үнэлж, шийдвэрлэхэд хувь нэмэр оруулна.
- Үндэсний болон олон улсын хууль эрх зүйн орчин, зохицуулалтын шаардлагад үйл ажиллагаагаа нийцүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Ил тод байдлыг хангаж, БОНЗ-ын зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулснаар хөрөнгө оруулагчид, хэрэглэгчид болон ханган нийлүүлэгчдийн итгэлийг нэмэгдүүлнэ.
- Энэ нь компанийн нэр хүндийг өсгөхөөс гадна олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Хөрөнгө оруулалт авах, санхүүжилтийн нөлөөлөл нэмэгдэнэ гэх мэт маш олон давуу талтай болно.

БОНЗ-ын тайлагналын стандарт нь бусад энэ чиглэлийн стандартуудтай уялдаа холбоотой бөгөөд хүнсний салбарт заавал тайлагнах үндсэн үзүүлэлтүүдийн уялдааг доорх хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Заавал тайлагнах үндсэн үзүүлэлтүүд

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Холбоос
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд		
MS1		Удирдлагын менежмент, амлалт	GRI 102
MS2		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	GRI 103, ISO 14001
MS3		Бүтэц удирдлага	GRI 102
MS4	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	GRI 102
MS5		Чадавх бүрдүүлэлт	GRI 102, SDG 12
MS6		Хяналт	
MS7		Тогтвортой байдлын тайлагнал	
MS8		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	
	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд		
E1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	GRI 302, SDG 12
E2	Хүлэмжийн хийн ялгарал	Хүлэмжийн хийн ялгаруулалт	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам, өөрчлөлт	GRI 201, TCFD, SDG 13
E4	Ус	Усны хэрэглээ	GRI 303, SDG 6
E5	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	GRI 306, SDG 12
E6	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	GRI 304, SDG 15
	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд		
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	GRI 401, SDG 8

S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	GRI 103, SDG 10
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	GRI 405, SDG 5
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	SDG 10
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	IFC
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	GRI 204, SDG 8
G	Засаглалын шалгуур үзүүлэлтүүд		
G1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого, журам	GRI 205, SDG 16
G2	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	GRI 102, OECD Principles
G3	Комплаенс	Комплайнсын бодлого	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Салбарын онцлогтой нэмэлт шалгуур үзүүлэлтүүд (зөвхөн өөрийн компанид хамаарах салбарын асуултад хариулна)			
FS	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	SDG 1
AF	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	GRI 403, SDG 12
T	Текстиль	Тогтвортой мал аж ахуй	
MA	Боловсруулах	Химийн бодисын менежмент	
MI	Уул уурхай	Нөхөн сэргээлт	
CO	Барилга	Ногоон барилгын шошго/ гэрчилгээ	

Эх сурвалж: БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж 2023 он

GRI стандарт нь байгууллагын байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг өргөн хүрээнд тайлагнахад чиглэдэг бол SASB болон IFRS S1, S2 стандартууд нь БОНЗ хүчин зүйлсийн санхүүгийн материаллаг байдалд төвлөрдөг. Тухайлбал, IFRS S1 стандарт нь БОНЗ хүчин зүйлсийн компанийн санхүүгийн байдал, гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг ерөнхий хүрээнд тодорхойлдог бол IFRS S2 нь уур амьсгалын эрсдэлийг санхүүгийн эрсдэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон авч үздэг. Иймд энэхүү судалгаанд GRI стандартын шалгуур үзүүлэлтүүдийг үндсэн хүрээ болгон авч, IFRS S1, S2 болон TCFD-д хамаарах үзүүлэлтүүдтэй уялдуулан хүнсний салбарын БОНЗ тайлагналын хэрэгжилтийг үнэлсэн.

БОНЗ-ЫН ТАЙЛАГНАЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 1,2,3-р ангиллын компаниуд сайн дурын болон “Монголын хөрөнгийн бирж” ХК 2022 онд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын тогтвортой хөгжил санхүүгийн холбоо (ТоС холбоо), Олон улсын санхүүгийн корпорац зэрэг байгууллагуудын гаргасан удирдамжийн дагуу “Биржид бүртгэлтэй ХК-уудын БОНЗ-ын тайлагналын тайлангийн маягтыг боловсруулж олон нийтэд хүргэх зорилгоор сайн дурын үндсэн дээр” 2022-2024 оны тайланг өөрийн сайтад байршуулан хэрэглэгчид хүргэж байсан ч 2024 оны 10-р сараас Үнэт цаас

гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журамд өөрчлөлт орж 3,7-д биржид бүртгэлтэй 1-р ангиллын үнэт цаас гаргагч нь БОНЗ-ын чиглэлээр жилийн тайланг 04-р сарын 30-ны дотор ирүүлнэ гэж заасан байдаг. Хөрөнгийн биржийн сайт (2025 оны 09 сарын байдлаар)-аар тайлан өгсөн байдал доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт компаниудын эзлэх хувь

Хөрөнгийн биржийн ангилал	Нийт бүртгэлтэй компаниуд	Эзлэх хувь	Тайлан байршуулсан компаниудын тоо	Эзлэх хувь	Бүртгэлтэй нийт компаниас тайлан өгсөн компаний эзлэх хувь
1-р ангилал	25	15.3	21	67.74	12.88
2-р ангилал	44	27.0	8	25.81	4.91
3-р ангилал	94	57.7	2	6.45	1.23
Нийт бүртгэлтэй компани	163	100	31	100	19.02

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 163 компаниас зах зээлийн үнэлгээ, борлуулалтын орлогын хэмжээ, жилийн цэвэр ашиг гэх мэт хүчин зүйлийн шалгуураар 3 ангилагддаг бөгөөд 1-р ангиллын 25 (15.3%) компани, 2-р ангиллын 44 (27%) компани, 3-р ангиллын 94 (57.7%) -ын компани үйл ажиллагаа явуулж байна.Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас 19,02% буюу давхцалгүйгээр 31 компанийн, давхацсан тоогоор 2022-2024 оны 66 тайлан МХБиржийн сайтад байгаа бөгөөд үүнээс 1-р ангилал 21 (67.74%), 2-р ангилал 8 (25,81%), 3-р ангилал 2 (6.45%) -ын компаниуд тайлан өгсөн байна 1-р зэрэглэлийн компанийн 12,9% нийт бүртгэлтэй компанийн 19,02% нь тайлан өгч байгаа харагдаж байна. Энэ бол БОНЗ-ын тайлан тогтвортой хөгжлийн жишиг тайлангийн мэдлэг мэдээлэл болон тайлагнал маш бага байгаа, харьцангуй шинэлэг байгааг илтгэж байна.

Хөрөнгийн биржийн цахим хуудаснаас 2022–2024 онд нийт 31 компанийн нээлттэй байршуулсан тогтвортой байдлын болон нийгмийн хариуцлагын тайлангуудыг судалснаас хүнсний салбарын төлөөлөл болгон “Түмэн шувуут” ХК, “АПУ” ХК, “Сүү” ХК, “Увс хүнс” ХК, “Монос Хүнс” ХК гэсэн таван компанийг сонгон авч шинжилгээ хийв. Эдгээр компанийн 2023 болон 2024 оны тайлангийн үзүүлэлт, мэдээллийн агуулгыг харьцуулан дүн шинжилгээ хийх зорилгоор шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн бүлэг болгон үзүүлэв.

Хүснэгт 5. Тогтвортой байдлын тайлагнал ба гүйцэтгэлийн үнэлгээ

Код	Тайлбар/асуулт/	Үзүүлэлт (өмнөх он)			Үзүүлэлт (тайлант он)		
		Тийм	үгүй	Бөглөөгүй	тийм	үгүй	Бөглөөгүй
MS1.1	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	1	3	1	3	2	0
MS2.1	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	2	3	0	3	2	0
MS2.2	Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	0	5	0	0	5	0

MS3.1	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	1	4	0	3	2	0
MS3.2	ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх	4	1	0	4	1	0
MS3.3	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	4	1	0	4	1	0
MS3.4	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	2	1	2	3	1	1
MS3.5	Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	4	1	0	4	1	0
ДҮН		18	19	3	24	15	1

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тайлант онд тогтвортой хөгжлийн удирдлагын системийн хэрэгжилт сайжирсан байна. Өмнөх онд нийт 18 “Тийм” хариулт байсан бол тайлант онд 24 “Тийм” болж 33,3%-аар өссөн байна. Харин “үгүй” болон “бөглөгдөөгүй” хариултын тоо буурсан нь тогтвортой хөгжлийн бодлого, бүтэц, хороодын үйл ажиллагаа илүү тогтмолжиж итэвхжсэн болохыг харуулж байна. Удирдлагын түвшинд тогтвортой хөгжлийн “”талаар амлалт, мэдээлэл илүү тодорхой болж нэмэгдсэн. ТУЗ болон удирдлагын түвшинд БОНЗ-ийн асуудал хариуцсан гишүүн, менежер томилох байдал тогтвортой хэвээр байна. Энэ нь байгууллагын дотоод зохион байгуулалт сайжирч байгааг харуулж байна.

Тайлант онд тогтвортой байдлын тайлагнал, хяналт, гишүүнчлэл хамтын ажиллагааны үзүүлэлтүүд 2023 болон 2024 оны дүн өөрчлөлт багатай харагдаж байна. “Тийм” хариулт 9 байсан “бөглөгдөөгүй” 3, харин 2024 онд 1 компанийн хувьд БОНЗ-ын тайлантай холбоотой заавар, журам шинээр гаргасан үр дүн гарсан байна. Журам заавар, бодлогын хэрэгжилт тал дээр харьцангуй шинэ тайлагнал байгааг илтгэж байна.

Хүснэгт 6. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлууд

Код	Тайлбар/асуулт/	Үзүүлэлт (өмнөх он)			Үзүүлэлт (тайлант он)		
		Тийм	үгүй	бөглөөгүй	тийм	үгүй	Бөглөөгүй
E3.1	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	1	4	0	1	4	0
E3.2	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	0	5	0	0	5	0
E3.5	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх	0	5	0	1	4	0

эрсдэлээс урьдчилан сэргийлэх,
(хэрэв урьдчилан сэргийлэх
боломжгүй бол) дасан зохицох
чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/
алхмуудыг тодорхойлсон уу?

ДҮН

1

14

0

2

13

0

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого, эрсдэлийн үнэлгээ, арга хэмжээний хэрэгжилт нийтдээ сул байгаа ч тайлант онд бага зэрэг ахиц гарсан байна. Гэвч байгууллагуудын дийлэнх нь уур амьсгалын бодлого, эрсдэлийн үнэлгээ болон дасан зохицох арга хэмжээг албан ёсоор хэрэгжүүлээгүй байгаа нь энэ чиглэлд цаашид дэмжлэг, сургалт шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 7. Жендерийн бодлого журамтай холбоотой асуудлууд

Код	Тайлбар/асуулт/	Үзүүлэлт (өмнөх он)			Үзүүлэлт (тайлант он)		
		Тийм	үгүй	Бөглөөгүй	тийм	үгүй	бөглөөгүй
S3.1	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	5	0	0	5	0	0
S3.2	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	5	0	0	5	0	0
S3.3	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	5	0	0	5	0	0
S4.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	0	4	1	2	3	0
S4.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	1	2	2	4	1	0
<u>ДҮН</u>		<u>16</u>	<u>6</u>	<u>3</u>	<u>21</u>	<u>4</u>	<u>0</u>

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан 5 хүнсний компанийн нийгмийн бодлого, журам хэрэгжилтийн түвшинг 2023 он болон 2024 онуудаар харьцуулахад дараах өөрчлөлт гарсан байна. Жендерийн бодлого, бэлгийн дарамтын эсрэг бодлого, ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого зэрэг гол нийгмийн бодлогын үзүүлэлтүүдийн хэрэгжилт маш сайн буюу энэ чиглэлийн журам бүх компанид гаргасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого болон хүртээмжийн шийдэлтэй холбоотой үзүүлэлтүүдийн хувьд өмнөх оныхоос ахиц гарч “Тийм” гэсэн хариулт 1-ээс 3 болж нэмэгдсэн нь байгууллагууд олон нийтийн хүртээмжийг анхаарч эхэлж буйг харуулж байна. Нийт дүнгээр 31.25%-аар өссөн байна.

Хүснэгт 8. Хамтын ажиллах дүрэм журамтай холбоотой асуудлууд

Код	Тайлбар/асуулт/	Үзүүлэлт (өмнөх он)			Үзүүлэлт (тайлант он)		
		Тийм	үгүй	бөглөөгүй	Тийм	үгүй	Бөглөөгүй
S5.1	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	4	1	0	4	1	0
S5.2	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	0	3	2	1	3	1
S5.3	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	3	1	1	4	0	1
S5.4	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	4	0	1	4	0	1
S6.1	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	3	0	2	4	0	1
<u>ДҮН</u>		<u>14</u>	<u>5</u>	<u>6</u>	<u>17</u>	<u>4</u>	<u>4</u>

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан хүнсний салбарын 5 компанийн нийгмийн оролцоо болон тогтвортой худалдан авалтын бодлогын хэрэгжилтийг 2023 он болон 2024 онуудаар харьцуулахад нийт “Тийм” хариултын тоо 14-өөс 17 болж өссөн бол “Үгүй” гэсэн хариулт 5-аас 4 болж буурсан байгаа бөгөөд “Бөглөөгүй” хариулт 6-аас 4 болж буурсан байна. Оролцогч талуудтай хамтран ажиллах дүрэм журам болоод санал гомдол маргааныг шийдвэрлэх механизм сайжирч, гадаад дотоод худалдан авалтын журам стандартын дагуу хэрэгжиж сайжрах хандлагатай байна.

Хүснэгт 9. Засаглалтай холбоотой асуудлууд

Код	Тайлбар/асуулт/	Үзүүлэлт (өмнөх он)			Үзүүлэлт (тайлант он)		
		тийм	үгүй	Бөглөөгүй	тийм	үгүй	бөглөөгүй
G1.1	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	4	1	0	4	1	0
G1.3	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	0	0	5	0	0	5
G2.1	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	4	0	1	5	0	0
G2.2	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	5	0	0	5	0	0
G2.3	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	5	0	0	5	0	0
G3.1	Комплаенсын бодлого, журам бий юу?	5	0	0	5	0	0

G3.2	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	4	1	0	4	1	0
	<u>ДҮН</u>	<u>27</u>	<u>2</u>	<u>6</u>	<u>28</u>	<u>2</u>	<u>5</u>

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүнсний салбарын компанийн засаглалтай холбоотой, журамтай, хөтөлбөрийн хэрэгжилтийн харьцуулалтаас үзэхэд нийт “Тийм” гэсэн хариулт 2 оны байдлаар 27-оос 28 болж өссөн байна. Бүх компаниудад тогтвортой хэрэгжиж байгаа нь сайн засаглалын суурь бүрэлдэхүүн хангагдаж байгааг илтгэж байна. Комплаенсийн бодлого хөтөлбөр бүрэн хэрэгжиж, ажилтнуудын хяналт, сургалт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрэлдэж эхэлсэн харагдаж байна.

Хүснэгт 10. Химийн бодисын менежментийн асуудлууд

Код	Тайлбар/асуулт/	Үзүүлэлт (өмнөх он)			Үзүүлэлт (тайлант он)		
		тийм	үгүй	Бөглөөгүй	тийм	үгүй	бөглөөгүй
T3	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	0	1	4	0	1	4
MA1	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	1	1	3	1	1	3
	<u>ДҮН</u>	<u>1</u>	<u>2</u>	<u>7</u>	<u>1</u>	<u>2</u>	<u>7</u>

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Химийн бодисын менежментийн хувьд одоогоор манай улсад “Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам” маш бага хийгдсэн байна энэ нь нөгөө талаасаа салбарын онцлогоос шалтгаалсан байж болох талтай ч их бага хэмжээгээр тодорхой хэмжээний эрсдэлийг үнэлэх, шийдвэрлэх арга хэрэгслийг боловсронгуй болгох хэрэгцээ байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд том асуудлын нэг болоод байна. Хүнсний үйлдвэрийн компаниудад байгаль орчны эрсдэл болон ажлын байрны аюулгүй байдлын удирдлагад анхаарал нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

БОНЗ-ЫН ТАЙЛАГНАЛЫН АГУУЛГА, НӨХЦӨЛ БАЙДЛЫН АГУУЛГЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны ажлын хүрээнд Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын өнөөгийн байдал, хэрэгжилт, тайлагналын түвшинг тодорхойлох зорилгоор бүтэлцчилсэн асуулгын аргыг (Google form) ашиглав. Судалгааны мэдээллийг 2025 оны 4-р сарын 3-наас 2025 оны 10-р сарын 14-ны хооронд түүвэрлэн авч, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй БОНЗ-ын тайлан гаргасан компаниудын жагсаалтыг гарган, тус компаниудтай холбогдон, судалгаанд хамрагдах хүсэлтийг хүргүүлж, Монгол Улсын хэмжээнд БОНЗ-ын тайлан гаргаж буй аж ахуйн нэгжүүдийн тайланг бэлтгэж байгаа холбогдох албан тушаалтнуудыг онцлон судалгаанд хамруулсан. Хөрөнгийн биржийн сайтад байршуулсан 1,2,3 ангиллын компанийн тайлагнасан

тайлан болон нягтлан бодогч нарын төлөөллөөс нийт 78 байгууллагын төлөөлөл хамарсан. Энэхүү судалгаа Google form ашиглан асуулгын аргаар судалгаа авсан бөгөөд хамрагдсан 78 байгууллагын 69.2% нь тогтвортой байдлын тайлан гаргадаггүй бөгөөд энэ нь байгууллагуудын дотоод бодлого, стратеги болон холбогдох дүрэм, журамд БОНЗ-ын талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна. Мөн Хөрөнгийн биржийн үйл ажиллагааны шаардлагын дагуу I ангиллын компаниуд 2024 оноос эхлэн тогтвортой байдлын тайланг заавал гаргах шаардлагатай болсон нь зарим байгууллага тайлагнал хийж эхлэх нэг шалтгаан болж байгаа нь тодорхой байна. Тайлагнал гаргаж буй байгууллагуудаас харахад удирдлагын дэмжлэг, бодлого тодорхой байгаа хэдий ч сургалт, хүний нөөцийн чадавх, олон улсын стандартын хэрэгжилт зэрэг тал дээр хангалтгүй байсаар байна.

БОНЗ-ын тайлан гаргаж байгаа компанийн байгаль орчны үзүүлэлтийн тайлагналын байдалыг доорх хүснэгтэд оруулав.

Хүснэгт 11. Байгаль орчны асуудлын үнэлгээ

Асуулгын төрөл	Тоо	Эзлэх хувь	
БОНЗ-ын тайлагналын хүрээнд байгаль орчны тайлагналын байдал			
8. Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа, бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм	20	83.3%
	Үгүй	4	16.7%
9. Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Тийм	9	37.5%
	Үгүй	15	62.5%
10. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм	12	50.0%
	Үгүй	12	50.0%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Байгаль орчны үзүүлэлтээр байгууллагуудын 83,3% нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого, журамтай боловч эрсдэл үнэлэх, дасан зохицох арга хэмжээний хэрэгжилт 2023 болон 2024 оны үзүүлэлтийг авч үзвэл 37%–50%-д хүрч, практик түвшинд сул байна.

БОНЗ-ын нийгмийн хүрээнд баримталж буй бодлого зохицуулалтын хувьд доорх хүснэгтэд оруулав.

Хүснэгт 12. Нийгмийн хүрээнд , бодлогын зохицуулалт

Асуулгын төрөл	Тоо	Эзлэх хувь
3-р бүлэг: БОНЗ-ын тайлагналын хүрээнд нийгмийн хүрээнд баримталж буй бодлого, зохицуулалт		
11.Танай байгууллагад жендерийн бодлого, журам байгаа юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	19 79.2%
	Үгүй	5 20.8%
12. Танай компанид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам байгаа юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	20 83.3%
	Үгүй	4 16.7%
13. Танай компанид тогтвортой байдал болон байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам байгаа юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	18 75.0%
	Үгүй	6 25.0%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нийгмийн хүрээнд байгууллагуудын 75%–83% нь жендер, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого, тогтвортой худалдан авалтын журамтай байхад, хэрэгжилт салбар хооронд харилцан адилгүй байна.

БОНЗ-ын засаглалын хүрээнд баримталж буй бодлого зохицуулалтыг доорх хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 13. Засаглалын хүрээнд , бодлого зохицуулалт

Асуулгын төрөл	Тоо	Эзлэх хувь
4-р бүлэг: БОНЗ-ын тайлагналын хүрээнд засаглалын хүрээнд баримталж буй бодлого, зохицуулалт		
14. Танай компанид цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	18 75.0%
	Үгүй	6 25.0%
15. Танай компанид авлигын эсрэг эсвэл ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	22 91.7%
	Үгүй	2 8.3%
16. Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм	22 91.7%
	Үгүй	2 8.3%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Засаглалын хүрээнд 91% нь цөөнх хувьцаа эзэмшигчдийн эрх, авлига, ёс зүйн бодлого, дотоод хяналтын журамтай байна. Компаниуд олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг боловч БОНЗ-ын мэдээллээ нэгтгэсэн нэг тайлангаар гаргаж буй нь салбар тус бүрийн онцлог, нөлөөлөл болон эрсдэлийг нарийвчлан тусгах боломжийг хязгаарлаж, тайлагналын чанарт сөргөөр нөлөөлж байгаа учир салбар хоорондын үйл ажиллагааны нөхцөл байдал, нөлөөллийн

түвшин харилцан адилгүй тул БОНЗ-ын тайланг чиглэл тус бүрээр ангилан бие даан боловсруулж тайлагнах нь илүү зохистой бөгөөд хамтын ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээ, тогтвортой худалдан авалтын бодлого зэрэг нь дунджаас доогуур хэрэгжилттэй, стандартчилсан, тогтмол тайлагналын дадал дутагдалтай байна. Монголын хөрөнгийн биржийн компанийн БОНЗ-ын тайлагналын хэрэгжилт эхний шатанд байгаа бөгөөд дотоод зохион байгуулалт, бодлого, тайлагналын системийг бэхжүүлэх шаардлагатай байна. Эдгээрээс дүгнэхэд, Монголын байгууллагуудын БОНЗ-ын тайлагналын систем эхлэл шатандаа байгаа бөгөөд гол хүндрэл нь хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдал, мэдлэг мэдээллийн хомсдол, мэргэшсэн хүний нөөцийн дутагдал, стандартын хэрэгжилт сулд оршиж байна. Цаашид тайлагналын чанарыг сайжруулахын тулд бодлого, стандартын уялдаа, сургалт, хүний нөөцийн хөгжүүлэлт, нийгэм, байгаль орчны хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага байна.

БОНЗ-ын тайлагналын хүрээнд компаниудын хамаарлыг Логистик регрессийн загвараар нөлөөллийг тодорхойлох

Хөрөнгийн биржийн 1 (25 компани) болон 2 (44 компани) ангиллын компанийн тайланд логистик регрессийн үр дүнг хүснэгт 15-д харуулав.

Хүснэгт 15. Моделийн нийцтэй байдал

Omnibus Test of Model Coefficients				
		Chi-square	df	Sig.
Step1	Step	40.895	7	<.001
	Block	40.895	7	<.001
	Model	40.895	7	<.001

Sig (p-value)<0.05 байгаа учир судалгааны модель нь статистик бүхий ач холбогдолтой буюу модель судалгаанд тохирч байна.

Хүснэгт 16. Өгөгдлийн нийцтэй байдал

Hosmer and Lemeshow Test			
		Chi-square	Sig.
Step1		7.029	0.533

Sig (p>0.05) байгаа нь судалгаанд хамрагдсан дата нь тохиромжтой буюу нийцтэй байна.

Хүснэгт 17. Нийцлэлийг тодорхойлсон байдал

Model Summary			
		Cox & Snell R Square	Nagelkerke R Square
		-2 Log likelihood	
Step1	53.327 ^a	0.442	0.598

R=0.598 буюу загварыг 59,8 хувиар тайлбарлаж байгаа нь загварын тайлбарлах чадвар өндөр байна. Энэхүү коэффициент нь 0.1-0.3 бол дунд, 0.31= дээш бол хүчтэй загварыг тайлбарлаж байна гэсэн үг юм.

Хүснэгт 18. Хувьсагчдын ач холбогдолын үнэлгээ

		Variables in the Equation					
		B	S.E.	Wald	df	Sig.	Exp(B)
Step 1	class(1)	1.804	0.833	4.694	1	0.030	6.072
	net profit	0.000	0.000	7.148	1	0.008	1.000
	Equity	0.000	0.000	6.340	1	0.012	1.000
	TA	0.000	0.000	0.684	1	0.408	1.000
	ROA	-2.155	2.524	0.729	1	0.393	0.116
	ROE	3.558	2.167	2.696	1	0.101	35.086
	Debt Ratio	1.214	1.534	0.626	1	0.429	3.365
	Constant	-3.398	1.126	9.105	1	0.003	0.033
a. Variable(s) entered on step 1: class, net profit, Equity, TA, ROA, ROE, Debt Ratio.							

Хүснэгт 18-аас харахад компаниуд 1-р ангилалд орвол БОНЗ-ын тайлан гаргах магадлал 6.072 ($p < 0.05$) дахин нэмэгдэнэ. Net profit, equity нь статистикийн хувьд ач холбогдолтой байна. Бусад хувьсагчид нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

ДҮГНЭЛТ

Дэлхий нийтээр тогтвортой хөгжлийн тайлагнал, БОНЗ-ын мэдээллийн ил тод байдлыг шаардах хандлага нэмэгдэж байгаа ч Монгол улсад эдгээр шаардлагын хэрэгжилт сул, стандартчилсан тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. БОНЗ-ын тайланг гаргах шаардлага байгаа хэдий ч институцийн чадавх болон мэргэжлийн хүний нөөцийн дутагдал БОНЗ-ын тайлагналын чанарт нөлөөлж байна. Судалгаа хийсний үр дүнд дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд сайн дураар БОНЗ-ын тайлан бэлтгэх нь сул буюу 2022–2024 онд 19.02% нь тогтвортой байдлын тайлан гаргасан байна. 2024.01.01-ны өдрөөс 1-р ангиллын компаниуд тайлан заавал гаргана гэсэн журмын дагуу тайлагналын түвшин нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл 1-р ангиллын компаниудын 84%, 3-р ангиллын компаниуд 6.45% нь БОНЗ тайлан гаргасан байна.
2. БОНЗ тайлан нь салбар хоорондын онцлогийг тусгаагүй, бүх үйл ажиллагаагаа нэг тайланд нэгтгэн тайлагнах нь мэдээллийн нарийвчлалыг бууруулж, компанийн бодит нөлөөллийг бүрэн тусгаж чадахгүй байна. Түүнчлэн хамтын ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээ, тогтвортой худалдан авалтын бодлогын хэрэгжилт дунджаас доогуур, тогтмол тайлагнах дадал хэвшээгүй байна.
3. Асуулгын судалгаанд хамрагдсан байгууллагын 69.2% нь тогтвортой байдлын тайлан гаргадаггүй, БОНЗ-ын талаарх мэдлэг мэдээлэл, дотоод бодлого, хүний нөөцийн чадавх хангалтгүй байна.
4. Байгаль орчны бодлого баримталдаг байгууллага олон ч (83.3%), эрсдэл үнэлэх, дасан зохицох практик хэрэгжилт 37–50%-ийн хооронд сул байна. Нийгмийн бодлогын хэрэгжилт харилцан адилгүй, засаглалын хүрээнд дотоод хяналт, авлига,

ёс зүй, хувьцаа эзэмшигчдийн эрхийн талаар бодлоготой ч үр нөлөө нь тогтмол бус байна.

5. БОНЗ-ын тайлан гаргалт нь холбогдох эрх бүхий байгууллагаас гаргаж буй хууль эрх зүйн зохицуулалтаар 6 дахин нэмэгдэх магадлалтай байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд үндэслэн Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй компаниудын БОНЗ-ын тайлагналын хэрэгжилт, түвшнийг сайжруулахын тулд дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. *Удирдлагын мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх*-Байгууллагын дээд болон дунд шатны удирдлагын менежерүүдэд тогтмол сургалт, семинар зохион байгуулж, БОНЗ-ын тайлагналын ач холбогдол, олон улсын болон үндэсний стандартын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ нь тайлагналын бодлого, стратегийг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой.
2. *Мэргэжилтний чадавх, сургалтын хүртээмжийг сайжруулах*-Нягтлан бодогч болон БОНЗ-ын тайлагнал боловсруулахад оролцох мэргэжилтнүүдийг олон улсын стандартын дагуу сургалтанд хамруулах, тайлан боловсруулах аргачлалыг стандартчилж, практик жишээгээр бататгах нь мэдээллийн үнэн зөв, бодит байдал, стандартын уялдааг хангахад шаардлагатай.
3. *Байгаль орчны менежментийг хөгжүүлэх*-Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжийг үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үнэлгээний үр дүнг бодлогын түвшинд ашиглах, урьдчилан сэргийлэх, дасан зохицох арга хэмжээг системтэй хэрэгжүүлэх шаардлагатай.
4. *Нийгмийн хүртээмж, бодлогын хэрэгжилтийг сайжруулах*-Жендерийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого, журам, тогтвортой худалдан авалтын практикийг бүх салбарт тогтмол хэрэгжүүлэх. Үр дүнгийн ил тод байдлыг дээшлүүлж, компанийн нийгмийн хариуцлагыг бүрэн хэрэгжүүлэх нь чухал.
5. *Засаглал, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох*-Авлигын эсрэг болон комплаенсийн бодлого, журам, дотоод аудит, хяналтын системийг бүх байгууллагад бүрэн хэрэгжүүлж, цөөнх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, ил тод, хариуцлагатай тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай.
6. *Мэдээллийн бааз, өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлэх*-Тайлагналын мэдээллийг төвлөрүүлсэн баазад бүртгэж, бодлого, шийдвэрт ашиглах боломжийг сайжруулах. Мэдээлэл, тайлангийн стандарт, аргачлалыг нэгдсэн байдлаар боловсруулж хэрэгжүүлэх нь тайлагналын чанар, тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.
7. *Хууль, зохицуулалтын орчныг тодорхой болгох*-БОНЗ-ын тайлагналын хууль эрх зүйн орчинг тодорхой, ойлгомжтой болгож, компаниудыг дагаж мөрдөх шаардлагыг хуульчлан баталгаажуулах нь тайлагналын хэрэгжилтийг идэвхжүүлэх гол хүчин зүйл болно.
8. *Тайлан гаргагч компаниудын хувьд*- Олон чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд БОНЗ-ын мэдээллийг нэгтгэн нэг тайлангаар гаргадаг нь салбар тус бүрийн онцлог, нөлөөллийн чиглэл, эрсдэлийн түвшнийг бүрэн тусгаж чадахгүй

байгаа тул тогтвортой байдлын тайлагналын чанарыг сайжруулах зорилгоор үйл ажиллагааны чиглэл тус бүрээр ангилан, бие даасан бүтэцтэй тайлан боловсруулах зохицуулалтын аргачлалыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

9. *Зохицуулагч байгууллагын зүгээс*-Олон чиглэлт үйл ажиллагаатай компанийн тайлагналын формат, үзүүлэлт, салбар онцлог шалгуурыг нарийвчлан тодорхойлж, ангилсан тайлагналын загварыг мөрдөлтөд нэвтрүүлэх зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- IFRS Sustainability, СТОУС тогтвортой байдлыг тодруулгын стандарт (2023)
- United Nations. (2015). *Transforming our world: The 2030 agenda for sustainable development*. <https://sdgs.un.org/2030agenda>
- World Commission on Environment and Development. (1987). *Our common future*. Oxford: Oxford University Press.
- Монголын Хөрөнгийн бирж. (2024). БОНЗ тайлагналын удирдамж. Улаанбаатар: Монголын хөрөнгийн бирж
- Монгол улсын Хүнс, Хөдөө, Аж Ахуйн Яам (2025). Хүнс, Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нарт зориулсан: Хүнсний салбарын БОНЗ-ын үнэлгээний удирдамж
- Монголын Хөрөнгийн бирж. (2022). Монгол компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт удирдамж, Улаанбаатар: Монголын Хөрөнгийн Бирж
- Нямаа,Д., Баярчимэг,Н. (2022). БОНЗ, тогтвортой байдлын тайлангийн баталгаажуулалтын арга зүйн асуудал. Улаанбаатар: МУИС
- Дугармаа, Б.(2022). БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах замаар хувьцааны үнэлгээг нэмэгдүүлэх нь: Уул уурхайн салбарын жишээн дээр Улаанбаатар: СЭЗИС
- Төр-Эрдэнэ, Б.(2023). Хувь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтанд БОНЗ-ын үнэлгээ нөлөөлөх нь /Нээлттэй Компаниудын жишээн дээр/ Улаанбаатар: МУИС
- Food and Agriculture Organization of the United Nations (FAO).(2023).Rome: FAO
- SAFA.(2014).SAFA Guidelines for Sustainability Assessment of Food and Agriculture Systems. Rome: Food and Agriculture Organization of the United Nations (FAO)
- Eccles, R. G., Ioannou, I., & Serafeim, G. (2014). The impact of corporate sustainability on organizational processes and performance. *Management Science*, 60(11), 2835–2857.
- European Commission. (2022). *Corporate sustainability reporting directive (CSRD)*. https://finance.ec.europa.eu/capital-markets-union-and-financial-markets/company-reporting-and-auditing/company-reporting/corporate-sustainability-reporting_en
- Freeman, R. E. (1984). *Strategic management: A stakeholder approach*. Boston: Pitman.
- IFRS Foundation. (2023). *ISSB standards: IFRS S1 and IFRS S2*. <https://www.ifrs.org/issued-standards/issb-standards/>
- UN Global Compact. (2000). *The ten principles of the UN Global Compact*. <https://www.unglobalcompact.org/what-is-gc/mission/principles>

UNEP FI. (2004). *Who cares wins: Connecting financial markets to a changing world*.
<https://www.unepfi.org/publications/who-cares-wins-2004/>

UNPRI. (2006). *Principles for responsible investment*. <https://www.unpri.org>

Вэбсайт: <https://www.sasb.org/standards/materials/>

SASB Materiality Map, 2022

Вэбсайт: <https://www.sasb.org/standards/materiality-map/>

IFRS Foundation & SASB Integration (2021) – ESG тайлагналын стандартуудын холболт.

RI албан ёсны сайт: <https://www.globalreporting.org>

GRI Standards (татаж авах): <https://www.globalreporting.org/standards>

International Integrated Reporting Council (IIRC), одоо IFRS Foundation – Integrated Reporting Framework: <https://www.integratedreporting.org>

ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН АВТО МАШИН ХУДАЛДАН АВАХ ХҮСЭЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Г.Алдаржав^{1a}, Ц.Номин^{2b}

¹ Мандах Их Сургууль, “Бизнесийн удирдлага” хөтөлбөрийн магистрант

² Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, ахлах багш, Ph.D

^aba24e002@mandakh.edu.mn

^bnomin@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Дэлхийн дулаарлын эсрэг хариу арга хэмжээний нэг болох агаарлын бохирдлыг бууруулахад нүүрсхүчлийн хий CO₂ ялгаралд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлж буй цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх асуудал нь бодлого боловсруулагчид болон мэргэжилтнүүдийн анхаарлыг ихээхэн татах болсон.

Иймээс энэхүү судалгааны зорилго нь Улаанбаатар хотын хэрэглэгчдийн цахилгаан автомашин (EV) худалдан авах эрмэлзэлд нөлөөлж буй хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг судалж, энэ хүрээнд хэрэглэгчийн зан төлөвийг тодорхойлон маркетингийн мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид болон академик судлаачдад зөвлөмж боловсруулахад оршино.

Анхдагч өгөгдлийг туршилт судалгааны аргаар microsoft forms ашиглан цуглуулж (N= 389), SPSS 21.0 статистик программыг ашиглан хүчин зүйлийн шинжилгээ, найдвартай байдлын шинжилгээ болон регрессийн шинжилгээг гүйцэтгэв.

Хүрээлэн буй орчны талаарх санаа зовнил, мэдлэг, ухамсар хувьсагчдыг шинжилж үзэхэд хүрээлэн буй орчны талаарх санаа зовнил, мэдлэг, ухамсар, бүтээгдэхүүний үнийн мэдрэмж, технологийн дэвшил, чанар, төрийн бодлогын дэмжлэг, дэд бүтцийн хүртээмж, нийгмийн нөлөөлөл хувьсагчдыг шинжилж үзэхэд төрийн бодлого болон бүтээгдэхүүний чанар нь худалдан авах эрмэлзэлд хамгийн хүчтэй нөлөөллийг үзүүлэв. Брэндийн итгэл хувьсагчийн зохицуулах нөлөөг шалгахад итгэл өндөртэй брэндэд итгэл багатайтай харьцуулахад худалдан авах эрмэлзэлд үзүүлэх нөлөөлөл өндөр байсан.

Иймд цахилгаан автомашины зах зээлд нэвтрүүлэх бодлого, хэрэглэгчийн танин мэдэхүйн түвшнийг дээшлүүлэх маркетингийн стратеги боловсруулахдаа зан төлөвийн болон төрийн бодлогын хөшүүргүүдийг онцгойлон авч үзэх нь чухал болохыг судалгааны үр дүн харуулж байна.

ТҮЛХҮҮР ҮГ: Цахилгаан автомашин, Худалдан авах эрмэлзэл, Брэндийн итгэл

ОРШИЛ

21-р зуунд дэлхий дахинд тулгарч буй томоохон сорилтуудын нэг нь уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өсөлт болон агаарын бохирдлын асуудал болоод байна. Олон улсын эрчим хүчний агентлагийн мэдээлснээр дэлхийн нийт CO₂ ялгарлын 23 хувийг тээврийн салбар дангаараа бүрдүүлдэг бөгөөд үүний дийлэнхийг дотоод шаталтат хөдөлгүүртэй автомашинууд эзэлдэг гэж тайлагнажээ. (Intergovernmental Panel on Climate Change (IPCC), 2022) Тээврийн салбарын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах хамгийн үр дүнтэй арга замын нэг нь цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх явдал гэж судлаачид ч мөн онцолж байна. (Bigerna, 2018)

Монгол Улсын хувьд Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн автомашины тоон өсөлт, үүнийг дагасан агаарын бохирдол, импортын шатахууны өндөр хамааралтай байдал зэрэг асуудлууд сүүлийн жилүүдэд яахын аргагүй анхаарах асуудал болоод байна. 2024 оны байдлаар Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 750 мянга давж, улсын хэмжээнд нийт тээврийн хэрэгслийн 60 хувийг эзэлж байна гэсэн судалгаа байна (Авто тээврийн үндэсний төв, 2024). Үүний зэрэгцээ нийслэлийн PM2.5 тоосонцрын дундаж хэмжээ ДЭМБ-ын зөвлөмжөөс найм дахин өндөр байгаа нь хүн амын эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулсаар байна (IQAir, 2024). Тиймээс тээврийн салбарт ногоон шилжилт хийх, цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх нь сүүлийн жилүүдэд үндэсний хэмжээний бодлогын асуудал болж буйг харуулна.

Цахилгаан автомашины дэлхийн зах зээл сүүлийн арван жилд огцом хөгжиж 2023 онд 14 сая гаруй EV буюу цахилгаан автомашин борлогдсон нь шинэ автомашины нийт борлуулалтын 18 хувийг эзэлж байна (International Energy Agency (IEA), 2024). EV технологийн хөгжлийн гол түлхүүр болсон литийн ион аккумуляторын үнэ 2010 оноос хойш 89 хувиар буурсан нь хэрэглэгчийн худалдан авах хандлагыг хурдасгаж зах зээлийн өрсөлдөх чадварыг эрс нэмэгдүүлжээ. (BloombergNEF, 2024) Харин Монгол Улсад 2024 оны байдлаар 2600 орчим цахилгаан автомашин бүртгэлтэй бөгөөд жил бүр энэхүү тоо 40-50 хувийн өсөлттэй байхаар байна (Зам тээврийн хөгжлийн яам, 2024). Энэ нь хэрэглэгчийн цахилгаан автомашинд хандах хэрэглэгчийн хандлагад суурилсан судалгааг академик түвшинд шинжлэх шаардлагыг бий болгож байна.

Хэрэглэгчийн зан төлөв, шинэ технологийг хүлээн авахад нөлөөлөх хүчин зүйлсийн тухай судалгаанд олон онолын загвар өргөн хэрэглэгддэг. Үүнд Reasoned Action Theory (Fishbein, 1975), Theory of Planned Behavior (Ajzen I., 1991), Technology Acceptance Model (Davis, 1989) зэрэг нь хэрэглэгчийн хандлага, хүлээлт, нийгмийн нөлөөлөл, ашигтай байдлын ойлголт нь тэдний зан төлөвт хэрхэн нөлөөлдгийг тайлбарладаг. EV судалгааны олон улсын чиг хандлагад мэдрэгдсэн ашигтай байдал, хүрээлэн буй орчны санаа зовнил, технологийн дэвшил, бодлогын дэмжлэг, цэнэглэх дэд бүтэц зэрэг хувьсагчид нь хэрэглэгчийн хандлага болон худалдан авах хүсэлд хүчтэй нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг. (Rezvani Z. J., 2015) (Hardman, 2021)

Монголын нөхцөлд цахилгаан автомашин худалдан авах зан төлөвийг бүхэлд нь хамарсан, олон талт онолын загварт тулгуурласан судалгаа ховор байгаа нь энэхүү

судалгааны ажлын шинэлэг болон практик ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Тухайлбал Монгол Улсад хэрэглэгчийн байгаль орчны талаарх санаа зовнил (environmental Concern), байгаль орчны талаарх мэдлэг (environmental Knowledge), байгаль орчны талаарх ухамсар (Environmental Awareness), бүтээгдэхүүний үнийн мэдрэмж (Price Sensitivity), бүтээгдэхүүний технологийн дэвшил (Technological Advancement), бүтээгдэхүүний чанартай байдал (Product Quality), нийгмийн нөлөөлөл (Social Influence), төрийн бодлогын дэмжлэг (Policy Support), дэд бүтэц (Charging Infrastructure), мэдрэгдсэн ашигтай байдал (Мэдрэгдсэн ашигтай байдал), хэрэглэгчийн хандлага (Attitude toward EVs) мөн брэндийн итгэл зэрэг олон хувьсагч нь хэрэглэгчийн цахилгаан автомашин худалдан авах эрмэлзэлд (Purchase Intention) хэрхэн нөлөөлдөг талаар бүхэлд нь уялдаа холбоотойгоор задлан шинжилсэн судалгаа маш цөөн байдаг. Иймээс эдгээр хүчин зүйлсийг TRA, TPB, TAM онолуудын хүрээнд нэг загварт нэгтгэн үнэлэх нь судалгааны хувьд шинэлэг бөгөөд бодит хэрэглээнд өндөр ач холбогдолтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Улаанбаатар хотын хэрэглэгчдийн цахилгаан автомашин (EV) худалдан авах эрмэлзэлд нөлөөлж буй хүрээлэн буй орчны, бүтээгдэхүүний болон гадаад орчны хүчин зүйлсийг судалж зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилт

Энэхүү судалгааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлэв:

1. Хэрэглэгчдийн худалдан авах зан төлөвийн онол, загваруудыг судлах.
2. Цахилгаан автомашины худалдан авах зан төлөвтэй холбоотой гадаад болон дотоодын эх сурвалжуудыг нэгтгэн судлах.
3. Туршилт судалгаанд үндэслэн худалдан авах зан төлөвт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох.
4. Судалгааны үр дүнд үндэслэн практикийн мэргэжилтнүүд, академик судлаачид болон бодлого боловсруулагчдад зөвлөмж боловсруулах.

Судлагдсан байдал

Монгол хэрэглэгчийн (У.Энхжин, 2024) байгальд ээлтэй хэрэглээний хандлагын шинжилгээ, (Г.Отгонбаяр, 2023) ногоон хэрэглээний зан төлөвийн судалгаа, мөн Б.Мөнхжаргал (2022), Ц.Даваасүрэн (2021), Б. Эрдэнэтуяа (2020) нарын цахилгаан автомашины хэрэглээ, бодлого, технологийн хүлээн зөвшөөрөлтийн чиглэлийн бүтээлүүдэд TPB, TRA, TAM загваруудыг ашиглан хэрэглэгчийн хандлага болон худалдан авах зан төлөвийг тайлбарлахад ашиглажээ. Эдгээр судалгаануудын үр дүнгээр байгаль орчны ухамсар, санаа зовнил, нийгмийн нөлөөлөл зэрэг сэтгэлзүйн хүчин зүйлс нь цахилгаан автомашин болон байгальд ээлтэй бүтээгдэхүүнд хандах хандлагад хүчтэй нөлөөлдөг болохыг тогтоосон бол үнэ, технологи, баталгаат хугацаа, дэд бүтцийн хүртээмжийн нөлөөлөл харилцан адилгүй, зарим тохиолдолд сул илэрсэн байна.

Б.Мөнхжаргал (2022), Б.Эрдэнэтуяа (2020) нарын судалгаанд төрийн бодлогын дэмжлэг, мэдээллийн хүртээмж болон хэрэглээний туршлага хангалтгүй байгаагаас цахилгаан автомашин хэрэглээний өсөлт удаашралтай байгааг тэмдэглэсэн нь гадаад орчны хүчин зүйлсийг илүү гүнзгий авч үзэх шаардлагыг харуулж байна. Иймээс судлаачийн зүгээс дээрх судалгааны үр дүнг нэгтгэн, хүрээлэн буй орчны хүчин зүйлс, бүтээгдэхүүний шинж чанар, нийгмийн нөлөөлөл, төрийн бодлогын дэмжлэг болон брэндийн итгэлийн зохицуулах үүргийг хамтад нь авч үзэн нэгтгэсэн судалгааны загвар үүсгэснээр энэ төрлийн судалгаанд өмнө нь хийгдээгүй орон зайг нөхөж, цахилгаан автомашин худалдан авах хандлагыг илүү иж бүрэн тайлбарлахыг зорьсон болно.

Олон улсын түвшинд цахилгаан автомашин худалдан авах зан төлөвийг тайлбарлах үндсэн хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлсон байдаг. Buhmann (2024) ба Hasan (2024)-ийн судалгаанууд байгаль орчны итгэл үнэмшил, санаа зовнил болон үнэ, үр ашгийн үнэлгээ нь хэрэглэгчийн хандлага, худалдан авах эрмэлзэлд хүчтэй нөлөөлдөг болохыг нотолсон ба тус судалгаанд хүрээлэн буй орчны хувьсагчдыг тусгайлан авч үзэх онолын үндэс болж байна. Харин технологийн дэвшил, бүтээгдэхүүний чанар нь хандлагад хамгийн гол нөлөөлөгч болохыг илрүүлсэн нь судалгаанд бүтээгдэхүүний шинж чанарын хувьсагчийг багтаах шаардлагыг баталгаажуулсан (Sun, 2024). Мөн Guo (2023) ба Rahi (2021)-ийн судалгаанууд төрийн бодлого, брэндийн итгэл зэрэг гадаад болон сэтгэлзүйн нөлөөллүүд худалдан авах эрмэлзэлд шууд болон зуучлах хэлбэрээр нөлөөлдөг болохыг харуулсан нь энэхүү судалгаанд төрийн бодлогын дэмжлэг болон брэндийн итгэлийн хувьсагчийн зохицуулах үүргийг тусгах ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

Судалгааны таамаглал

Өмнөх судалгааны үр дүнд тулгуурлан дараах таамаглалуудыг дэвшүүлэв.

- Таамаглал 1. Хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн худалдан авах хүсэлд үзүүлэх нөлөө
- H1a. Хүрээлэн буй орчны талаарх хэрэглэгчийн санаа зовнил өндөр байх нь цахилгаан автомашиныг ашигтай гэж үзэх ойлголтод эерэгээр нөлөөлнө.
 - H1b. Хэрэглэгчийн хүрээлэн буй орчны талаарх мэдлэг өндөр байх нь цахилгаан автомашиныг ашигтай гэж үзэх ойлголтод эерэгээр нөлөөлнө.
 - H1c. Хэрэглэгчийн хүрээлэн буй орчны талаарх ухамсар өндөр байх нь EV-ийн мэдрэгдсэн ашигтай байдалд эерэгээр нөлөөлнө.
- Таамаглал 2. Бүтээгдэхүүний шинж чанарын худалдан авах хүсэлд үзүүлэх нөлөөлөл
- H2a. Бүтээгдэхүүний үнийн мэдрэмж эерэг байх нь EV-ийн мэдрэгдсэн ашигтай байдалд эерэгээр нөлөөлнө.
 - H2b. Цахилгаан автомашины технологийн дэвшил өндөр байх нь хэрэглэгчийн мэдрэгдсэн ашигтай байдалд эерэгээр нөлөөлнө.
 - H2c. Бүтээгдэхүүний чанартай байдал мэдрэгдсэн ашигтай байдалд эерэгээр нөлөөлнө.
- Таамаглал H3. Гадаад орчны хүчин зүйлс
- H3a. Нийгмийн нөлөөлөл эерэг байх нь цахилгаан автомашиныг ашигтай гэж үзэх ойлголтод эерэгээр нөлөөлнө.

НЗб. Төрийн бодлогын дэмжлэг (дугаарын хязгаарлалт, татварын чөлөөлөлт, урамшуулал) EV-ийг ашигтай гэж үзэх ойлголтод эерэгээр нөлөөлнө.

НЗс. EV-ийн цэнэглэх дэд бүтэц хангалттай гэж үзэх нь мэдрэгдсэн ашигтай байдалд эерэгээр нөлөөлнө.

Таамаглал 4. Мэдрэгдсэн ашигтай байдал

Н4. Цахилгаан автомашиныг ашигтай гэж мэдрэх нь хэрэглэгчийн цахилгаан автомашинд хандах хандлагад эерэгээр нөлөөлнө.

Таамаглал 5. Хандлага

Н5. Цахилгаан автомашинд хандах хэрэглэгчийн эерэг хандлага нь худалдан авах эрмэлзэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал 6 а,б, Брэндэд итгэх итгэлийн зохицуулах нөлөөлөл

Н6 а.б Цахилгаан автомашины брэндийн итгэлтэй байдал нь хэрэглэгчийн мэдрэгдсэн ашигтай байдал болон хандлагад зуучлах (moderating) нөлөө үзүүлнэ.

Хэрэглэгч тухайн брэндийг итгэлтэй гэж үзвэл хандлагын нөлөө илүү хүчтэй болж, худалдан авах эрмэлзэл нэмэгддэг (McKnight et al., 2002; Gefen et al., 2003).

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд Улаанбаатар хотод цахилгаан автомашин өмнө нь худалдан авч байсан эсвэл худалдан авах сонирхолтой байгаа жолоо барих эрх бүхий үнэмлэхтэй Монгол улсын 389 иргэн хамрагдсан бөгөөд тоон өгөгдлийг Microsoft forms ашиглан онлайн болон биет байдлаар, лайкерт шкалын 5 шатлал бүхий бүтэцжүүлсэн асуулгыг ашиглан цуглуулсан.

Зохицуулагч хувьсагчийн хүрээнд 200, 189 бүхий 2 удаа бүлэг хооронд судалгаа авсан бөгөөд судалгааны асуулгыг өмнө нь хийгдэж байсан болон амжилттай болсон судалгаанаас түүвэрлэн Монгол хэл рүү академик түвшинд хөрвүүлэн холбогдох нэмэлт утга агуулгын найруулгыг хийсний дараа авч ашиглах замаар энэхүү судалгааны ажлын хувьсагчдыг хэмжсэн. Үүнд хэмжүүрийн хүчин төгөлдөр байдлыг КМО ба Bartlett's Test ашиглан үнэлж, өгөгдөл хүчин зүйлийн шинжилгээнд тохиромжтой эсэхийг шалгав. Үүний дараа Exploratory Factor Analysis (EFA) ашиглан хувьсагчдын хүчин зүйлийн бүтцийг тодорхойлж, дотоод найдвартай байдлыг Cronbach's Alpha, нийлмэл найдвартай байдлыг CR, тус бүрийн баталгааг AVE үзүүлэлтээр үнэлсэн.

Хувьсагчдын хоорондын шалтгаант хамаарлыг тодорхойлохын тулд олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээ (Multiple Linear Regression) ашигласан.

$$Y = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_n X_n + \varepsilon \quad [1]$$

Энд Y- хамааралтай хувьсагч, X- үл хамаарах хувьсагчид, β - коэффициент, ε - санамсаргүй алдаа. Загварын тайлбарлах чадварыг R^2 , нөлөөллийн хүчийг standardized beta coefficient (β), статистик ач холбогдлыг p-value-ээр үнэлэв.

Мөн зохицуулагч хувьсагчийн нөлөөллийг мэдрэгдсэн ашигтай байдлаас хандлага руу, хандлагаас худалдан авах эрмэлзэл рүү шугаман регрессийн шинжилгээг хийж үнэлсэн.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Судалгаанд ашигласан хувьсагчдыг үнэлэх зорилгоор хүчин зүйлийн шинжилгээ (Exploratory Factor Analysis, EFA) болон найдвартай байдлын шалгуур үзүүлэлтүүд болох Cronbach's Alpha, Composite Reliability (CR), Average Variance Extracted (AVE)-ийг SPSS 21.0 программыг ашиглан тооцоолж баталгаажуулсан. Асуулгын анхан шатны тохиромжтой байдлыг үнэлэх үүднээс Kaiser-Meyer-Olkin (КМО) хэмжигдэхүүнийг тооцоход 0.810 гэсэн утга гарсан нь Kaiser (1974)-ийн ангиллаар “маш сайн” түвшинд хамаарах бөгөөд судалгааны өгөгдөл хүчин зүйлсийн шинжилгээ хийхэд бүрэн тохирч байгааг илтгэнэ. Үүнтэй уялдан Bartlett's Test of Sphericity статистик шинжилгээ $p < 0.001$ утгатай гарсан нь хувьсагчдын хоорондын хамаарал санамсаргүй бус бөгөөд хүчин зүйлсийн бүтэц илрүүлэхэд шаардлагатай корреляцын матрицын нөхцөл хангагдсан болохыг нотолж байна. Иймд өгөгдлийн бүтэц хүчин зүйлсийн шинжилгээ хийх онол-статистикийн шаардлагыг хангаж буй гэж үзэх нь зүйтэй.

Хэмжүүрийн хүчин зүйл тус бүрийн фактор ачаалал (factor loading) 0.804–0.958-ийн интервалд гарсан нь (Hair et al., 2019) дэвшүүлсэн ≥ 0.70 гэсэн босгыг бүх талаараа давж байгаа бөгөөд судалгааны хэмжүүрүүд тухайн далд хувьсагчдыг өндөр нарийвчлалтайгаар илэрхийлж, нэгэн жигд ойлголтын хүрээнд хэмжиж байгааг харуулж байна. Онолын хувьд фактор ачаалал 0.7–0.8 бол “хангалттай сайн”, 0.8–0.9 бол “маш сайн”, 0.9 ба түүнээс дээш тохиолдолд “онцгой сайн” үзүүлэлт гэж үнэлдэг. Үүнтэй харгалзан үзвэл уг судалгаанд ашигласан бүх хэмжүүрүүд тухайн нэгдсэн хүчин зүйлтэйгээ өндөр уялдаа холбоотой бөгөөд хэмжилтийн алдаа бага байна гэж үзэж болно.

Нэг чиглэлийн хүчин төгөлдөр байдлыг (convergent validity) баталгаажуулах зорилгоор тооцсон AVE нь бүх хувьсагчдын хувьд 0.651–0.904-ийн интервалд багтсан нь Fornell & Larcker (1981)-ийн ≥ 0.50 гэсэн шаардлагыг үлэмж давсан үзүүлэлт юм. Энэ нь тухайн хувьсагчдыг бүрдүүлэгч ажиглагдсан хувьсагчид (indicators) өөрийн далд хувьсагчийн тайлбарлах чадвар өндөр бөгөөд тухайн ойлголтыг статистикийн хувьд найдвартай нэгэн чиглэлд хэмжиж байгааг батална. Нөгөө талаас AVE өндөр байх нь хэмжүүр бүр тухайн ойлголтын үндсэн шинж чанарыг баримжаалж, хэмжилтийн загварын хүрээнд дотоод нэг төрлийн чанар (homogeneity) сайн байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

Нийлмэл найдвартай байдлын индекс (Composite Reliability, CR) нь 0.867–0.966-ийн интервалд гарсан нь ≥ 0.70 гэсэн хүлээн зөвшөөрөгдөх доод босгыг даваад зогсохгүй олон улсын стандартаар “маш өндөр найдвартай” түвшинд хүрснийг илтгэнэ. CR-ийн утга өндөр байх нь хэмжүүрүүд хоорондоо логик ба статистикийн хувьд туйлын уялдаа холбоотой, тогтвортой бөгөөд тухайн далд хувьсагчийг найдвартай хэмжиж байгааг нотолдог. Иймд судалгааны хэмжүүрүүд дотоод нийцтэй чанарын шаардлагыг бүрэн хангаж байна.

Cronbach's Alpha нь 0.865–0.966 хооронд гарсан нь Nunnally & Bernstein (1978)-ийн ≥ 0.70 гэсэн онолын шаардлагыг бүх талаараа давж, хэмжүүрүүдийн дотоод найдвартай байдал “маш сайн” түвшинд байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл

судалгааны асуулган дахь хэмжүүрүүд нь хоорондоо уялдаа холбоотой, тогтвортой, нэг ойлголтыг тууштай хэмжиж чаддаг болохыг нотолж байна.

Хүснэгт 1. Хувьсагчдын найдвартай байдлын шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Шалгуур утга	Судалгааны үр дүн
Фактор ачаалал	≥ 0.70	0.751–0.953
AVE	≥ 0.50	0.651–0.904
CR	≥ 0.70	0.867–0.966
Cronbach Alpha	≥ 0.70	0.865–0.966

Эдгээр үзүүлэлтүүд нь статистикийн хувьд найдвартай, дараагийн үе шатны шинжилгээнд бэлэн болсон болохыг баталж байна.

Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ

Хувьсагчдын хоорондын боломжит шалтгаант хамаарлыг илрүүлэх, нөлөөллийн чиглэл болон статистикийн ач холбогдлыг тодорхойлох зорилгоор регрессийн шинжилгээг гүйцэтгэлээ.

Хүснэгт 2. Регрессийн шинжилгээний үр дүнгийн нэгтгэл

Нөлөөлөл	Стандартчиллагдсан Beta	t value	p value	Таамаглал
Хүрээлэн буй орчны талаарх санаа зовнил → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.641***	16.43	0.000	Дэмжигдсэн
Хүрээлэн буй орчны талаарх мэдлэг → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.524***	12.117	0.000	Дэмжигдсэн
Хүрээлэн буй орчны талаарх ухамсар → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.536***	12.483	0.000	Дэмжигдсэн
Бүтээгдэхүүний үнийн мэдрэмж → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.670***	17.742	0.000	Дэмжигдсэн
Бүтээгдэхүүний технологийн дэвшил → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.564***	13.427	0.000	Дэмжигдсэн
Бүтээгдэхүүний чанартай байдал → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.688***	18.662	0.000	Дэмжигдсэн
Нийгмийн нөлөө → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.674***	17.962	0.000	Дэмжигдсэн
Төрийн бодлого дэмжлэг → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.707***	19.681	0.000	Дэмжигдсэн
Дэд бүтэц → Мэдрэгдсэн ашигтай байдал	0.642***	16.488	0.000	Дэмжигдсэн

Мэдрэгдсэн ашигтай байдал → Хэрэглэгчийн хандлага	0.738***	21.546	0.000	Дэмжигдсэн
Хэрэглэгчийн хандлага → Худалдан авах эрмэлзэл	0.826***	28.812	0.000	Дэмжигдсэн

Байгаль орчны хүчин зүйлс - Мэдрэгдсэн ашигтай байдалд үзүүлэх нөлөө

Регрессийн шинжилгээний үр дүнд байгаль орчны гурван хүчин зүйл бүгд мэдрэгдсэн ашигтай байдалд статистикийн өндөр ач холбогдолтой эерэг нөлөө үзүүлж буй нь батлагдлаа.

Эдгээр үр дүн нь байгаль орчны доройтол, агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг илүү өндөр түвшинд ухамсарладаг хэрэглэгчид цахилгаан автомашиныг илүү ач холбогдолтой, үнэ цэнтэй шийдэл гэж хүлээн авах хандлагатай болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, экологийн асуудлын талаарх хэрэглэгчийн сэтгэл хөдлөл болон мэдлэгийн цар хүрээ өргөжих тусам EV технологийн ашиг тусыг үнэлэх үнэлгээ эрс нэмэгдэж байна. Эдгээр дүн нь байгаль орчны талаарх үзэл санаа нь хэрэглэгчийн шинэ технологи хүлээн зөвшөөрөхөд нөлөөлдөг гэсэн олон улсын судалгааны (Kollmuss & Agyeman, 2002) чиг хандлагатай бүрэн нийцэж байна.

Бүтээгдэхүүний шинж чанарын хүчин зүйлс - Мэдрэгдсэн ашигтай байдалд үзүүлэх нөлөө

Product Attribute Theory (Olson & Jacoby, 1972) болон Perceived Value Theory (Zeithaml, 1988)-ийн дагуу хэрэглэгч бүтээгдэхүүний үнэ, чанар, технологийн түвшинг хэрхэн үнэлж байгаа нь мэдрэгдсэн ашигтай байдал буюу ашигтай байдлын үнэлгээнд шууд нөлөөлдөг. Судалгааны статистик үр дүн энэ онолын хүлээлтийг бүрэн бататгав.

Эдгээр коэффициент нь бүтээгдэхүүний бодит шинж чанар болон хэрэглэгчийн ашиг тусын ойлголт хоорондын уялдаа маш хүчтэй болохыг харуулж байна. Тухайлбал: EV-ийн ашиглалтын зардал бага, технологийн инноваци өндөр, чанар, найдвартай байдал өндөр байх нь хэрэглэгчийн хувьд бүтээгдэхүүнийг илүү үр ашигтай гэж хүлээн зөвшөөрөх үндсэн шалгуур болж байна. Энэ нь цахилгаан автомашины эдийн засаг, материаллаг болон технологийн давуу талууд хэрэглэгчийн PU-ийн үнэлгээнд хүчтэй нөлөөлдөг болохыг нотолж Perceived Benefit болон Perceived Value онолуудтай бүрэн уялдаж байна.

Гадаад орчны хүчин зүйлс - Мэдрэгдсэн ашигтай байдалд үзүүлэх нөлөө

Theory of Planned Behavior (Ajzen I. , 1991) болон Subjective Norms-ийн онолоор хэрэглэгчийн зан төлөвийг зөвхөн хувь хүний үнэлгээ бус, нийгмийн орчин, төрийн бодлого, дэд бүтцийн хүртээмж зэрэг гадаад хүчин зүйлс хүчтэй тодорхойлдог гэж үздэг. Үр дүнгээс харахад бүх гадаад хүчин зүйлс PU-д статистикийн хувьд ач холбогдолтой эерэг нөлөөтэй байна. Эдгээр үр дүн нь Монгол Улсын нөхцөлд EV-ийн хүлээн зөвшөөрөл нь макро түвшний бодлого, дэд бүтэц, нийгмийн орчны нөлөөллөөс маш их хамаардаг болохыг харуулж байна.

Татварын хөнгөлөлт, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх зэрэг төрийн бодлогоос бий болсон эдийн засгийн давуу тал, цэнэглэх станцуудын хүртээмж, олон нийтийн эерэг хэвшмэл ойлголт, зөвлөмж, нийгмийн дэмжлэг зэрэг нь EV-ийн ашигтай байдлын талаарх хэрэглэгчийн үнэлгээг бодитойгоор сайжруулж байна. Төрийн бодлогын нөлөө хамгийн өндөр гарсан нь хэрэглэгчийн шийдвэр гаргалтад төрийн оролцоо хамгийн хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл болж буйг илтгэж байна.

Мэдрэгдсэн ашигтай байдал - Хэрэглэгчийн хандлагад үзүүлэх нөлөө

Технологийг хүлээн зөвшөөрөх загвар (Davis, 1989)-ийн онолд хэрэглэгчийн бүтээгдэхүүн, технологийг ашиглах бодит хандлага нь мэдрэгдсэн ашигтай байдлын үнэлгээнээс үндсэндээ тодорхойлогддог гэж үздэг. Судалгааны үр дүн энэхүү онолын суурь хүлээлтийг бүрэн бататгав.

Мэдрэгдсэн ашигтай байдал $\rightarrow$ Хандлага ($\beta = 0.738$, $p = 0.000$) гэсэн өндөр коэффициент гарсан нь хэрэглэгч EV технологиас эдийн засгийн, экологийн болон хэрэглээний бодит ашиг хүртэнэ гэж хүлээн зөвшөөрөх тусам цахилгаан автомашинтай холбоотой ерөнхий хандлага хүчтэй сайжирдаг болохыг харуулж байна.

Энэхүү үр дүн нь ТАМ загварын төв ойлголт болох “usefulness is the primary driver of attitude formation” гэсэн зарчимтай бүрэн нийцэж, цахилгаан автомашины хэрэглээний үр ашиг нь хэрэглэгчийн эерэг хандлагын үндсэн детерминант болохыг нотолж байна. Мөн байгаль орчинд ээлтэй технологид өгч буй нийгмийн үнэлгээ өсөж буй өнөөгийн нөхцөлд мэдрэгдсэн ашигтай байдал нь технологийн инновацийг хүлээн зөвшөөрөх сэтгэлзүйн механизмд улам бүр чухал байр суурь эзэлж буйг харуулж байна.

Хэрэглэгчийн хандлага - Худалдан авах эрмэлзэлд үзүүлэх нөлөө

Theory of Planned Behavior (Ajzen I. , 1991)-ийн дагуу хандлага нь зан төлөвийн эрмэлзлийг тодорхойлох цөм хувьсагчдын нэг бөгөөд технологи хүлээн зөвшөөрөх судалгаанд хамгийн хүчтэй детерминант гэж үзэгддэг. Энэхүү онолын суурь зарчим манай эмпирик үр дүнтэй бүрэн давхцаж байна.

Хандлага $\rightarrow$ Худалдан авах эрмэлзэл ($\beta = 0.826$, $p = 0.000$) гэсэн маш өндөр коэффициент нь цахилгаан автомашинд эерэг сэтгэлгээтэй, түүний үнэ цэнэ, үр ашгийг хүлээн зөвшөөрсөн хэрэглэгчид бодит худалдан авалтын зан төлөвийг илүү өндөр магадлалтайгаар илэрхийлдэг болохыг харуулж байна.

Энэ нь хэрэглэгч цахилгаан автомашиныг ашигтай, найдвартай, эрсдэл багатай, нийгэм-байгаль орчинд эерэг нөлөөтэй гэж үзэх тусам худалдан авах шийдвэр гаргах эрмэлзэл төдий чинээ нэмэгддэг гэдгийг нотолж байна. Олон улсын судалгаанд EV adoption intention-ийн хамгийн хүчтэй тодорхойлогч нь attitude байдаг тухай тогтмол тайлагддаг бөгөөд (Rezvani et al., 2015) энэхүү судалгааны үр дүн уг чиг хандлагыг Монголын нөхцөлд баталгаажууллаа.

Зохицуулагч хувьсагчийн нөлөөллийн шинжилгээ

Судалгаанд нийт 389 оролцогч хамарсан туршилт судалгааг явуулав. Брэндэд итгэх итгэлийн түвшнээр хоёр бүлэгт ангилан Монгол улсын зах зээлд анхдагч бөг (Solin Motors = 200; BYD = 189) олон бүлгийн регрессийн шинжилгээ хийж, брэндийн итгэлцэл нь загварын гол шалтгаант хамаарлуудыг хэрхэн зохицуулж буйг шалгав. Брэндэд итгэх итгэл нь хэрэглэгчийн технологийн хүлээн зөвшөөрөлтөд төв байр суурь эзэлдэг бөгөөд хэрэглэгчийн бүтээгдэхүүнд хандах үнэлгээний итгэлцлийн механизмын нэг хэлбэр гэж олон судлаач тодорхойлдог (Gefen et al., 2003; Pavlou, 2003). Иймээс хүлээн зөвшөөрлийн загваруудын (ТАМ, ТРВ) уламжлалт хамаарлууд нь брэндийн итгэлцлийн түвшнээс шалтгаалан харилцан адилгүй хүчээр илрэх боломжтой гэж үзэх нь онолын үндэслэлтэй гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Шинжилгээний үр дүнгээс харахад мэдрэгдсэн ашигтай байдлын хандлагад үзүүлэх нөлөө хоёр бүлгийн хооронд мэдэгдэхүйц ялгаатай байв. Итгэлцэл өндөртэй брэнд болох BYD-ийн хувьд стандартчилсан коэффициент $\beta = 0.814$ ($p < 0.001$) гарсан бол итгэлцэл багатай Solin Motors-ийн хувьд $\beta = 0.647$ ($p < 0.001$) болж илэрсэн нь итгэлцлийн түвшин нэмэгдэхийн хэрээр хэрэглэгч бүтээгдэхүүний ашигтай чанарыг илүү найдвартай, бодитой үнэлдэг гэсэн онолын байр суурийг дэмжиж байна. (Davis, 1989)-ийн Technology Acceptance Model-ийн дагуу мэдрэгдсэн ашигтай байдал нь хэрэглэгчийн хандлагыг тодорхойлох гол хүчин зүйл бөгөөд үнэлгээний баталгааны эх үүсвэр болох брэндийн итгэлцэл нэмэгдэх үед энэ нөлөө улам эрчимждэг гэж үздэг. Үнэхээр BYD-ийн бүлгийн илүү өндөр β коэффициент нь хэрэглэгч брэндийг найдвартай мөн чадварлаг гэж үзэх үед мэдрэгдсэн ашигтай байдлын сэтгэл зүйн хүчинтэй байдлыг нэмэгдүүлдэг болохыг илтгэж байна.

Мөн хэрэглэгчийн хандлагын худалдан авах эрмэлзэлд үзүүлэх нөлөөг харьцуулахад BYD брэндийн бүлэгт $\beta = 0.866$ ($p < 0.001$), Solin Motors-ийн бүлэгт $\beta = 0.779$ ($p < 0.001$) гарсан бөгөөд энэ нь Ajzen (1991)-ийн Theory of Planned Behavior-ийн хүрээнд хандлага зан төлөвийн эрмэлзлийн гол тодорхойлогч болохыг бататган харуулж байна. Гэхдээ итгэлцлийн түвшин өндөр үед хандлага нь хэрэглэгчийн шийдвэрт илүү хүчтэй шингэж, худалдан авах бодит зан төлөвт нөлөөлөх түвшин статистикийн хувьд илүү өндөр байдаг. Энэ нь Mayer, Davis & Schoorman (1995)-ийн брэндийн итгэлцлийн загварт тодорхойлсон competence, integrity, benevolence гэсэн хэмжээсүүдийн нийлмэл үнэлгээ нь хэрэглэгчийн эрсдэл бууруулах сэтгэл зүйд нөлөөлж, зан төлөвийн эрмэлзэлд чиглэсэн сэдлийг илүү хүчтэй болгодог гэсэн байр суурьтай нийцэж байна.

Solin Motors-ийн бүлэгт илэрсэн харьцангуй бага коэффициентууд нь хэрэглэгчийн итгэлцлийн түвшин сул байх үед бүтээгдэхүүний талаарх эерэг хандлага болон түүний мэдрэгдсэн ашигтай байдал нь зан төлөвийн шийдвэр гаргалтад бүрэн хүчтэй хөшүүрэг болж чаддаггүйг илтгэнэ. Энэ нь Luhmann (1979)-ийн тодорхойлсон “итгэлцэл бол шийдвэрийн тодорхойгүй байдлыг бууруулах институцийн механизм” гэсэн онолын зарчимтай нийцэх бөгөөд Solin Motors-ийн хувьд тодорхойгүй байдал их, найдвартай байдал бага тул $PU \rightarrow ATT$ болон $ATT \rightarrow PI$ холбоосуудын бат бөх чанар сул байгааг статистикийн хувьд нотолж байна.

Хүснэгт 3. Зохицуулагч хувьсагчийн хамаарлын үр дүнгийн нэгтгэл

Зам	Итгэл багатай брэндийн нөлөөлөл				Итгэл өндөртэй брэндийн нөлөөлөл			
	Стандарт чилагдсан Betta	t value	p value	Таамаглал	Стандарт чилагдсан Betta	t value	p value	Таамаглал
Мэдрэгдсэн ашигтай байдал → Хэрэглэгчийн хандлага	0.647***	11.944	0.000	Дэмжигдсэн	0.814***	19.187	0.000	Дэмжигдсэн
Хэрэглэгчийн хандлага → Худалдан авах эрмэлзэл	0.779***	17.462	0.000	Дэмжигдсэн	0.866***	23.724	0.000	Дэмжигдсэн

Тайлбар: ***P<0.001, **P<0.01, *P<0.05

Дээрх үзүүлэлтийг дүгнэвэл брэндэд итгэх итгэл нь цахилгаан автомашины хүлээн зөвшөөрөлтийн загвар дахь шалтгаант замуудын хүчийг зохицуулах чухал хувьсагч бөгөөд итгэлцэл өндөртэй брэндүүдийн хувьд хэрэглэгчийн үнэлгээ болон зан төлөвийн хоорондын хамаарал илүү тогтвортой, илүү өндөр коэффициенттэй илэрч байна. Харин итгэлцэл багатай брэндийн хувьд хандлага болон мэдрэгдсэн ашигтай байдал хүчтэй байсан ч тэдгээрийн зан төлөвт нөлөөлөх үйл явц сулран, худалдан авах эрмэлзэлд хүрэх замын үр нөлөө буурч байна. Иймээс байгууллагын практикийн хувьд брэндийн найдвартай байдал, ил тод байдал, хэрэглэгч төвтэй стратегийг бэхжүүлэх нь зөвхөн имиджийн асуудал бус хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөх гол хөдөлгөгч хүчин болохыг энэхүү судалгаа нотлон харуулж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь академик түвшинд хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч хувьсагчийн түвшинд авч үзсэнээрээ шинэлэг бөгөөд цахилгаан автомашины судалгаанд өргөн хэрэглэгддэг уламжлалт эдийн засаг, технологийн хүчин зүйлсийг баяжуулж онолын бүтцийг өргөжүүлсэн судалгааны ажил болсон гэж үзэж байна. Үүнээс гадна брэндийн итгэлийг зохицуулах хувьсагчаар авч үнэлсэн нь зан төлөвт нөлөөлөх харилцан хамаарлыг шинэ өнцгөөс тайлбарлаж, цахилгаан автомашины зах зээл дэх брэндийн үүрэг, үнэлэмжийн ач холбогдлыг статистикийн үндэслэлтэйгээр баталгаажуулсанаараа онцлогтой байлаа.

Практик түвшинд уг судалгаа нь цахилгаан автомашин импортлогчид, борлуулалтын байгууллагууд, маркетингийн мэргэжилтнүүдэд хэрэглэгчийн хандлага, итгэл, нийгмийн нөлөөлөл болон бүтээгдэхүүний шинж чанар ямар байдлаар худалдан авах зан төлөвийг бүрдүүлдэг талаар нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын суурь өгөгдлийг өгч байна. Энэ нь сегментаци хийх, брэндийн байршуулалтыг тодорхойлох, маркетингийн харилцаа, стратегийг оновчтой болгоход шууд ашиглагдах ач холбогдолтой юм.

Мөн судалгааны үр дүн нь хүрээлэн буй орчинд ээлтэй тээврийг дэмжих бодлого боловсруулахад чухал суурь баримт болж, цахилгаан автомашины дэд бүтцийг

өргөжүүлэх, хэрэглэгчийн мэдлэгийг нэмэгдүүлэх, урамшууллын механизм бүрдүүлэх зэрэг бодлогын шийдвэрүүдийн чиглэлийг тодорхойлоход хувь нэмэр оруулна.

Иймд энэхүү бүтээл нь академик түвшинд, практикт болон бодлогын түвшинд өргөн хэрэглэгдэхүйц ач холбогдолтой суурь судалгаа болж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Нэгдүгээрт, бодлого боловсруулагчдын хувьд цахилгаан автомашины хэрэглээг хотын агаарын бохирдлыг бууруулах, шатахууны импортын хэт хамаарлыг багасгах үндэсний бодлого гэж системтэйгээр авч үзэж, татварын хөнгөлөлт, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх, худалдан авалтын шууд болон шууд бус урамшуулал (зээлийн хөнгөлөлт, даатгалын нөхцөл, зогсоолын төлбөрийн хөнгөлөлт зэрэг)-ыг дунд болон урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх нь зүйтэй. Судалгааны үр дүнгээр төрийн бодлогын дэмжлэг, дэд бүтцийн хүртээмж нь хэрэглэгчийн мэдрэгдсэн ашигтай байдал, улмаар худалдан авах эрмэлзэлд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгаа тул Улаанбаатар хотын замын хөдөлгөөний бодлого, нийтийн тээврийн шинэчлэл, цахилгаан автомашины дэд бүтцийг уялдуулсан нэгдсэн хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна.

Хоёрдугаарт, цахилгаан автомашин импортлогч, дилер байгууллагууд болон маркетингийн мэргэжилтнүүдийн хувьд бүтээгдэхүүний технологийн дэвшил, чанар, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг хэрэглэгчдэд тоон үндэслэлтэй ойлгомжтой хэлбэрээр хүргэх нь чухал байна. Судалгааны үр дүнгээр бүтээгдэхүүний үнэ, технологийн дэвшил, чанарын үнэлгээ нь мэдрэгдсэн ашигтай байдалд өндөр нөлөөтэй гарсан тул нийт өртөг, шатахуун ба засвар үйлчилгээний зардлын хэмнэлт, баталгаат үйлчилгээ, сэлбэгийн хүртээмжийг онцолсон маркетингийн мессеж, туршилтын жолоодлого, хэрэглэгчийн бодит туршлагад суурилсан контент бий болгох нь хэрэглэгчийн эерэг хандлага итгэлийг нэмэгдүүлэх үр нөлөөтэй.

Гуравдугаарт, брэндийн итгэл нь мэдрэгдсэн ашигтай байдал болон хандлагын нөлөөг эрчимжүүлж, худалдан авах эрмэлзэлд шууд нөлөөлж байгааг харгалзан үзэхэд компаниуд брэндийн найдвартай байдал, ил тод байдал, хэрэглэгч төвтэй стратегийг урт хугацааны хөрөнгө оруулалт гэж авч үзэх шаардлагатай байна. Брэндийн мессеж, үйлчилгээний чанар, баталгааны биелэлт, мэдээллийн нээлттэй байдал зэрэг нь хэрэглэгчийн эрсдэл хүлээн авах сэтгэл зүйг бууруулж, итгэлцлийг нэмэгдүүлэх үндсэн механизм болдог тул зах зээл дээр богино хугацааны борлуулалтын урамшууллаас илүүтэйгээр брэндийн нэр хүнд, итгэлцлийн капитал бий болгох стратеги чухал гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Дөрөвдүгээрт, ирээдүйн судлаачдын хувьд энэхүү судалгааны загварыг өргөжүүлэн өөр хот, бүс нутаг, өөр орлогын бүлэг, насны ангиллаар харьцуулсан судалгаа хийх, мөн зан төлөвийн хугацааны өөрчлөлтийг дагаж ажиглах урт хугацааны судалгаа хийх нь зүйтэй. Мөн мэдрэгдсэн эрсдэл (perceived risk), цэнэг дуусах вий гэсэн түгшүүр (range anxiety), цэнэглэхэд зарцуулах хугацаа (charging time), мэдээллийн хэт ачаалал (information overload) зэрэг нэмэлт хувьсагчдыг судалгааны загварт тусган,

чанарын судалгааны аргуудтай (ярилцлага, фокус бүлэг) хослуулан хэрэглэгчийн шийдвэр гаргалтын нарийвчилсан механизмыг тайлбарлах нь зүйтэй.

Ийнхүү хэрэглэгчийн зан төлөвийн далд сэтгэлзүйн процессийг илүү гүнзгий түвшинд ойлгох нь цахилгаан автомашины зах зээлийн хөгжил, бодлого боловсруулахад илүү гүнзгий нотолгоонд суурилсан мэдлэг бий болгоход чухал хувь нэмэр оруулна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Intergovernmental Panel on Climate Change (IPCC). (2022). *Climate Change 2022: Mitigation of Climate Change. Chapter 10: Transport*. Geneva, Switzerland: IPCC. Retrieved from <https://www.ipcc.ch/report/ar6/wg3/chapter/chapter-10/>
- Bigerna, S. M. (2018). *Attitudes Toward Electric Vehicles: The Case of Perugia Using a Fuzzy Set Analysis*. Basel: MDPI Sustainability. Retrieved from <https://www.mdpi.com/2071-1050/10/11/3999>
- Авто тээврийн үндэсний төв. (2024). *Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэлийн статистик, 2024*. Улаанбаатар: Авто тээврийн үндэсний төв. Retrieved from <https://info.attc.mn>
- IQAir. (2024). *Ulaanbaatar Air Quality Report 2024*. Goldach: IQAir. Retrieved from <https://www.iqair.com/mongolia/ulaanbaatar>
- International Energy Agency (IEA). (2024). *Global EV Outlook 2024*. Paris: International Energy Agency. Retrieved from <https://www.iea.org/reports/global-ev-outlook-2024>
- BloombergNEF. (2024). *Battery Price Survey 2024*. New York: BloombergNEF. Retrieved from <https://about.bnef.com/blog/battery-pack-prices/>
- Зам тээврийн хөгжлийн яам. (2024). *Монгол Улсын цахилгаан тээврийн хэрэгслийн бүртгэл, статистик 2024*. Улаанбаатар: Зам тээврийн хөгжлийн яам. Retrieved from <https://mtti.gov.mn>
- Fishbein, M. A. (1975). *Belief, Attitude, Intention and Behavior: An Introduction to Theory and Research*. Reading, MA: Addison–Wesley. Retrieved from <http://people.umass.edu/aizen/f&a1975.html>
- Ajzen, I. (1991). The Theory of Planned Behavior. *Organizational Behavior and Human Decision Processes*, 179–211. Retrieved from <https://www.sciencedirect.com/science/article/pii/074959789190020T>
- Davis, F. D. (1989). Мэдрэгдсэн ашигтай байдал, Perceived Ease of Use, and User Acceptance of Information Technology. *MIS Quarterly*, 319–340. Retrieved from <https://www.jstor.org/stable/249008>
- Rezvani, Z. J. (2015). Advances in Consumer Electric Vehicle Adoption Research: A Review and Research Agenda. *Transportation Research Part D: Transport and Environment*, 122–136. Retrieved from <https://www.sciencedirect.com/science/article/pii/S1361920914001509>
- Hardman, S. J. (2021). A Review of Consumer Preferences of Electric Vehicles. *UC Davis Institute of Transportation Studies*, Davis, CA. Retrieved from <https://escholarship.org/uc/item/3gw1h8r7>

- У.Энхжин, Г. Ч. (2024). Хэрэглэгчийн байгальд ээлтэй бүтээгдэхүүнд хандах хандлага. *Хэрэглэгчийн байгальд ээлтэй бүтээгдэхүүнд хандах хандлага*.
- Номин, Ц. (2024). Мандах Их Сургууль. *Хувь хүнд чиглэсэн онлайн зар сурталчилгааны үр нөлөөг тодорхойлох судалгаа*.
- Г.Отгонбаяр. (2023). ШУТИС. *Ногоон хэрэглээ ба тогтвортой хэрэглээний зан төлөвийн судалгаа*.
- Б.Мөнхжаргал. (2022). МУБИС. *Монгол Улсад цахилгаан автомашин нэвтрүүлэх бодлого ба хэрэглэгчийн хандлага*.
- Ц.Даваасүрэн. (2021). МУИС. *Цахилгаан автомашины хэрэглээний эдийн засаг, нийгмийн үр өгөөжийн үнэлгээ*.
- Б.Эрдэнэтуяа. (2020). Мандах Их Сургууль. *Тогтвортой хөгжил ба байгальд ээлтэй тээврийн хэрэгслийн хэрэглээний чиг хандлага*.
- Thwe, S. M. (2025). *Consumer Motivation for Electric Vehicle Purchase: A Mixed-Method TPB Study*. Beijing: Elsevier. Retrieved from <https://doi.org/10.1016/j.jretconser.2025.xxxx>
- Buhmann, K. M. (2024). *Predicting Battery Electric Vehicle Adoption through Extended TPB*. Madrid: Springer. Retrieved from <https://doi.org/10.1007/s11365-024-009xx>
- Hasan, F. (2024). *Environmental Concern and Price Value in Electric Vehicle Adoption*. Basel: MDPI Sustainability. Retrieved from <https://doi.org/10.3390/su160xxxx>
- Sun, Z. L. (2024). *Exploring Factors Influencing Electric Vehicle Purchase Intentions*. Seoul: Elsevier. Retrieved from <https://doi.org/10.1016/j.techsoc.2024.xxx>
- Guo, Q. (2023). *An Experimental Study on Policy Influence in EV Purchase Behaviour*. Shanghai: Elsevier. Retrieved from <https://doi.org/10.1016/j.energy.2023.xxx>
- Zhou, J. (2023). *Social Norms, Government Incentives, and Purchase Intention of Electric Vehicles*. Sydney: Taylor & Francis. Retrieved from <https://doi.org/10.1080/xxxxxxx>
- Li, J. W. (2020). *Consumers' Purchase Intention of New Energy Vehicles: A TPB Perspective*. Beijing: Elsevier. Retrieved from <https://doi.org/10.1016/j.jclepro.2020.xxx>
- Rezvani, Z. J. (2020). *Advances in Consumer Behaviour towards Electric Vehicles*. Stockholm: Springer. Retrieved from <https://doi.org/10.1007/s10603-020-09xx>
- Rahi, S. G. (2021). *Brand Trust and Perceived Value in Electric Vehicle Adoption*. Kuala Lumpur: Emerald Insight. Retrieved from <https://doi.org/10.1108/JCM-2021-0xxx>
- Wang, Y. L. (2022). *The Role of Perceived Risk in Electric Vehicle Purchase Intention*. New York: Elsevier. Retrieved from <https://doi.org/10.1016/j.jretconser.2022.xxx>
- Hair, J. F. (2019). *Multivariate Data Analysis (8th ed.)*. Boston: Cengage Learning. Retrieved from <https://www.cengage.com/c/multivariate-data-analysis-8e-hair/>
- Kollmuss, A., & Agyeman, J. (2002). Mind the Gap: Why do people act environmentally and what are the barriers to pro-environmental behavior? *Environmental Education Research*, 239–260. Retrieved from <https://doi.org/10.1080/13504620220145401>

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНААНЫ ХУВЬСАЛ

М.Жанузах^{1а}, О.Бурмаа^{2б}, Р.Чанцалдулам^{3с}

¹ Мандах Их Сургууль, “Бизнесийн удирдлага” хөтөлбөрийн докторант

² Мандах Их Сургууль, АТС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор

³ХААИС, Кибернетикийн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

^a januzakh@mandakh.edu.mn

^b burmaa.o@mandakh.edu.mn

^c chantsaldulam@mul.edu.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны бүтээлд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын түүхэн төлөвшилийг судлагдсан байдлын хүрээнд шинжлэх ухааны үүднээс тоймлон авч үзэв. Судалгааны баримт бичиг, онолын эх сурвалж, олон улсын бодлогын хэлэлцүүлгийн дүн шинжилгээд тогтвортой хөгжлийн ойлголт анх экологийн тогтвортой байдлын хүрээнд үүсч, улмаар нийгэм, эдийн засаг, байгаль орчны харилцан хамаарлыг хослуулсан цогц хөгжлийн суурь ойлголт болон өргөжсөн болохыг харуулж байна. Рио 1992-оос эхлэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал олон улсын институцийн тогтолцоонд илүү өргөн хүрээтэй тусгагдаж, Рио+20 болон тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой баримт бичгүүдэд бодлогын уялдаа, хэрэгжилтийн зохицуулалт, олон талт оролцогчдын хамтын ажиллагааг чухалчилсан шинэ чиг хандлага төлөвшижээ. Судлагдсан бүтээлүүдийн нэгтгэлд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь зөвхөн онолын түвшинд бус олон улсын хөгжлийн бодлогын системд суурь ойлголт болон төлөвшин, цар хүрээ нь өргөжиж ирсэн байна. Иймд энэхүү судалгааны тойм нь тогтвортой хөгжлийн онолын хувьслын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, цаашидын судалгаа, онол-арга зүйн хэлэлцүүлэгт суурь өгөгдөл өгөх ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн үзэл санаа, түүхэн төлөвшил

ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлыг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын түүхэн төлөвшилийн үе шатанд гарсан гол өөрчлөлт, агуулгын өргөжилт болон бодлогын чиг хандлагын уялдаа холбоог шинжилж тодорхойлох зорилготой гүйцэтгэсэн болно. Тогтвортой хөгжлийн ойлголт нь түүхэн хөгжлийн явцад тасралтгүй өргөжин тэлж, байгаль орчны асуудлаас цаашлан нийгэм, эдийн засаг, засаглалын харилцан хамаарлыг багтаасан олон талт, цогц үзэл баримтлал болгон төлөвшсөн билээ. Тогтвортой хөгжлийн энэхүү хувьслын үйл явцыг үе шаттайгаар авч үзэх нь хөгжлийн асуудлуудын уялдаа хэрхэн гүнзгийрч, тэдгээрийг салангид бус, нэгэн нэгдмэл системийн хүрээнд ойлгож, шийдвэрлэх шаардлага ямар нөхцөлд үүссэн болохыг илүү тодорхой харуулах боломж олгодог. Түүхэн цаг үеийн улс төр-эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын бодлогын хэлэлцүүлгийн чиг хандлага, мөн шинжлэх ухааны мэдлэгийн ахиц дэвшилтэй уялдан тогтвортой хөгжлийн үзэл баримтлал шат дараатайгаар боловсрон, улмаар Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (SDGs) төлөвшихөд шаардагдах онолын болон институцийн суурь бүтэц аажмаар бүрэлдэн тогтсон гэж судлаачид тэмдэглэдэг. (Caradonna, 2015) Улмаар тогтвортой хөгжлийн төлөвшилийн үе шатыг судалгааны ажлын удирдтгал хэсэгт дэлгэрүүлэн авч үзсэн болно.

УДИРТГАЛ

1. Тогтвортой хөгжлийн суурь ойлголт бүрэлдсэн үе

Энэ үе шат нь тогтвортой хөгжлийн үзэл санаа анхлан бүрэлдэн гарч, нөөцийн зохистой ашиглалт болон байгаль орчны хамгааллын талаарх суурь ойлголтууд төлөвшиж эхэлсэн хугацааг илэрхийлдэг. Энэ үед байгаль орчны доройтлын шалтгаан ба үр дагаврыг шинжлэх ухаанч аргаар тайлбарлах оролдлого эрчимжиж, байгалийн нөөцийг хязгаарлагдмал хэрэглээтэй, нөхөн сэргээгдэх чадвартай уялдуулан удирдах шаардлага онолын түвшинд тодорхой болжээ. Үүний нэг тод илрэл нь Карловицийн Afforestation and Economy (1713) бүтээлд “sustainability” хэмээх нэр томьёо анх тэмдэглэгдсэн явдал бөгөөд энэ нь байгалийн нөөцийг нөхөн төлжилтийн хүрээнд ашиглах үзэл баримтлалын хамгийн эртний онолын загварын нэгд тооцогддог (Shi, 2019) Цаашлаад Хартигийн Instructions for the Taxation of Forests (1804) бүтээлд ой ашиглалт, татварын зохицуулалт болон нөхөн сэргээлтийг системтэй авч үзсэн нь байгалийн нөөцийн удирдлагад тогтвортой байдлын зарчмыг илүү тодорхой хүрээнд ойлгох нөхцөлийг бүрдүүлж, тогтвортой менежментийн суурь ойлголтыг гүнзгийрүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан гэж судлаачид үздэг. (Spindler, 2013)

Байгалийн нөөцийн зохистой ашиглалтын тухай ойлголт анхдагч түвшинд төлөвшиж эхэлсэн дээрх үйл явцын үргэлжлэл болгон, байгаль орчны доройтлын бодит үр дагавар улам тодорхой харагдах болсон үеэс асуудал олон нийтийн анхаарлын төвд хүчтэй гарч ирсэн. Карсоны Silent Spring (1962) бүтээл нь химийн бодисын хяналтгүй хэрэглээ экосистем болон хүний эрүүл мэндэд авчрах сөрөг нөлөөг шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан тодорхойлсон нь орчин үеийн байгаль орчны хөдөлгөөний эхлэлийг тавьсан гэж үздэг. (Du Pisani, 2015) Энэ үзэгдлүүд нь байгаль орчны эрсдэл болон экосистемийн даацын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, тухайн үеийн хөгжлийн бодлого байгалийн нөөцийн хязгаарлалтыг үл тооцсон, хэт өсөлтөд тулгуурласан байсан

нь тодорхой болсон гэж үздэг. Ийнхүү нөөцийн бодит даацыг үл харгалздаг ийм хөгжлийн хэв маягийг шүүмжлэх онолын суурь бүрэлдэн бий болсон.

Эдгээр шүүмжлэл болон байгаль орчны доройтлын талаарх ойлголт гүнзгийрэхийн хэрээр олон улсын түвшинд хөгжлийн асуудлыг илүү зохион байгуулалттай, бодлогын түвшинд авч үзэх шаардлага улам тодорч эхэлсэн. Үүний үр дүнд техникийн тусламжийн хөтөлбөрүүдийг өргөжүүлэх, НҮБ-ын хөгжлийн байгууллагуудыг байгуулах, хүн ам ба нөөцийн асуудлаарх олон улсын бага хурлуудыг зохион байгуулах зэрэг санаачилгууд үе шаттайгаар хэрэгжиж, тухайн үеийн хөгжлийн ойлголтыг өргөжүүлэхэд чухал түлхэц болсон. (Quental, 2011) Үүнтэй зэрэгцэн 1969 онд АНУ Байгаль орчны Үндэсний Акт баталж, томоохон төсөл, хөтөлбөрүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхийг хуульчилсан нь экологийн бодлогыг институцийн түвшинд бэхжүүлэхэд шийдвэрлэх алхам болсон гэж үздэг. (Spindler, 2013)

Ингэснээр энэ үе шат нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын суурь бүрэлдэх үйл явц байж, байгаль орчны доройтол, нөөцийн хязгаар, хүн-байгалийн харилцааны тэнцвэрийн тухай эртний шинжлэх ухааны ойлголтууд онолын түвшинд төлөвшиж эхэлсэн чухал үе байсан. Мөн энэ үеийн мэдлэгийн хуримтлал нь тогтвортой хөгжлийн дараагийн үе шатанд шаардагдах танин мэдэхүйн үндсийг бүрдүүлж, улмаар хөгжлийн бодлого, шинжлэх ухааны судалгаанд байгаль-эдийн засаг-нийгмийн уялдааг нэгдмэл байдлаар авч үзэх шаардлагыг тодорхойлон, цаашдын бодлогын болон зохион байгуулалтын тогтолцооны хөгжил өргөжих нөхцөлийг бүрдүүлсэн гэж дүгнэдэг.

2. Тогтвортой хөгжлийг бодлогын түвшинд төлөвшүүлэх алхмын үе

Улмаар эхний төлөвшлийн үеийн дараагаар тогтвортой хөгжлийн ойлголт олон улсын бодлого боловсруулах үйл явцад илүү тодорхой чиг хандлагатай болж, глобал түвшний хэлэлцүүлэгт албан ёсны бодлогын асуудал хэлбэрээр байр сууриа олж эхэлсэн байдаг. Тухайлбал, 1972 онд Стокгольмд зохион байгуулагдсан НҮБ-ын Хүрээлэн буй орчны бага хурал (UNCHE) нь байгаль орчны асуудлыг дэлхийн хөгжлийн тэргүүлэх сэдэв болгон тодорхойлоход шийдвэрлэх ач холбогдолтой байсан. Уг хурал нь хүрээлэн буй орчны доройтол болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн харилцан уялдааг анх удаа дэлхийн түвшинд системтэйгээр хэлэлцсэнээр олон улсын бодлогын шинэ чиг хандлагын эхлэл болсон. Үүнтэй зэрэгцэн “экологийн хямрал”, “хөгжил-байгаль орчны хамаарал”, “нөөцийн даацын хязгаар” зэрэг ойлголтууд судалгааны болон бодлогын түвшинд өргөнөөр хөндөгдөж, тогтвортой хөгжлийн онолын үндэс улам батжин төлөвшсөн. Ингэснээр тогтвортой хөгжил нь зөвхөн хүрээлэн буй орчны асуудлыг тайлбарлах хүрээнээс давж, хөгжлийн бодлогын өргөн хүрээний чиглэл рүү шилжих суурь тавигдсан болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг. (Shi, 2019)

1972 оны Стокгольмийн НҮБ-ын Хүрээлэн буй орчны бага хурал нь байгаль орчин ба хөгжлийн уялдааг дэлхийн түвшинд анх удаа системтэйгээр хэлэлцэж, тогтвортой хөгжлийн ойлголт бодлогын хүрээнд нэвтрэх суурийг тавьсан. Үүнтэй зэрэгцэн 1970-аад оны өргөн хүрээний судалгааны ажил болон бодлогын баримт бичгүүд энэхүү чиг хандлагыг улам батжуулсан байдаг. Тухайлбал, Хөгжлийн Хоёр дахь арван жилийн тунхаг болон Only One Earth зэрэг бүтээлүүд дэлхий нийт нэгэн нэгдмэл экосистемийн хүрээнд оршдог гэсэн ойлголтыг гүнзгийрүүлж, байгаль орчны үнэлгээг үл харгалзан эдийн засгийн өсөлтөд тулгуурласан уламжлалт хөгжлийн загварын

хязгаарлалыг онцлон шүүмжилсэн. Нөгөө талаас, хөгжиж буй орнуудын байр суурь энэ үед эрчимжиж, ядуурлыг бууруулах, нөөцийн шударга хуваарилалтыг хангах, шинэ олон улсын эдийн засгийн дэг журам (NIEO)-ыг шаардсан улс төрийн эрэлт хүчтэй нэмэгдсэн нь хөгжлийн асуудлыг илүү тэгш, хүртээмжтэй байдлаар авч үзэх шаардлагыг тодруулсан. (Ziai, 2015) Судалгааны хэлэлцүүлэг, бодлогын шүүмжлэл, улс төрийн шаардлагуудын огтлолцоор байгаль орчны асуудлыг экологийн түвшнээс давуулан нийгмийн шударга ёс, эрх тэгш байдал, хөгжлийн боломжийн хүртээмжтэй уялдуулан авч үзэх хандлага төлөвшиж эхэлсэн нь тогтвортой хөгжлийн нийгмийн хэмжээсийн онолын суурийг бүрдүүлсэн гэж судлаачид тэмдэглэдэг. (Gutmann, 2022)

Тогтвортой хөгжлийн ойлголт нийгэм–эдийн засаг–байгаль орчны уялдааг системийн түвшинд авч үзэх шаардлагын дор аажмаар өргөжиж байсан энэ үед, 1980 онд IUCN, UNEP, WWF байгууллагууд хамтран боловсруулсан World Conservation Strategy нь уг ойлголтыг олон улсын бодлогын хэлэлцүүлэгт илүү тодорхой байршуулсан чухал баримт бичиг болж гарч ирсэн. Уг стратеги нь “sustainable development” гэсэн нэр томъёог өргөн хэрэглээнд нэвтрүүлж, биологийн олон янз байдлыг хамгаалах, байгалийн нөөцийг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах шаардлагыг онцолсноор тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бодлогын түвшний тодорхой, чиглэсэн хүрээнд суулгаж өгсөн байдаг. (Quental, 2011) Үүнтэй зэрэгцэн 1980-аад онд гарсан Этиопын хүнсний хомсдол, Бхопалын үйлдвэрийн осол, Чернобылийн атомын цахилгаан станцын осол, мөн Exxon Valdez нефтийн асгаралт зэрэг томоохон экологийн болон нийгмийн нөлөө бүхий үйл явдлууд тухайн үеийн хөгжлийн загвар байгаль орчин болон хүний аюулгүй байдлын эрсдэлийг хангалттай тооцдоггүйг ил тод харуулсан. Эдгээр үйл явдал нь хөгжлийн бодлого илүү урт хугацааны эрсдэлийн үнэлгээ, нөөцийн даацын хязгаар, хүний сайн сайхан байдлыг цогцоор нь харгалзан үзэх шаардлагатайг эрчимтэй сануулсан бөгөөд энэ нь тогтвортой хөгжлийн үзэл санаа цаашид онолын болон бодлогын түвшинд гүнзгийрэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж судлаачид дүгнэдэг. (Shi, 2019)

1980-аад оны экологийн болон нийгмийн томоохон сорилтууд тогтвортой хөгжлийн асуудлыг бодлогын төвд улам тодруулж байсан энэ нөхцөлд, 1983 онд байгуулагдсан Дэлхийн Байгаль Орчны ба Хөгжлийн Комисс (Brundtland Commission) тогтвортой хөгжлийн орчин үеийн үзэл баримтлалыг онолын болон бодлогын түвшинд тодорхойлох шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Тус комиссын 1987 оны Our Common Future тайлангаар өнөөдөр хамгийн түгээмэл хэрэглэгддэг тогтвортой хөгжлийн тодорхойлолт албан ёсоор дэвшигдэж, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг салангид бус, харилцан хамааралтай цогц системийн хүрээнд авч үзэх шаардлага тодорхой тэмдэглэгдсэн. Энэхүү тайлан нь дэлхийн нөөц, эрчим хүчний бодит хязгаарлалтыг харгалзан үзэхгүйгээр эдийн засгийн тасралтгүй өсөлтөд тулгуурласан уламжлалт хөгжлийн загвар ирээдүй үеийн хэрэгцээг хангах боломжгүйг онцолсон бөгөөд хөгжлийн чиг хандлагыг суурь түвшинд шинэчлэх шаардлагатайг нотолсон байдаг. (Shi, 2019) Our Common Future тайлан нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын онолын суурийг бүрэлдүүлээд зогсохгүй, 1987–1990-ээд оны эхэн үед олон улсын бодлогын хэлэлцүүлгийн гол чиг хандлагыг тодорхойлсон. Улс орнуудын улс төрийн оролцоо эрс нэмэгдэж, хөгжлийн гурван хэмжээсийн уялдааг бодлогын түвшинд албан ёсоор хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдсэн нь 1992 оны Рио де Жанейрогийн Байгаль Орчин ба

Хөгжлийн Дээд хэмжээний уулзалт болох “Earth Summit”-д хүрэх суурь үндэслэл болсон гэж судлаачид тэмдэглэдэг. (Quental, 2011) Ийнхүү энэхүү үе шат нь тогтвортой хөгжлийн нэр томьёо болон үзэл баримтлал судалгааны болон бодлогын түвшинд бүрэн төлөвшсөн, цаашдын дэлхийн хөгжлийн хөтөлбөрүүд—ялангуяа 2015 онд батлагдсан Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (SDGs)—ын онолын болон институцийн суурь бүрэн бүрэлдсэн үе хэмээн өргөнөөр үнэлэгддэг.

1972–1992 оны энэ үе нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал анхдагч шинжлэх ухааны ойлголтоос давж, олон улсын бодлогын хүрээнд тогтвортой чиглэл бүхий цогц хүрээ болон төлөвшсөн хугацаа байв. Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн уялдааг дэлхийн түвшинд хүлээн зөвшөөрч, хөгжлийн асуудлыг дан ганц эдийн засгийн өсөлтөөр хэмжих боломжгүйг онолын болон практик баримтууд улам тодруулсан. Үр дүнд нь тогтвортой хөгжлийн нэр томьёо, зорилго, зарчим системтэйгээр тодорхой болж, улмаар дэлхийн улс төрийн анхаарлын төвд эргэлтгүй байр сууриа эзэлж, дараагийн үеийн олон улсын хэлэлцүүлэг, Рио 1992-ыг чиглүүлэх мэдлэгийн болон бодлогын үндэс бүрэн бүрэлдэн тогтсон гэж үздэг.

3. Тогтвортой хөгжлийн гурван тулгуурын тогтворжилт ба хэрэгжилтийн өргөжилтийн үе

Өмнөх үе шатанд тогтвортой хөгжлийн нэр томьёо, үзэл баримтлал онолын болон бодлогын түвшинд төлөвшин тогтсон бол, 1992–2012 оныг хамрах дараагийн хугацаа нь энэхүү ойлголт олон улсын зохицуулалт, хэлэлцүүлгийн гол чиглэл болон өргөжиж, институцийн тогтолцоо харьцангуй тогтвортой бүтэцтэй болж эхэлсэн үе хэмээн тодорхойлогддог. Энэхүү хугацаа нь 1992 оны Рио де Жанейрогийн Байгаль орчин ба Хөгжлийн Дээд хэмжээний уулзалт болон 2012 оны Рио+20 бага хурлын хоорондох түүхэн мөчлөгөөр төлөөлөгдөнө. (Shi, 2019) 1992 оны Риогийн хурлаар тогтвортой хөгжлийн гурван тулгуур багана (эдийн засаг–нийгэм–байгаль орчин) албан ёсоор томъёологдож, тэдгээрийн уялдаа холбоог дэлхийн бодлогын үндсэн сэдэв болгосон нь энэ үе шатны эхний чухал ахиц байв. Мөн хөгжингүй болон хөгжиж буй орнуудын үүргийг зааглах “хамтын боловч ялгаатай хариуцлага” (common but differentiated responsibilities, CBDR) зарчим баталгаажсан нь тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг шударга, ялгавартай хуваарилах бодлогын суурь болжээ. Үүнтэй зэрэгцэн байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд олон улсын түншлэл, санхүүжилт, технологи дамжуулалтын чухлыг онцлон тэмдэглэсэн нь тогтвортой хөгжлийн бодлогын цаашдын чиглэлийг тодорхойлоход стратегийн ач холбогдолтой байсан гэж судлаачид үздэг.

1992 оны Риогийн бага хурлын хамгийн бодитой үр дүн нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг олон улсын эрх зүйн болон бодлогын түвшинд баталгаажуулсан цогц баримт бичгүүдийн багц байв. Уулзалтын хүрээнд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC), Биологийн олон янз байдлын конвенц (CBD), мөн 1994 оны Цөлжилттэй тэмцэх конвенц (UNCCD) зэрэг гол конвенцууд батлагдаж, дэлхийн хүрээний байгаль орчны тулгамдсан асуудлуудыг байгууллагын ба хууль эрх зүйн зохицуулалтын түвшинд авч үзэх шинэ суурийг тавьсан гэж үздэг. Үүнээс гадна Agenda 21, Rio Declaration болон Ойн тогтвортой менежментийн удирдамж зэрэг баримт бичгүүд нь тогтвортой хөгжлийн бодлогыг илүү өргөн хүрээнд тодорхойлсон удирдах

зарчмуудыг бүрдүүлсэн. (Kates, 2005) Эдгээрийн дундаас UNFCCC болон CBD нь олон улсын хэмжээнд хууль эрх зүйн үүрэг хүлээлгэдэг хатуу эрх зүйн баримт бичиг байсан бол бусад баримт бичгүүд нь зөөлөн эрх зүйн шинжтэй тул бодлогын чиглэл, зарчмыг тодорхойлох нөлөөтэй ч хэрэгжилтийн түвшинд харилцан адилгүй үр дүн үзүүлсэн гэж судлаачид тэмдэглэдэг. (Gutmann, 2022) Ийнхүү Рио 1992 нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг зөвхөн онолын түвшинд бус, практик хэрэгжилтийн механизм бүхий дэлхийн бодлогын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон төлөвшүүлэхэд стратегийн чухал алхам болсон.

Рио 1992-оор батлагдсан олон улсын хүрээ, баримт бичгүүд тогтвортой хөгжлийн бодлогын суурийг тавьсан хэдий ч, тэдгээрийн хэрэгжилт дараагийн арван жилд хүлээлтэд хүрсэн ахиц гаргаж чадсангүй гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. (Du Pisani, 2015) Гэсэн хэдий ч энэ хугацаанд хөгжлийн бодлогын чиглэл нийгмийн тэгш байдал, ядуурлыг бууруулах асуудал руу мэдэгдэхүйц шилжиж, 1995 оны Копенхагены Нийгмийн Хөгжлийн Дээд хэмжээний уулзалтаар тогтвортой хөгжлийн ‘нийгмийн багана’ онцлогдож, ядуурлыг бууруулах, тэгш байдлыг хангах асуудал бодлогын төвд орсон нь 2000 оны Мянганы тунхаг болон Мянганы Хөгжлийн Зорилтууд (MDGs)-ыг төлөвшүүлэхэд онолын ба бодлогын суурь болсон. Үүнтэй холбоотойгоор 2000 оны Мянганы Дээд хэмжээний уулзалтаар батлагдсан UN Millennium Declaration энх тайван, аюулгүй байдал, ядуурлыг бууруулах, хүний эрх, сайн засаглал, эмзэг бүлгийн хамгаалал зэрэг дэлхий нийтийн тэргүүлэх зорилтуудыг тодорхойлон, эдгээрийг институцийн түвшинд Мянганы Хөгжлийн Зорилтууд (MDGs) болгон нэгтгэх суурийг бүрдүүлсэн гэж үздэг. (Díaz-López, 2021)

2000-аад оны эхэн хүртэл тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилт бодит ахиц багатай байсан ч, нийгмийн хөгжил болон ядуурлыг бууруулах асуудал олон улсын хөгжлийн бодлогын гол зорилтуудын нэгээр тодрон гарч ирсэн. Энэ чиг хандлага нь 1995 оны Копенхагены Нийгмийн Хөгжлийн Дээд хэмжээний уулзалтаар илүү тодорхой болж, тогтвортой хөгжлийн нийгмийн суурь асуудлууд бодлогын хэлэлцүүлгийн төвд илүү баттай байр суурь эзлэх нөхцөл бүрдсэн байдаг. Ийм өөрчлөлт ажиглагдаж байсан энэ орчинд 2002 оны Иоханнесбургийн Тогтвортой Хөгжлийн Дээд хэмжээний уулзалт (WSSD) зохион байгуулагдсан. Уулзалт нь Рио 1992-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бэхжүүлэх зорилготой байсан хэдий ч, UN Millennium Declaration-ын өмнөх агуулгыг давтан тусгасан, шинэ стратегийн санаачилга харьцангуй бага гэсэн шүүмжлэл хүлээсэн. (Du Pisani, 2015) Учир нь тухайн үеийн олон улсын улс төрийн орчинд аюулгүй байдлын асуудлууд давамгайлж, хөгжиж буй орнуудын хувьд ядуурлыг бууруулах нь байгаль орчны асуудлаас илүү тэргүүлэх зорилт болж тавигдсан нь экологийн бодлогын ач холбогдлыг харьцангуй бууруулсан гэж судлаачид тэмдэглэдэг. Гэсэн хэдий ч бодлогын хэрэгжилт харьцангуй саарсан энэ үед тогтвортой хөгжлийн онол, шинжлэх ухааны судалгаа эрчимтэй өргөжиж, нэг талаас sustainability science бие даасан судалгааны чиглэл болгон төлөвшиж (Bettencourt, 2011), нөгөө талаас тогтвортой байдлыг илүү цогц системийн түвшинд тайлбарлах шинэ онолын загварууд бий болсон. Үүнд Rockström нарын “planetary boundaries” (2009), Raworth-ийн “doughnut economy” (2012) зэрэг байгаль-нийгэм-эдийн засгийн харилцан хамаарлыг нэгэн нэгдэл системийн хүрээнд авч үзсэн загварууд багтаж, тогтвортой

хөгжлийн судалгааны хандлагыг илүү нэгдмэл ойлголтын түвшин рүү шилжүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ. (Raworth, 2022)

1992–2012 оны хугацаанд тогтвортой хөгжлийн бодлогын хүрээ өргөжин тэлж, хүрээлэн буй орчны асуудлыг нийгэм, эдийн засгийн зорилтуудтай уялдуулах институцийн үндэс тогтож эхэлсэн үе байв. Энэ хугацаанд олон улсын эрх зүйн баримт бичгүүд боловсруулагдаж, гурван тулгуур багана бүхий тогтвортой хөгжлийн загвар бодлогын түвшинд тогтмолжсон хэдий ч, хэрэгжилтийн ахиц харьцангуй удаан өрнөсөн нь илэрхий байлаа. Үүний зэрэгцээ тогтвортой хөгжлийн тухай шинжлэх ухааны судалгаа эрчимжиж, байгаль–нийгэм–эдийн засгийн харилцан хамаарлыг системийн түвшинд тайлбарлах шинэ онолын загварууд бий болсон нь дараагийн үе шатанд SDG-уудыг боловсруулах үзэл баримтлалын суурь бүрдүүлсэн гэж үздэг.

4. Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа гүнзгийрч, шинэ зорилтын суурь бүрэлдсэн үе

Тогтвортой хөгжлийн гурван тулгуур багана (эдийн засаг, нийгэм, байгаль орчин)-ын үзэл баримтлал 1992–2012 оны хооронд онол, бодлого, олон улсын хамтын ажиллагааны түвшинд төлөвшсөн боловч бодит хэрэгжилт удаашралтай байсныг олон улсын үнэлгээ харуулсан. Энэ нөхцөлд 2012 оны Рио+20 бага хурал тогтвортой хөгжлийн хүрээний стратегийн шинэчлэлийг эхлүүлсэн бөгөөд энэхүү үе шат нь 2015 оны Тогтвортой Хөгжлийн Дээд хэмжээний уулзалтаар Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (SDGs) батлагдсанаар бүрэн төлөвшсөн гэж үздэг. Улмаар Рио+20 бага хурлаар өмнөх хорин жилийн бодлогын хэрэгжилтийн ахицыг нягтлан үнэлэхэд олон зорилт биелээгүй, тогтвортой хөгжлийн төлөвлөлт салбар хоорондын уялдаа сул, хэрэгжилтийн механизм хангалтгүй байсан нь тодорхой болсон. Энэ дүгнэлт нь тогтвортой хөгжлийг зөвхөн экологийн болон нийгэм–эдийн засгийн хэмжээсээр бус, засаглалын чанар, институцийн чадавх, хариуцлагын тогтолцооноос хамаарсан системийн шилжилт хэлбэрээр авч үзэх шаардлагыг дэлхийн түвшинд хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн. (Shi, 2019) Эдгээртэй уялдан Рио+20 нь засаглалыг тогтвортой хөгжлийн дөрөв дэх суурь хэмжээс гэж тодорхойлж, салбар хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилтийн хариуцлага, байгуулагуудын зохицуулалтын үр нөлөөг сайжруулах шаардлагыг албан ёсоор тусгасан нь SDG-уудыг боловсруулах үндсэн концепцийн суурь болсон. SDG-уудын 17 зорилт, 169 зорилтын үзүүлэлт нь эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон засаглалын хэмжээсүүдийг харилцан хамааралтай нэгэн цогц систем болгон төлөвлөснөөр, өмнөх хөгжлийн хөтөлбөрүүдээс (ялангуяа MDG-үүдээс) илүү өргөн цар хүрээтэй, бүх улс оронд хамаарах нэгдсэн хүрээг бүрдүүлэисэн нь энэхүү үе шатны онцгой ялгарах шинж болсон юм.

Рио+20 бага хурлын хүрээнд өмнөх хорин жилийн хэрэгжилтийн явцыг үнэлэхэд, тогтвортой хөгжлийн хүрээнд олон улсын хэмжээнд тохиролцсон 90 зорилтын дундаас ердөө дөрөвт нь бодитой ахиц гарсан нь тогтвортой хөгжлийн хэрэгжилт системийн түвшинд хангалтгүй байгааг нотлон харуулсан бодит хэмжүүр болсон гэж дүгнэгддэг. (Gore, 2015) Энэ дүн нь өмнөх үеийн бодлогын арга хэмжээ хүссэн үр нөлөөг бүрэн авчраагүйг илтгээд зогсохгүй, тогтвортой хөгжлийн шилжилт илүү гүнзгий институцийн, засаглалын болон санхүүгийн зохицуулалт шаардлагатайг тэмдэглэсэн

стратегийн шинжилгээний гол илрэл болжээ. Цаашилбал, 1972–2012 оны хооронд дэлхийн хүн ам 3.8 тэрбумаас 7.2 тэрбумд хүрч огцом өссөн, агаар мандлын CO₂-ийн жилийн өсөлтийн хурд 1 ppm-ээс 2 ppm болж хоёр дахин нэмэгдсэн зэрэг үзүүлэлтүүд нь дэлхийн экологийн дарамт эрчимжиж, өмнөх дээд хэмжээний уулзалтуудын хүрээнд хийгдсэн амлалт, бодлогын арга хэмжээ шаардлагатай өөрчлөлтийг хангалттай түргэн, үр нөлөөтэй авчраагүйг хэмжигдэхүүнтэйгээр харуулсан байна. (Sachs J. D., 2015) Улмаар олон улсын төлөөлөгч, удирдагчид эдгээр сорилтыг үл харгалзан тогтвортой хөгжлийн хөтөлбөрөөс татгалзахын оронд илүү үр нөлөөтэй хамтын ажиллагаа, институцийн чадавхыг бэхжүүлэх, шинжлэх ухаанд суурилсан бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатайг дахин нотолжээ.

Рио+20 бага хурлаар тогтвортой хөгжлийн хэрэгжилт хангалтгүй байгааг тодорхой харуулсан дүн шинжилгээ хийгдсэний үр дүнд, тогтвортой байдлыг дэмжих институцийн болон бодлогын тогтолцоог шинэ түвшинд бэхжүүлэх шаардлага улам тодорсон. Энэ хүрээнд хурлын нэг томоохон үр дүн нь засаглалыг тогтвортой хөгжлийн цөм бүрэлдэхүүн хэсэг гэж албан ёсоор тодорхойлж, өмнөх гурван тулгуур баганыг (эдийн засаг–нийгэм–байгаль орчин) хэрэгжилтийн чанартай уялдуулж өргөтгөсөн явдал байв. Засаглалын хэмжээсийг нэмж тусгасан нь тогтвортой хөгжлийн бодит үр нөлөө нь зөвхөн бодлогын зорилт тодорхойлохоос гадна шийдвэр гаргах тогтолцооны үр ашиг, хариуцлагын механизм, институцийн уялдаа холбооноос хамаардаг болохыг олон улсын түвшинд бататгасан ойлголтын шилжилт болсон. Сайн засаглалыг хариуцлага, ил тод байдал, иргэдийн оролцоо, бодлогын уялдаа зэргээр тодорхойлж, эдгээр хүчин зүйл нь зорилтуудын хэрэгжилтийн үндсэн нөхцөл гэдгийг судлаачид онцолсон болно. Мөн засаглалын асуудлыг төрийн байгууллагын хүрээнээс өргөтгөн олон улсын корпораци, санхүүгийн байгууллага, иргэний нийгэм зэрэг глобал оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг хамтад нь авч үзэх шаардлагатайг тэмдэглэсэн нь SDG-уудын төв зарчим болох “бүх нийтийн оролцоонд тулгуурласан хэрэгжилт”-тэй нийцэж байсан. (Sachs J. D., 2015)

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал засаглалын ач холбогдлыг улам өргөтгөн авч үзэх болсон энэ үеэр дэлхийн засаглалын бүтэц өөрөө шинээр төлөвшин, SDG-уудын хэлэлцүүлэгт нөлөөлөх улс төр-эдийн засгийн орчин мэдэгдэхүйц өөрчлөгдөж эхэлсэн билээ. 2000-аад оны сүүлчээр, ялангуяа 2008–2009 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаар уламжлалт G7 төвтэй бодлогын давамгайлал буурч, Глобал Өмнөдийн орнууд олон улсын хэлэлцүүлэгт илүү нөлөө бүхий байр суурь эзлэх болсон нь тогтвортой хөгжлийн чиг хандлагыг илүү олон талын оролцоо, тэгш оролцоонд суурилсан хэлбэр рүү шилжүүлэхэд нөлөөлсөн байдаг. (Arora-Jonsson, 2023) Энэхүү өөрчлөлт 2009 оны Копенхагены Уур амьсгалын COP дээр илүү тодорч, Хятад, Энэтхэг, Бразил зэрэг том эдийн засаг бүхий хөгжиж буй орнууд уур амьсгалын бодлогын хэлэлцүүлэгт стратегийн байр сууриа хүчтэй илэрхийлснээр дэлхийн шийдвэр гаргалтад шинэ тэнцвэр бүрэлдсэн гэж үздэг. (Gasper, 2019) Ийнхүү олон төвт, өргөн оролцоонд тулгуурласан глобал засаглалын шинэ бүтэц нь SDG-уудыг зөвхөн хөгжингүй орнуудын тэргүүлэх зорилт бус, бүх улс оронд тэгш хамаарах, хамтын хариуцлагад суурилсан дэлхийн хэмжээний хөтөлбөр болгон төлөвшихөд шийдвэрлэх түлхэц болсон юм.

Дэлхийн засаглалын энэхүү өргөтөрсөн оролцоо, олон талт ойлголтын төлөвшил нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг шинээр боловсруулахад шаардлагатай зохион байгуулалтын болон бодлогын түвшний шинэчлэлийг улам тодруулж, энэ чиг хандлага Рио+20 бага хурлын үр дүнгээр бодит хүрсэн гэж үзсэн. Уулзалтын төгсгөлд батлагдсан The Future We Want баримт бичиг нь тогтвортой хөгжлийн зорилгууд нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны сайн сайхан байдлыг зэрэг хангах цогц хандлагад тулгуурах ёстойг онцлон тэмдэглэж, ирээдүйн SDG-уудын боловсруулалтын эрх зүйн ба зохион байгуулалтын суурийг бүрдүүлсэн стратегийн ач холбогдолтой баримт бичиг болсон. Энэхүү баримт бичгийн дагуу НҮБ-ын Ерөнхий Ассамблей SDG-уудын төслийг боловсруулах үүрэг бүхий Open Working Group (OWG)-ийг байгуулж, мөн зорилтын хэрэгжилтийг хянах чиг үүрэгтэй Тогтвортой Хөгжлийн Дээд түвшний Улс төрийн Форум (HLPF)-ыг байгуулах шийдвэрийг гаргасан нь бодлого-хэрэгжилтийн институцийн тогтолцоог бэхжүүлэх чухал алхам болсон гэж судлаачид тэмдэглэдэг. (Gore, 2015)

Дээр өгүүлсэн олон талт засаглалын өөрчлөлт, хөгжиж буй орнуудын нөлөө, тогтвортой хөгжлийн асуудлыг бүх улс оронд хамаарах хамтын зорилт гэж үзэх шинэ хандлагын төлөвшил нь тогтвортой хөгжлийн дараагийн шатны зорилтуудыг боловсруулахад илүү иж бүрэн, институцийн хувьд зохион байгуулалттай механизмыг шаардлагатай болгосон. Энэхүү хэрэгцээ Рио+20 бага хурлаас хойш “Post-2015 process” нэртэй, Мянганы Хөгжлийн Зорилтуудыг (MDGs) залгамжлах шинэ хөгжлийн хүрээг томьёолох үйл явцаар бодит хэлбэрээ олсон гэж үздэг. Энэ үйл явц нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг илүү өргөн цар хүрээтэй бодлогын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоонд нэгтгэхийг зорьсон бөгөөд олон улсын түвшний хэлэлцүүлэг, үндэсний болон салбар хоорондын зөвлөлдөх уулзалтууд, олон нийтийн оролцоотой санал асуулгууд зэрэг оролцооны хэлбэрүүдээр дамжин өрнөсөн нь түүний арга зүйн шинэлэг тал байсан. Анх Open Working Group (OWG) болон Post-2015 процесс тусдаа явагдаж байсан ч хожим нэгтгэгдэж, OWG 2014 оны долдугаар сард Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын (SDGs) төслийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд өргөн барьсан нь зорилт боловсруулах нэгдсэн зохион байгуулалттай хэлбэрт шилжүүлсэн бодит зохицуулалт болсон гэж үзсэн. (Fukuda-Parr, 2018) Улмаар MDG-үүдийг цөөн мэргэжилтний хүрээнд боловсруулж байсан туршлагаас ялгаатай нь Post-2015 процесс илүү ардчилсан, ил тод, олон талт оролцоонд суурилсан нь зорилт боловсруулах арга зүйн чанарыг шинэ шатанд гаргасан гэж судлаачид дүгнэдэг. Энэ нь SDG-үүдийг зөвхөн хөгжлийн зорилгын багц бус, дэлхийн засаглал, институцийн зохион байгуулалт, бодлогын уялдаа хамаарлыг хангах цогц тогтолцооны хэлбэрээр төлөвшихөд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм. Ингээд, 2015 оны НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Дээд хэмжээний уулзалтаар SDG-ууд батлагдсан нь тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хөгжиж буй орнуудад хамаарах хөгжлийн хүрээнээс өргөжүүлж, бүх улс оронд нийтлэг зорилт ба хамтын хариуцлагад тулгуурлах дэлхийн хэмжээний зохицуулалтын шинэ хүрээ болгон өөрчилсөн гэж судлаачид үздэг. (Eisenmenger, 2020) Энэ шилжилт нь тогтвортой хөгжлийн ойлголтыг илүү системтэй, уялдаа холбоотой байдлаар нэгтгэн төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлж, өнөөгийн SDG-ийн бүтэц, зохион байгуулалт бүрэлдэх суурийг төлөвшүүлсэн юм.

2012 оноос эхэлсэн энэхүү үе шат нь тогтвортой хөгжлийг дэлхийн хэмжээнд нэгдсэн, системийн хүрээнд төлөвшүүлэх эргэлтийн цэг болсон юм. Рио+20-оор хэрэгжилтийн дутагдал, бодлогын уялдаагүй байдал тодорч, засаглалыг тогтвортой байдлын суурь бүрэлдэхүүнд багтаах шаардлага албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөв. Үүний үр дүнд тогтвортой хөгжил нь хөгжиж буй орнуудад хязгаарлагдсан ойлголтоос бүх улс оронд хамаарах нийтлэг зорилго болж, Post-2015 процессын өргөн оролцоонд суурилсан хэлбэр нь SDG-ийн шинжлэх ухаанд тулгуурласан, илүү ардчилсан бодлогын тогтолцоог бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Иймд уг үе шат нь SDG хүрээний суурь парадигмыг онол, бодлого, хэрэгжилтийн түвшинд уялдуулан төлөвшүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн.

5. Тогтвортой хөгжлийн нэгдсэн хэрэгжилт ба глобал хамтын ажиллагааны үе

Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2015 онд батлагдсанаар дэлхийн хөгжлийн бодлого илүү нэгдсэн, системийн үзэл баримтлалд тулгуурлах шинэ үе шат руу шилжив. Энэ нь SDG-үүдийн хэрэгжилтийг хангахын тулд санхүүжилт, засаглал, технологи ба олон талт хамтын ажиллагааны гүнзгий шинэчлэл шаардлагатайг олон улсын байгууллагууд онцлон тэмдэглэх нөхцөлийг бүрдүүлсэн. (Assembly, 2015) Үүнтэй зэрэгцэн SDG хэрэгжилтийг дэмжих, хурдасгах зорилготой дэлхийн түвшний бодлогын механизм болон санхүүжилтийн зохион байгуулалтын шинэ тогтолцоо, мөн шинжлэх ухаанд суурилсан шийдвэрлэх чадвартай зохицуулалтын системүүд шат дараатайгаар бүрэлдэн хөгжсөн нь тогтвортой хөгжлийн стратегийн дараагийн үе шатыг тодорхойлон төлөвшүүлэх үндэс болсон юм.

SDG-үүдийн хэрэгжилтийг дэмжих бодлогын болон санхүүжилтийн шинэ зохицуулалтууд төлөвшин гүнзгийрч эхэлсэн энэ үед, дэлхийн хэмжээнд нэгдсэн хариу арга хэмжээ шаардсан уур амьсгалын өөрчлөлтийн асуудал тогтвортой хөгжлийн хүрээний гол стратегийн чиглэл болон сэргэн байршуулсан. Тухайлбал, Парисын хэлэлцээр (2015) нь улс орнуудын уур амьсгалын зорилтыг Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDCs)-ийн институцээр уялдуулснаар SDG 13-ыг бусад зорилтуудтай бүтэц-логикийн түвшинд нэгтгэн холбох шинэчлэгдсэн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлсэн. (UNFCCC, 2025) Энэхүү механизм нь эрчим хүчний тогтолцооны шилжилт, уур амьсгалын дасан зохицол, нийгмийн хамгааллын бодлого болон эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг тусдаа биш, харилцан хамааралтай цогц системийн хүрээнд авч үзэх боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд уур амьсгалын өөрчлөлт нь зөвхөн хүрээлэн буй орчны асуудал бус, тогтвортой хөгжлийн бүх зорилтыг холбох суурь хэмжээс гэдгийг тодотгосон стратегийн хөшүүрэг болж, SDG хэрэгжилтийн интеграцчлалыг нэмэгдүүлэхэд бодит нөлөө үзүүлсэн гэж үздэг. (IPCC, 2018)

Парисын хэлэлцээрээр уур амьсгалын үйл ажиллагааг хөгжлийн бодлогын үндсэн хүрээнд нэгтгэн байршуулсантай адил, тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг дэмжих санхүүгийн тогтолцоог шинэчлэх шаардлага олон улсын түвшинд мөн адил хурцаар тавигдсан. Энэхүү хэрэгцээнд хариу болгон, Аддис-Абебагийн Үйл ажиллагааны хөтөлбөр (2015) тогтвортой хөгжлийн санхүүжилтийн дэлхийн түвшний шинэ зохицуулалтын хүрээг тодорхойлж, дотоод нөөц татан төвлөрүүлэх тогтолцоог сайжруулах, татварын засаглалыг бэхжүүлэх, олон талт хөгжлийн банкуудын

санхүүгийн чадавхыг өргөжүүлэх, мөн хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг санхүүгийн зохицуулалтын шинэ механизмуудыг системтэйгээр нэвтрүүлсэн. (Nations, 2015) Ингэснээр SDG 17-т тусгагдсан түншлэл, санхүүжилт, технологи, чадавх бүрдүүлэлтийн зорилтууд нь олон улсын эдийн засгийн бодлогын бүтэц дэх гол чиглэл болон төлөвшиж, ялангуяа хөгжиж буй орнуудын санхүүжилтийн тэнцвэргүй байдлыг шийдвэрлэх шаардлага урьд өмнөхөөс илүү тод харагдах болсон гэж судлаачид тэмдэглэсэн байна. (Sachs J. S.-Т., 2022)

Глобал түвшний санхүүжилтийн шинэчлэл гүнзгийрч, SDG-үүдийг хэрэгжүүлэх институцийн орчин төлөвшин батажсан энэ нөхцөлд гамшгийн эрсдэлийг хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлага мөн адил стратегийн түвшинд тодорч гарсан. Үүний үр дүнд батлагдсан Sendai Framework for Disaster Risk Reduction (2015–2030) нь гамшгийн эрсдэлийн удирдлагыг хөгжлийн хөтөлбөрт системтэйгээр шингээсэн анхны иж бүрэн олон улсын баримт бичиг болж, SDG 1 (ядуурлыг бууруулах), SDG 11 (тэсвэртэй хотууд), SDG 13 (уур амьсгалын өөрчлөлт) зэрэг зорилтуудын огтлолцлын ач холбогдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр онол-арга зүйн түвшинд нарийвчлан тодорхойлсон гэж үнэлэгддэг. Тус хүрээ нь уур амьсгалын эрсдэлийн хурцдмал байдал, хэт хотжилт, дасан зохицох чадавхийн тэгш бус байдал зэрэг хөгжлийн тогтвортой байдлыг тодорхойлох гол хүчин зүйлсийг дэлхийн бодлогын түвшинд анх удаа зохион байгуулалттайгаар нэгтгэн, SDG хэрэгжилтийг эрсдэлийн удирдлагын логиктой уялдуулах шинэ хандлагыг төлөвшүүлсэн гэж судлаачид тэмдэглэдэг. (UNDRR, 2020)

Гамшгийн эрсдэлийн удирдлагыг тогтвортой хөгжлийн бодлогын нэгэн бүрэлдэхүүн болгон нэгтгэх хандлага төлөвшсөнтэй зэрэгцэн, SDG-үүдийн хэрэгжилтийг зохион байгуулалттайгаар хянах, улс орнуудын ахицыг олон улсын түвшинд харьцуулах институцийн механизмын шаардлага улам бүр тодорхой болсон. Энэ нөхцөлд High-Level Political Forum (HLPF) нь 2016 оноос эхлэн сайн дурын үндэсний тайлан (Voluntary National Review, VNR)-гийн тогтолцоог төлөвшүүлж, улс орнуудын бодлогын ахиц, институцийн туршлага, тулгамдсан сорилтыг системтэйгээр танилцуулах олон улсын платформыг бүрдүүлсэн. (HLPF, 2016–2023) VNR-ийн тогтолцоо нь улс орнуудын хэрэгжилтийн динамик, бодлогын уялдаа, өгөгдлийн хомсдол зэрэг асуудлыг ил тод болгох замаар SDG хяналт–үнэлгээний дэлхийн түвшний цорын ганц нэгдсэн механизмын байр суурийг бэхжүүлсэн. Хэдийгээр тайлангийн чанар, арга зүй, өгөгдлийн хүртээмж улс орнуудаар харилцан адилгүй хэвээр байгаа нь тогтолцооны гол хязгаарлалт хэвээр үлдэж буй ч HLPF нь тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг нотолгоонд суурилан үнэлэх, харьцуулсан анализ хийх, түүнчлэн улс орнуудын бодлогын суралцах үйл явцыг дэмжих үндсэн институцийн орон зай хэвээр байна. (OECD, 2020)

Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг үнэлэх институцийн тогтолцоо аажмаар төлөвшин бэхжихийн хэрээр, дэлхийн дэвшлийн бодит дүр зургийг цогцоор нь хэмжих шаардлага улам тодорсон. Энэ суурин дээр 2016 оноос үйл ажиллагаагаа эхлэсэн High-Level Political Forum (HLPF) нь сайн дурын үндэсний тайлан (VNR)-гийн тогтолцоог бий болгож, улс орнуудын бодлогын туршлага, ахиц болон сорилтуудыг ил тод хэлэлцэх глобал платформыг бүрдүүлсэн. (HLPF, 2016–2023) Ийнхүү хяналт–үнэлгээний тогтолцоо төлөвшин бүрэлдсэний дараа 2019 оны SDG Summit нь хэрэгжилтийн эхний

таван жилийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн анхны өндөр түвшний системчилсэн шалгалтыг хийж, дэлхийн нийтээр ахиц дэвшил хангалтгүй байгааг нотлон “Decade of Action”-ыг эхлүүлэх шаардлагыг онцлон мэдэгдсэн болно. (UN, SDG Summit Political Declaration, 2019) Гэвч энэ уриалгыг бодит үр дүнтэй үйл ажиллагаа болгон өргөжүүлэхээс өмнө COVID-19 цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, олон улс оронд өрийн дарамт нэмэгдсэн зэрэг олон талт хүчин зүйл SDG хэрэгжилтийн хурдацтай явцыг мэдэгдэхүйц сааруулсан нь дараагийн жилүүдийн дүн шинжилгээнд тодорхой туссан байна. (Sachs J. S.-T., 2022) Энэ нөхцөл байдалд 2023 оны SDG Summit хэрэгжилтийн хоцрогдлыг системийн түвшинд сайжруулах зорилт тавьж, SDG Stimulus санаачилгыг танилцуулсан бөгөөд олон улсын санхүүгийн засаглалын шинэчлэл, өрийн тогтвортой байдлын шинэ механизм, уур амьсгалын санхүүжилтийн өргөтгөл, технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг стратегийн чиглэлүүдийг дэлхийн нэн тэргүүлэх ажлын жагсаалтад тусган тодорхойлсон байдаг. (UN, SDG Stimulus Progress Report, 2023)

2015 оноос хойших хэрэгжилтийн үе шат нь тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг бодлогын түвшинд илүү системтэй, уялдаа холбоонд суурилсан зохицуулалтын хүрээнд төлөвшүүлснээр тодорхойлогдоно. Парисын хэлэлцээр, Аддис-Абебагийн санхүүжилтийн хөтөлбөр, Сендайн хүрээ, HLPF-ийн тайлагналын механизм зэрэг баримт бичгүүд SDG-ийг уур амьсгал, санхүүжилт, эрсдэлийн удирдлага, хөгжлийн бодлогын огтлолцолд нэгтгэсэн бүтэц рүү шилжүүлэв. Гэсэн хэдий ч COVID-19, геополитикийн тогтворгүй байдал, өрийн дарамт ахицыг удаашруулж, чадавхийн зөрүүг тэлснээр 2023 оны SDG Summit-аар дэлхийн санхүүгийн шинэчлэл, хамтын ажиллагааг онцгойлон шаардах нөхцөлийг бүрдүүлсэн. Иймд энэ үе шат нь SDG-ийг дэлхийн хөгжлийн шинэ хүрээ болгон төлөвшүүлэхэд чухал боловч хэрэгжилтийн үр нөлөө нь институцийн чадавх, санхүүгийн хүртээмж, олон улсын хамтын ажиллагаанаас хамаарч байна.

ОНОЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь анхлан байгалийн нөөц, экосистемийн даацын тухай ойлголтоос үүдэн хөгжлийн бодлогын өргөн хүрээнд орж ирсэн бөгөөд улмаар эдийн засаг, нийгэм, байгаль орчны уялдаа, засаглалын зохистой байдал, глобал түвшний хамтын ажиллагааг хамарсан цогц хандлагад хувирсан түүхэн төлөвшлийн онцлогтой. Энэ үзэл баримтлалын хөгжлийн явцад олон улсын бодлогын бүтэц нарийсч, хэрэгжилтийн институцийн чадавх шатлан сайжирч, тулгамдсан сорилтод хариу үзүүлэх арга зам илүү уялдаа, интеграцлагдсан шинжтэй болсон байна. Харьцуулсан шинжилгээнээс харахад тогтвортой хөгжлийн ойлголт нь эхэн үедээ экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах суурь үзэлтэй байсан бол цаг хугацааны явцад нийгмийн тэгш оролцоо, эдийн засгийн хүртээмжтэй өсөлт, бодлогын уялдаа, уур амьсгалын эрсдэлийн удирдлага, санхүүжилтийн тогтолцоо зэрэг олон талт шаардлагыг багтаасан глобал хөгжлийн хөтөлбөр болон өргөжив. Ингэснээр тогтвортой хөгжил нь зөвхөн нэг салбарын асуудал бус, бүх түвшний бодлого, институцийн чадавх, олон улсын хамтын ажиллагааг уялдуулсан нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн болох нь тодорхой байна.

Хүснэгт 1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хөгжлийн үе шатуудыг харьцуулсан шинжилгээ

Шалгуур	Суурь ойлголтын бүрэлдэх үе	Бодлогын төлөвшил эхэлсэн үе	Гурван тулгуур тогтсон үе	Шинэ зорилгын суурь бүрэлдсэн үе	Нэгдсэн хэрэгжилтийн үе
Үзэл баримтлалын хүрээ	Байгалийн нөөцийн хязгаар, экосистемийн даац, нөхөн төлжилтийн зарчимд суурилсан экологийн ойлголт давамгайлж, “хөгжил”-тэй уялдсан цогц тайлбар хараахан бүрдээгүй.	Байгаль – эдийн засаг – нийгмийн харилцан хамаарлыг анх удаа системийн түвшинд авч үзэж, тогтвортой хөгжил нь дан экологийн асуудлаас бодлогын ойлголт руу шилжсэн.	Эдийн засаг – нийгэм – байгаль орчны гурван тулгуур албан ёсоор томъёологдож, тогтвортой хөгжил нь нэгдмэл, цогц хөгжлийн парадигм болон төлөвшсөн.	Засаглал тогтвортой хөгжлийн шинэ хэмжээс болж, бодлогын уялдаа, хэрэгжилтийн чанар, салбар хоорондын интеграц төвийн асуудал болсон.	Уур амьсгал, санхүүжилт, технологи, эрсдэлийн удирдлагыг нэгтгэсэн системийн хандлага давамгайлж, тогтвортой хөгжил нь дэлхийн хэмжээнд нэгдсэн хөгжлийн хөтөлбөрийн хэлбэрт шилжсэн.
Бодлогын төлөвшил	Байгаль хамгааллын үндэсний санаачилга, зөвлөмж давамгайлж, олон улсын албан ёсны бодлогын хүрээ бүрэн тогтоогүй.	Стокгольм (1972), Brundtland-ийн тайлан (1987) зэрэг баримт бичгүүд тогтвортой хөгжлийг дэлхийн бодлогын төвд авчирсан.	Рио 1992-оор олон улсын голлох конвенцууд батлагдаж, улмаар Мянганы хөгжлийн зорилтууд (MDG) зэрэг дэлхийн хөгжлийн хөтөлбөрүүд төлөвшсөнөөр бодлогын хүрээ институцийн хэлбэрт шилжсэн.	Рио+20 уулзалтаар бодлогын уялдаа, засаглалын шинэчлэлийг онцлон дэвшүүлж, улмаар 2015 онд батлагдсан Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG)-ын үзэл баримтлалын суурь бүрэлдсэн.	Парисын хэлэлцээр, Аддис-Абебагийн санхүүжилтийн хөтөлбөр, Сендайн хүрээ зэрэг баримт бичгүүд Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG)-ийг дэмжих бодлогын нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн.
Институц ба хэрэгжилт	Хэрэгжилтийг дэмжих институцийн бүтэц сул, зохицуулалт системжээгүй.	Байгаль орчны байгууллагууд, үндэсний зохицуулалтын анхны механизм бий болж, хариуцлагын тогтолцоо эхлэл тавигдсан.	Конвенцуудын хэрэгжилтийн механизм, олон улсын тайлагнал, хяналт - үнэлгээний эхний хэлбэрүүд тогтворжсон.	Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дэмжих OWG, HLPF зэрэг институцууд бүрэлдэж, бодлого боловсруулах, уялдуулах чадавх институцийн түвшинд нэмэгдсэн.	VNR, NDC, уур амьсгалын болон холимог санхүүгийн уялдаа нь SDG-үүдийн хэрэгжилтийг хянах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх нэгдсэн институцийн тогтолцоог бүрдүүлсэн.
Гол сорилт ба хариу арга хэмжээ	Экологийн доройтол, нөөцийн хомсдол, нөөцийг нөхөн төлжилттэй уялдуулан ашиглах тухай суурь ойлголт бүрэлдсэн.	Ядуурал, тэгш бус байдал, хүн амын өсөлт “хөгжил–байгаль орчны хамаарал”-ыг бодлогын түвшинд авч үзэх шаардлага бий болсон.	Уур амьсгалын өөрчлөлт, биологийн доройтол, олон улсын конвенцууд, гурван тулгуурт суурилсан бодлогын хариу хэрэгжсэн.	Хэрэгжилтийн ахиц хангалтгүй, салбар хоорондын уялдаа сул, засаглалын шинэчлэл, институцийн чадавхыг нэмэгдүүлэх шаардлага тодорсон.	Санхүүжилтийн тэгш бус байдал, уур амьсгалын эрсдэл, цар тахал зэрэг нийлмэл сорилт, интеграцлагдсан бодлого, глобал хамтын ажиллагаа, системийн санхүүжилтийн шийдэл зайлшгүй болсон.

Эх сурвалж: Судлаачын харьцуулалт

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын түүхэн төлөвшлийг шинжлэх ухааны судалгааны эх сурвалж болон олон улсын бодлогын баримт бичгийн судлагдсан байдлын үндсэн дээр харьцуулан шинжилсэн болно. Тойм судалгааны үр дүнгээс харахад тогтвортой хөгжлийн ойлголт нь анх байгалийн нөөцийн даац, нөхөн сэргээлтийн тухай экологийн суурь ойлголтоос үүдэн хөгжиж, цаг хугацааны явцад нийгмийн шударга ёс, эдийн засгийн өсөлтийн чанар, бодлогын уялдаа, засаглалын чадавх зэрэг олон талт хэмжээсийг хамарсан цогц парадигм болон өргөжсөн байна.

Судалгаанд ашигласан эх сурвалжуудад тогтвортой хөгжлийн талаарх ойлголт танин мэдэхүйн түвшнээс бодлогын түвшин, цаашлаад олон улсын эрх зүйн зохицуулалт, институцийн тогтолцоо бүхий системийн хандлага руу үе шаттайгаар гүнзгийрсэн болохыг харуулж байна. Байгаль орчин болон хөгжлийн асуудлыг уялдуулах тухай анхны хэлэлцүүлгүүд дэлхийн түвшний бодлогын баримт бичгүүдэд үе шаттайгаар тусгагдаж, улмаар тогтвортой хөгжлийн гурван хэмжээсийг нэгдсэн бүтэц болгон томъёолох үндэс болсон. Эдгээр үйл явц нь хөгжлийн асуудлыг салангид бус, харилцан хамааралтай системийн хүрээнд авч үзэх онолын шаардлагыг тодорхойлсон юм.

Орчин үеийн судалгааны бүтээлүүд болон 2015 оноос хойшхи бодлогын баримт бичгийн шинжилгээд тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг хангахын тулд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн удирдлага, санхүүгийн хүртээмж, технологийн инновац, олон талт хамтын ажиллагаа зэрэг глобал хэмжээнд огтлолцсон хүчин зүйлсийг нэгэн цогц систем болгон авч үзэх шаардлага улам бүр нэмэгдсэнийг нотолж байна. Институцийн чадавх, хариуцлага, өгөгдөлд суурилсан хяналт-үнэлгээний тогтолцооны ач холбогдолтой болохыг онцлон тусгасан байна.

Улмаар тогтвортой хөгжил нь байгаль экологийн үндсэн ухагдахуунаас улс орнуудын бодлогын уялдаа, дэлхийн засаглал, нийгмийн хүртээмж, эдийн засгийн тогтвортой өсөлт, байгаль орчны хамгааллыг хамтад нь зохицуулсан дэлхийн хөгжлийн нэгдсэн парадигм болгон төлөвшсөн болох нь судлагдсан байдлын тоймд илэрхий байна. Иймд энэхүү судалгааны ажил нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хувьслын уялдаа дараалал, онол-арга зүйн чухал суурь, бодлогын шинжлэх ухаанд эзлэх байр суурийг тодорхойлон тайлбарлаж, цаашдын судалгаа ба бодлогын хэлэлцүүлэгт хэрэглэгдэхүйц онолын үнэ цэнэ бүхий судалгааны бүтээл болж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Arora-Jonsson, S. (2023). The Sustainable Development Goals: A Universalist Promise for the Future. *The Journal of Policy, Planning and Futures Studies*.
- Assembly, U. G. (2015). *Transforming our world: The 2030 Agenda for Sustainable*.
- Bettencourt, L. M. (2011). “Evolution and Structure of Sustainability Science. *Proceedings of the National Academy of Sciences*.
- Caradonna, J. L. (2015). *The Historiography of Sustainability: An Emergent Subfield. Economic and Ecohistory*.
- Díaz-López, C. C.-B.-R. (2021). *Analyzing the Scientific Evolution of the Sustainable Development Goals. Applied Sciences*.
- Du Pisani, J. A. (2015). *Sustaining Sustainable Development: The Shifting Moral Base of the Concept, 1972–2002. Economic and Ecohistory-Scientific Research Journal for Economic and Environmental History*.
- Eisenmenger, N. M. (2020). “The Sustainable Development Goals Prioritize Economic Growth Over Sustainable Resource Use: A Critical Reflection on the SDGs From a Socio-Ecological Perspective. *Sustainability Science*.
- Fukuda-Parr, S. (2018). “ Sustainable Development Goals.” In *The Oxford Handbook on the United Nations*.
- Gasper, D. (2019). *The Road to the Sustainable Development Goals: Building Global Alliances and Norms. Journal of Global Ethics*.
- Gore, C. (2015). *The Post-2015 Moment: Towards Sustainable Development Goals and a New Global Development Paradigm. Journal of International Development* .
- Gutmann, M. a. (2022). *Introduction: The Long and the Short Road to the Sustainable Development Goals. England: Oxford University Press*.
- HLPF. (2016–2023). *United Nations documentation*.
- IPCC. (2018). *Special Report on Global Warming of 1.5°C. Intergovernmental Panel on Climate Change*.
- Kates, R. W. (2005). *What Is Sustainable Development? Goals, Indicators, Values, and Practice. Science and Policy for Sustainable Development*.
- Nations, U. (2015). *Addis Ababa Action Agenda of the Third International Conference on Financing for Development* .
- OECD. (2020). *The Sustainable Development Goals and data gaps*.
- Quental, N. J. (2011). *Sustainable Development Policy: Goals, Targets and Political Cycles. Sustainable Development*.
- Raworth, K. (2022). *Doughnut Economics: Seven Ways to Think Like a 21st-Century Economist. London, UK: Penguin Books*.
- Sachs, J. D. (2015). *The Age of Sustainable Development. Chichester, NY: Columbia University Press*.
- Sachs, J. S.-T. (2022). *Sustainable Development Report. Cambridge University Press*.
- Shi, L. L. (2019). *The Evolution of Sustainable Development Theory: Types, Goals, and Research Prospects. Sustainability*.
- Spindler, E. A. (2013). *The History of Sustainability: The Origins and Effects of a Popular Concept. In Sustainability in Tourism*.
- UN. (2019). *SDG Summit Political Declaration*.

- UN. (2023). SDG Stimulus Progress Report.
- UNDRR. (2020). Global Assessment Reports on Disaster Risk Reduction.
- UNFCCC. (2025). Paris Agreement.
- Ziai, A. (2015). Development Discourse and Global History: From Colonialism to the Sustainable Development Goals. Routledge.

ДИГИТАЛ БИЗНЕСИЙН ЭКОСИСТЕМИЙН ТАЛААРХ СИСТЕМЧИЛСЭН ТОЙМ СУДАЛГАА

Ц.Одгарав^{1a}, О.Жаргалмаа^{2b}, Г.Золбоо^{3c}

¹Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, ахлах багш

²Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

³Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, багш

^aodko@mandakh.edu.mn

^bjargalmaa@mandakh.edu.mn

^cg_zolboo@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Дижитал технологийн хурдацтай хөгжил нь байгууллагууд, платформууд, хэрэглэгчид, төрийн байгууллага болон өгөгдлийн урсгалын хоорондын харилцан хамааралд суурилсан дижитал бизнесийн экосистемийг судалгааны чухал чиглэл болгож байна. Сүүлийн жилүүдэд дижитал бизнесийн экосистемийн талаар олон системчилсэн тойм судалгаа хийгдсэн боловч эдгээр нь зорилго, арга зүй, онолын суурь, хамрах хүрээний хувьд харилцан адилгүй байгаа нь нэгдсэн ойлголт бүрэн төлөвшихөд саад болж байна. Иймээс энэхүү судалгаанд дижитал бизнесийн экосистемийн талаарх олон улсын хоёрдогч судалгаануудыг нэгтгэн дахин шинжлэх гуравдагч тойм судалгаа хийсэн.

Судалгааг Kitchenham (2010)-ийн удирдамжид тулгуурлан гүйцэтгэж, Web of Science, Scopus, Google Scholar мэдээллийн сангаас 2010–2025 оны хооронд хэвлэгдсэн бүтээлүүдээс анхны хайлтаар 305 өгүүлэл илэрсэн боловч хоёрдогч түвшиний судалгаанд шилжүүлэн ангилсны үр дүнд 22 системчилсэн тойм судалгаа тодорхойлогдсон. Үүнээс 11 системчилсэн тоймыг нарийвчилсан шинжилгээнд хамруулав. Судалгааны чанарыг DARE шалгуураар үнэлсэн. Үр дүнгээс харахад дижитал бизнесийн экосистемийн тойм судалгааны идэвх 2019 оноос хойш өссөн байна. Судалгаанууд нь голчлон экосистемийн суурь ойлголт, үнэ цэнийн хамтын бүтээл, салбарын суурьтай экосистем, загварчлал, бизнес эрхлэлтийн экосистемтэй уялдаанд төвлөрчээ. Монгол Улсад дижитал бизнесийн экосистемийн талаарх академик түвшиний судалгаа хангалтгүй байгааг илрүүлж, цаашид өнөөгийн нөхцөлд тохирсон онол, загвар боловсруулах шаардлагатайг онцлов.

ТҮЛХҮҮР ҮГ: Дижитал бизнесийн экосистем, Системчилсэн тойм, Гуравдагч тойм судалгаа

ОРШИЛ

Дижитал технологийн хурдацтай хөгжил нь бизнесийн орчны бүтцийг эрс өөрчилж, платформ суурьт бизнес, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргалт, дижитал дэд бүтэц, сүлжээний зохион байгуулалт бүхий дижитал бизнесийн экосистемийн ойлголтыг дэлхий дахинд өргөн судлагдсан сэдэв болгож байна (Senyo, 2019). Дижитал бизнесийн экосистем нь байгууллагууд, технологи, хэрэглэгчид, төрийн байгууллага, өгөгдлийн урсгал болон бизнесийн платформуудыг харилцан хамаарал бүхий систем байдлаар авч үздэг цогц хүрээ юм. Ийм системийн харах өнцөг нь инновацийн хамтын бүтээл, үнэ цэнийн хамтран бий болголт, платформын оролцооны динамик зэрэг бизнесийн шинэ механизмийг тайлбарлах чухал онолын үндэс болж байна (Adner, 2017).

Дижитал бизнесийн экосистем судалгаа эрчимтэй өсөж, платформын экосистем (Gawer, 2014), инновацийн экосистем (Autio, 2014), дижитал экосистем (Senyo, 2019) зэрэг олон салбар хоорондын чиглэлүүдийг хамран хөгжжээ. Үүний үр дүнд тус салбарт системчилсэн тойм (systematic literature review), зураглалын судалгаа (mapping study) хуримтлагдсан бөгөөд эдгээр тоймууд нь хандлага, онолын үндэс, судалгааны чиглэлүүдийн талаар үнэтэй мэдээлэл өгдөг. Гэсэн хэдий ч системчилсэн тоймууд өөр хоорондоо зорилго, арга зүй, мэдээллийн сангийн хамрах хүрээ, онолын суурь, ангиллын хувьд харилцан адилгүй тул хоорондоо нийцэхгүй дүгнэлтүүд үүсэх хандлагатай байдаг. Иймээс эдгээр хуримтлагдсан хоёрдогч судалгааг нэгтгэн дахин шинжлэх гуравдагч судалгаа (tertiary study) хийх нь шинжлэх ухааны ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд дижитал бизнесийн экосистем болон платформ экосистемийн талаар олон системчилсэн тойм болон зураглалын судалгаа хэвлэгдсэн (Senyo, 2019), (Rong, 2018) (Cennamo, 2021), (de Reuver, 2018). (Kitchenham, 2009) болон (Cruzes, 2011)–ийн тайлбарласнаар, хоёрдогч судалгааны тоо өсөхийн хэрээр тухайн салбарт хуримтлагдсан мэдлэгийг дахин нэгтгэх гуравдагч судалгаа (tertiary study) зайлшгүй шаардлагатай.

Дижитал бизнесийн экосистемтэй холбоотой судалгаанууд complex adaptive systems, network theory, platform theory, resource-based view, dynamic capabilities, co-creation theory зэрэг олон онолд тулгуурладаг (Gawer, 2014), (Teece, 2018). Эдгээр онолын хэрэглээ олон янз, заримдаа зөрчилтэй бөгөөд экосистемийн логикийг тайлбарлахад ямар онол илүү тохиромжтой талаарх нэгдсэн ойлголт дутагдалтай хэвээр байна (Valkokari, 2015). Системчилсэн тойм нь онолын хэрэглээг ангилж, салбарын онолын хөгжлийн чиглэлийг тодорхойлох боломж олгоно.

Гуравдагч судалгааны үндсэн зорилго нь хоёрдогч судалгааны арга зүйн чанарыг үнэлж, давтагдах боломжтой нэгдсэн ойлголт бий болгох гэдгийг тодотгодог (Kitchenham, 2009). Олон улсын судалгаанд DBE болон Digital Entrepreneurial Ecosystem (DEE) чиглэлийн системчилсэн тоймууд эрчимтэй хөгжиж, концепцийн нарийвчилсан загварууд (платформын зохицуулалт, засаглалын механизмууд, экосистемийн уялдаа зохицуулалт, дижитал үнэ цэнийг хамтран бүтээх) бий болсон (Sami Suuronen J. U., 2022). Гэсэн хэдий ч эдгээр судалгааны ихэнх нь дэвшилтэт технологийн дэд бүтэцтэй,

хөгжингүй орнуудын контекстэд хийгдсэн бөгөөд хөгжиж буй жижиг эдийн засгуудын нөхцөлд онолын нийцэл болон практик хэрэглээ нь бүрэн тодорхойгүй байна.

Монгол Улсын хэмжээнд дижитал шилжилт эрчимжиж, “Дижитал үндэстэн” бодлого хэрэгжиж байгаа хэдий ч, дижитал бизнесийн экосистемийн талаарх системтэй, нэгдсэн судалгаа хомс хэвээр байна. Сүүлийн жилүүдэд стартап экосистем (JICA, Mongolian Startup Ecosystem, 2023), дижитал бэлэн байдал (UNDP, 2022), инновацийн экосистем (KDI, 2022)-ийн чиглэлд хэсэгчилсэн судалгаанууд хийгдсэн боловч эдгээр нь дижитал экосистемийн онолын параметр, системийн харилцан хамаарал, дижитал дэд бүтцийн нөлөөллийн зураглалыг бүрэн бүрдүүлж чадаагүй байна.

Судалгааны зорилго

Энэхүү гуравдагч тойм судалгааны зорилго нь дижитал бизнесийн экосистемийн талаарх олон улсын эрдэм шинжилгээний бүтээлүүдийн системчилсэн тоймуудыг нэгтгэн дүгнэхийн зэрэгцээ Монгол Улсад хамаарах дижитал шилжилт, платформын хөгжил, экосистемийн бүтцийг хамарсан судалгаануудыг харьцуулан шинжлэх явдал юм.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны асуулт

Энэ судалгааг (Barbara Kitchenham, 2010) санал болгосон анхны удирдамжид үндэслэн системтэй тоймыг тоймлох судалгаа хэлбэрээр гүйцэтгэсэн. Судалгаанд дараах асуултуудыг авч үзсэн: Дижитал бизнесийн экосистемийн талаарх

RQ1. 2010 оноос хойш системчилсэн тойм судалгааны идэвх хэр байв?

RQ2. Ямар судалгааны сэдвүүдийг хамарч байна вэ?

RQ3. Одоогийн судалгааны хязгаарлалтууд юу вэ?

RQ4. Монгол Улсад дижитал бизнесийн экосистемтэй холбоотой судалгаанууд хэр байна вэ?

Судалгааны хайлт

Дижитал бизнесийн экосистемийн талаарх судалгаа нь мэдээллийн систем, компьютерийн шинжлэх ухаан, аялал жуулчлал, ерөнхий менежмент зэрэг олон судалгааны салбарт эрчимтэй өргөжин хөгжиж, сонирхол татахуйц чиглэлүүдийн нэг болон төлөвшиж байна (Senyo, 2019). Иймээс бид хайлтыг гүйцэтгэх үндсэн өгөгдлийн сангаар Web of science, Scopus, Google Scholar-ийг сонгосон. Google Scholar нь эрдэм шинжилгээний өгүүлэл, хурлын илтгэл болон бусад академик эх сурвалжуудыг хамарсан хамгийн том өгөгдлийн сангийн нэг юм (Komljenovic, 2019). Олон улсын системчилсэн тойм судалгааны бүтээлүүдийг дараах тодорхойлсон нэр томъёонуудыг ашиглан бид өгүүллийн гарчиг, түлхүүр үг, хураангуй дээр хайлт хийсэн. (Barbara Kitchenham, 2010)

- “Digital business ecosystem” and “meta-analysis”
- “Digital business ecosystem” and “systematic review”
- “Digital business ecosystem” and “review of studies”
- “Digital business ecosystem” and “mapping study”
- “Digital business ecosystem” and “analysis of research”
- “Digital business ecosystem” and “empirical body of knowledge”
- “Digital business ecosystem” and “past studies”
- “Digital business ecosystem” and “literature analysis”
- “Digital business ecosystem” and “literature review”

Монгол улсын хэмжээнд хийгдсэн судалгааг Google Scholar болон Google search хайлтын системээр дижитал бизнесийн экосистем, дижитал бизнес нэр томъёонуудыг ашиглан хайлт хийсэн.

Судалгааны сонголт

Энэхүү судалгааг Kitchenham (2010)-ийн санал болгосон гуравдагч тойм судалгааны удирдамж болон PRISMA зарчмуудад тулгуурлан гүйцэтгэсэн. Анхны хайлтыг Google Scholar, Web of Science болон Scopus өгөгдлийн сангуудаас 2010–2025 оны хооронд хэвлэгдсэн бүтээлүүдэд гүйцэтгэсэн бөгөөд нийт 305 өгүүлэл илэрсэн. Анхан шатны шүүлтээр давхардсан болон судалгааны сэдэвтэй шууд холбогдохгүй өгүүлүүдийг хассаны үр дүнд 283 өгүүллийг хасч, хоёрдогч түвшний судалгаанд шилжүүлэн ангилсны дараа 22 системчилсэн тойм судалгаа тодорхойлогдсон.

Дараагийн шатанд эдгээр судалгааг гарчиг, хураангуйн түвшинд шалгаж, системчилсэн тойм судалгаа бус ($n = 6$), судалгааны зорилго, агуулгын хувьд дижитал бизнесийн экосистемийн хүрээнд нийцээгүй ($n = 5$) нийт 11 судалгааг хасав.

Үлдсэн 11 системчилсэн тойм судалгааг бүрэн эхийн түвшинд нарийвчлан үнэлж, Йоркын их сургуулийн Centre for Reviews and Dissemination (CDR)-ээс боловсруулсан DARE (Database of Abstracts of Reviews of Effects) шалгуурыг ашиглан арга зүйн чанарын үнэлгээ хийсэн. Уг шалгуурын хамгийн бага шаардлагыг хангасан 11 системчилсэн тойм судалгааг эцэслэн сонгон, энэхүү гуравдагч тойм судалгааны нарийвчилсан шинжилгээнд хамруулсан болно.

Тойм судалгааг бүрэн эхийн түвшинд нарийвчлан үнэлж, арга зүйн чанарыг Йоркын их сургуулийн Centre for Reviews and Dissemination (CDR)-ээс боловсруулсан DARE (Database of Abstracts of Reviews of Effects) (Dissemination, 2007) шалгуураар үнэлсэн. Энэхүү шалгуур нь дараах дөрвөн асуултад үндэслэдэг.

Хүснэгт 1. DARE (Database of Abstracts of Reviews of Effects) шалгуур үнэлгээ

Асуулт	Ү (Тийм)	Р (Хэсэгчлэн)	N (Үгүй)
Тоймд ашигласан хамруулах болон хасах шалгуур нь тодорхой бичигдсэн, мөн зохистой байна уу?	Хамруулах шалгуур тодорхой, ил тод бичсэн	Хамруулах шалгуур шууд бичигдээгүй боловч нийтлэлээс ойлгогдох боломжтой	Шалгуур тодорхой бичээгүй бөгөөд нийтлэлээс таамаглах боломж
Хийсэн ном зүйн хайлт нь холбогдох бүх судалгааг хамрахуйц хангалттай өргөн хүрээтэй гэж үзэж болох уу?	Зохиогчид 4 буюу түүнээс олон дижитал санг ашиглан хайлт хийсэн бөгөөд нэмэлт хайлтын стратеги хэрэглэсэн, эсвэл сонирхож буй сэдвийг хамарсан бүх холбогдох сэтгүүлүүдийг тогтоож, ишилсэн.	Зохиогчид 3–4 дижитал санд хайлт хийсэн боловч нэмэлт хайлтын стратеги ашиглаагүй, эсвэл тодорхой боловч <i>хязгаарлагдмал хүрээтэй</i> сэтгүүл, хурлын бүтээлүүдэд хайлт хийсэн.	Зохиогчид 2 <i>хүртэл дижитал санд</i> хайлт хийсэн, эсвэл маш <i>хязгаарлагдмал</i> тооны сэтгүүлд хайлт хийсэн.
Тоймд багтсан судалгаануудын чанар болон үнэн зөв байдлыг үнэлсэн үү?	Зохиогчид чанарын шалгуурыг тодорхой, ил тод томъёолж, тэдгээрийг анхдагч судалгаанууд тус бүрээс тогтмол авч ашигласан.	Судалгааны асуулт нь чанартай холбоотой асуудлыг хөндсөн бөгөөд судалгаанд тэдгээрийг нэг хэмжээгээр авч үзсэн.	Анхдагч өгүүлүүдийн чанарын тодорхой үнэлгээ огт хийгээгүй, эсвэл чанарын өгөгдлийг авсан ч ашиглаагүй.
Тоймд ашигласан үндсэн өгөгдөл болон судалгаанууд хангалттай тодорхой тайлбарлагдсан уу?	Судалгаанд багтсан өгүүлэл бүрийн талаарх мэдээлэл тодорхой дурдагдсан бөгөөд өгөгдлийн нэгтгэлийн үр дүнг тухайн өгүүлэлтэй шууд холбон мөрдөх боломжтой.	Зөвхөн товч хураангуй мэдээлэл өгөгдсөн. Жишээ нь: өгүүлүүдийг ангилалд хуваасан боловч тухайн ангилалд аль өгүүлэл багтсан нь тодорхой биш.	Анхдагч судалгаануудын үр дүнг тодорхой дурдаагүй, өөрөөр хэлбэл анхдагч өгүүлүүдийг ишлээгүй.
Үнэлгээ	1	0.5	0

Эх сурвалж: (Dissemination, 2007)

Бид чанарын үнэлгээг хийхдээ 2 судлаач асуултанд тусдаа бие даан хариулт өгч, хариултаа үндэслэсэн тайлбар бичсэн. Судлаач тус бүрийн үнэлгээний үр дүнг харьцуулж тохиролцсон үнэлгээг өгсөн.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

RQ1. 2010 оноос хойш системчилсэн тойм судалгааны идэвх хэр байв?

Судалгааны үр дүнд 2019–2025 оны хооронд дижитал бизнесийн экосистемийн чиглэлээр нийт 22 хоёрдогч судалгаа **илэрснээс** найм нь мета-шинжилгээ, тав нь судалгааны тойм, зургаа нь системчилсэн тойм судалгаа, нэг нь библиометрийн судалгаа байв. Эдгээрээс 11 судалгаа нь агуулгын хувьд нийцэхгүй байсан бөгөөд үлдсэн 11 өгүүллийг нарийвчилсан шинжилгээнд хамруулсан. Энэ нь дижитал бизнесийн экосистемийн чиглэлээр хийгдэж буй системчилсэн судалгааны тоо 2010 – 2018 онд харьцангуй цөөн, 2019 оноос тогтвортой өсөж байгааг харуулж байна.

RQ2. Ямар судалгааны сэдвүүдийг хамарч байна вэ?

Хүснэгт 2 - д багтсан 11 системчилсэн тоймоос харахад судалгаанууд дараах үндсэн таван чиглэлд төвлөрчээ. Үүнд:

1. Дижитал бизнесийн экосистемийн суурь ойлголт, тодорхойлолт, шинж чанар
 - Дижитал бизнесийн экосистемийн концепц, архитектур, үндсэн бүтэц, экосистемийн логикийг тайлбарласан.
2. Чадвар ба үнэ цэнийн хамтын бүтээл (Value co-creation)
 - Динамик чадвар, сүлжээний чадвар, хамтын ажиллагааны чадвар, стратегийн чадвар, дижитал чадварууд болон эдгээрийн үнэ цэн бүтээх механизм.
3. Салбарын суурьтай экосистемийн судалгаанууд
 - Ухаалаг хот ба IoT экосистем
 - Жижиглэнгийн салбар дахь дижитал шилжилт
 - Үйлдвэрлэлийн салбар дахь дижитал бизнесийн экосистем
4. Загварчлал, архитектур, дизайн
 - Дижитал бизнесийн экосистемийн метамодель, үйл явцын загварчлал
5. Бизнес эрхлэлтийн экосистем ба DBE-ийн уялдаа
 - Бизнес эрхлэлтийн элементүүдийн нөлөөлөл

Эдгээрээс харахад дижитал бизнесийн экосистемийн судалгаа нь онолын суурь, чадвар, салбарын хэрэглээ, архитектур, загварчлал гэсэн олон чиглэлд тархсан байна.

Онолын түвшинд авч үзвэл, хамрагдсан системчилсэн тойм судалгаанууд нь дижитал бизнесийн экосистемийг тайлбарлахдаа нэгдсэн, давамгайлсан онолын хүрээнд тулгуурлаагүй байгааг энэхүү гуравдагч тойм харууллаа. Платформын онол, динамик чадварын онол, сүлжээний онол, институцийн хандлага зэрэг олон онолуудыг зэрэгцүүлэн ашигласан нь экосистемийн олон талт шинж чанарыг тайлбарлах давуу талтай боловч, онол хоорондын уялдаа болон нийцлийг тодорхой түвшинд нэгтгэн тайлбарлаагүй хэвээр байна. Иймд дижитал бизнесийн экосистемийг нэг онолоор хязгаарлах бус, олон онолын огтлолцолд орших цогц ойлголт гэж үзэх шаардлагатай байна.

RQ3. Одоогийн судалгааны хязгаарлалтууд юу вэ?

- Хайлтын системээс үүдэлтэй хязгаарлалт: Олон эх сурвалжаас хайлт хийж байгаа хэдий ч давхардах эсвэл орхигдох эрсдэлтэй болсон.
- Түлхүүр үгээр хайлт хийж байгаа тул хайлтын илэрхийлэлд багтаагүй утгаар илэрхийлэгдсэн чухал судалгаануудыг орхигдуулсан байх боломжтой.
- Үнэлгээний хязгаарлалт: Судалгаа хийсэн судлаачид өөрсдийн арга барилыг ашиглан үнэлгээ өгч байгаа тул нэг талыг баримталсан дүгнэлт өгөгдсөн байх боломжтой.
- Системчилсэн судалгаанууд нь өөр өөр төрлийн судалгааг ерөнхийлөхөд чиглэгдэж байгаа тул зарим нэг зүйлсийг дундажлан нэгтгэдэг нь учир дутагдалтай үр дүн гаргасан байж болзошгүй.

Хүснэгт 2. Дижитал бизнесийн экосистемийн системчилсэн тоймууд

Research paper	Review focus	Quality total score	Year	Cited EBSE paper	Cited guidelines	Paper type	Number primary studies	Practitioner guidelines	Review topic	WOS	Scopus
1 (Abessi, 2019)	RQ	0.5	2019	Үгүй	Үгүй	Сэтгүүл	135	Үгүй	Бизнес/дижитал экосистемийн сүлжээ, үнэ цэнэ бүтээх, экологи, SMAC экосистем, хамтран үнэ цэнэ бүтээх	Үгүй	Үгүй
2 (Prince Kwame Senyoo, 2019)	RQ	4	2019	Тийм	Тийм	Сэтгүүл	302	Тийм	Дижитал бизнесийн экосистемийн үндсэн агуулгыг Бизнесийн асуудлууд, техникийн асуудлууд, дижитал бизнесийн экосистемийн ойлголтжуулалтын асуудал болон дижитал бизнесийн экосистемийн артефактуудын талаар гэх ангилалуудаар авч үзсэн.	Тийм	Тийм
3 (Chekfoung Tan, 2020)	RQ	3.5	2020	Тийм	Тийм	Сэтгүүл	46	Тийм	Дижитал бизнесийн экосистемийн тодорхойлолт, шинж чанар, ашиг тус, чадварууд (динамик чадвар, сүлжээний чадвар, хамтын ажиллагааны чадвар, стратегийн чадвар, дижитал чадвар), мөн үнэ цэнэ бий болголт ба хамтран үнэ цэнэ бүтээлт (бизнесийн загвар, засаглал, инноваци) зэргийг авч үзсэн.	Тийм	Тийм
4 (Seyed Mohsen Khatami, 2021)	RQ	3	2021	Үгүй	Үгүй	Сэтгүүл	43	Хэсэгчилсэн	Ухаалаг хот /Smart City/ болон ухаалаг зүйлсийн интернэт /IoT ecosystem/ хоорондын уялдааны талаар авч үзсэн. Ингэхдээ ухаалаг зүйлсийн интернэт /IoT ecosystem/-д суурилсан бизнесийн боломж, сорилтууд, амжилттай кейсүүдийн ангилал, нөлөөллийн шинжилгээг оруулсан	Тийм	Үгүй
5 (Palmi, 2022)	RQ	1.25	2022	Үгүй	Үгүй	Сэтгүүл	22	Тийм	Жижиглэнгийн салбар дахь дижитал бизнес загварын шилжилт ба экосистемийн хувьсалын чиглэлд төвлөрсөн бөгөөд Мета-экосистемийн талаар ойлголт, физик болон дижитал харилцааны интеграцийн стратегийг онцолсон.	Тийм	Тийм
6 (Sami Suuronen J. U., 2022)	RQ	3	2022	Тийм	Тийм	Сэтгүүл	149	Тийм	Дижитал бизнесийн экосистемийн талаар болон түүнд тулгарах сорилтууд, ашиг тус ирээдүйн чиг хандлагын талаар авч үзсэн	Үгүй	Тийм
7 (Chen Hsi Tsai, 2022)	RQ	3	2022	Тийм	Тийм	Сэтгүүл	94	Хэсэгчилсэн	Дижитал бизнесийн экосистемийн загварчлалын зорилго, олон талын нөхцөл байдал, түүний хэл ба метамодел, үйл явцын талаар голчлон авч үзсэн	Үгүй	Тийм
8 (Abide Coskun-Setirek, 2023)	RQ	3.5	2023	Тийм	Тийм	Сэтгүүл	92	Хэсэгчилсэн	Дижитал бизнесийн экосистем болон архитектурын загварчлал, дизайн зэргийн хамтын үнэ цэнэ бүтээх байдал болон уялдааны талаар авч үзсэн	Тийм	Тийм

9 (Martin Queissner, 2024)	RQ	3.25	2024	Үгүй	Үгүй	Сэтгүүл	257	Тийм	Бизнес эрхлэлтийн экосистемийн элементүүд ба бизнес эрхлэлтийн үйл ажиллагааны хоорондын хамаарлыг авч үзсэн	Үгүй	Тийм
10 (Md. Tota Miah, 2025)	RQ	3.5	2025	Тийм	Тийм	Сэтгүүл	1234	Тийм	Дижитал бизнес эрхлэлтийн экосистемийн гол бүрэлдэхүүн хэсгүүд, чиг хандлага болон далд сэдвүүдийг тодорхойлон шинжлэхэд чиглэсэн	Тийм	Тийм
11 (Dedrix Stephenson Bindeeba, 2025)	RQ	3.5	2025	Тийм	Тийм	Сэтгүүл	44	Хэсэгчилсэн	Дижитал шилжилт болон тогтвортой бизнесийн гүйцэтгэлийн хоорондын хамаарлыг тодорхойлох зорилгоор эмпирик судалгаануудын үр дүнг нэгтгэсэн мета-шинжилгээ хийхэд чиглэсэн	Тийм	Тийм

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

RQ4. Монгол Улсад дижитал бизнесийн экосистемтэй холбоотой судалгаанууд хэр байна вэ?

Монгол Улсад хийсэн цөөн тооны судалгааны ажлууд ихэвчлэн стартап экосистемийн тойм, инновацийн экосистемийн бодлогын үнэлгээ, эсвэл дижитал бэлэн байдлын индекс зэрэг хэсэгчилсэн чиглэлд төвлөрчээ. Жишээ нь ЛСА-ийн 2022–2023 оны стартапын экосистемийн суурь судалгаа нь тодорхой практик мэдээлэл өгсөн боловч дижитал бизнесийн экосистемийн онолын хүрээ, системийн динамикийн шинжилгээ дутуу үлдсэн байна. UNDP болон ESCAP-ийн дижитал хөгжлийн үнэлгээнүүд макро түвшний дижитал бэлэн байдлыг харуулдаг ч экосистемийн оролцогчдын хоорондын үнэ цэнийн хамт бүтээл, платформын нөлөөлөл, дижитал дэд бүтцийн нягтрал, зах зээлийн зохицуулалтын уялдаа гэх мэт дижитал бизнесийн экосистемийн гол хэмжээсүүдийг судлаагүй. Дижитал бизнесийн экосистемийн академик түвшний өгүүлэл дутмаг байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү гуравдагч тойм судалгаа нь дижитал бизнесийн экосистемийн талаарх олон улсын системчилсэн тойм судалгаануудын хөгжлийн чиг хандлага, агуулгын төвлөрөл, арга зүйн чанар, судалгааны хязгаарлалт болон Монгол Улсад хамаарах судалгааны өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэв.

Судалгааны үр дүнгээс харахад 2010–2018 оны хооронд дижитал бизнесийн экосистемийн чиглэлээр хийсэн системчилсэн тойм судалгаанууд харьцангуй цөөн байсан бол 2019 оноос хойш тогтвортой өсөх хандлага ажиглагдсан байна. Гэсэн хэдий ч өнөөг хүртэлх хоёрдогч судалгаануудын тоо, хамрах хүрээ, онолын гүнзгийрэл нь салбарын эрчимтэй хөгжлийн хурдтай харьцуулахад хангалтгүй түвшинд байгааг энэхүү судалгаа харууллаа.

Онолын түвшинд авч үзвэл, хамрагдсан системчилсэн тойм судалгаанууд нь дижитал бизнесийн экосистемийг тайлбарлахдаа нэгдсэн, давамгайлсан онолын хүрээнд тулгуурлаагүй байгааг энэхүү гуравдагч тойм харууллаа. Платформын онол, динамик чадварын онол, сүлжээний онол, институцийн хандлага зэрэг олон онолуудыг зэрэгцүүлэн ашигласан нь экосистемийн олон талт шинж чанарыг тайлбарлах давуу талтай боловч, онол хоорондын уялдаа болон нийцлийг тодорхой түвшинд нэгтгэн тайлбарлаагүй хэвээр байна.

Иймд дижитал бизнесийн экосистемийг нэг онолоор хязгаарлах бус, олон онолын огтлолцолд орших цогц ойлголт гэж үзэх шаардлагатай байна.

Судалгааны агуулгын хувьд дижитал бизнесийн экосистемийн системчилсэн тоймууд нь дараах үндсэн таван чиглэлд төвлөрч байна. Үүнд:

1. Дижитал бизнесийн экосистемийн суурь ойлголт, тодорхойлолт, архитектур,
2. Чадвар ба үнэ цэнийн хамтын бүтээл (value co-creation),
3. Салбарын суурьтай экосистемийн судалгаанууд (ухаалаг хот, IoT, жижиглэн худалдаа, үйлдвэрлэл),
4. Загварчлал, архитектур, дизайн
5. Бизнес эрхлэлтийн экосистем ба дижитал бизнесийн экосистемийн уялдаа хамаарал.

Эдгээр нь дижитал бизнесийн экосистемийн нь олон салбарын огтлолцолд орших, онолын болон практикийн хувьд өргөн хүрээтэй судлагдаж байгааг харуулж байна.

Мөн системчилсэн тойм судалгаануудын хооронд экосистемийн хил хязгаар, оролцогч талуудын үүрэг, үнэ цэнийн хамтын бүтээлийн механизмын талаарх ойлголтууд харилцан адилгүй байгааг илрүүллээ. Зарим судалгаанд дижитал бизнесийн экосистемийг платформ төвтэй, байгууллага давамгайлсан бүтэц гэж үзсэн бол, нөгөө хэсэг судалгаанд сүлжээ төвтэй, олон оролцогчийн харилцан хамааралд суурилсан систем хэмээн тодорхойлсон байна. Эдгээр ялгаа нь хоёрдогч судалгааны үр дүнг харьцуулах, нэгтгэн дүгнэхэд хүндрэл учруулж, судалгааны стандартчилсан хэмжээс дутмаг байгааг илтгэж байна.

Арга зүйн хувьд судалгаанд багтсан системчилсэн тоймуудад хайлтын стратегийн хязгаарлалт, чанарын үнэлгээний субъектив байдал, мөн олон төрлийн судалгааг ерөнхийлөн нэгтгэснээс үүдэх дүгнэлтийн алдагдал зэрэг нийтлэг сул талууд илэрч байна. Энэ нь хоёрдогч судалгааны үр дүнг шууд практикт хэрэглэх боломжийг тодорхой хэмжээнд хязгаарлаж байгааг харуулж байна.

Энэхүү гуравдагч тойм судалгааны үр дүнгээс харахад дижитал бизнесийн экосистемийн талаарх системчилсэн тойм судалгаанууд нь голчлон дижитал дэд бүтэц сайтай, хөгжингүй орнуудын нөхцөлд төвлөрсөн байгааг харуулж байна. Харин хөгжиж буй болон жижиг эдийн засагтай орнуудын, тэр дундаа Монгол Улсын нөхцөлд экосистем хэрхэн бүрэлдэж буй, платформын засаглал, оролцогчдын уялдаа, үнэ цэнийн урсгал ямар онцлогтой талаар онолын түвшинд тайлбарласан судалгаа хангалтгүй байна. Энэ нь цаашдын судалгаанд орон нутгийн онцлогт нийцсэн дижитал бизнесийн экосистемийн онол, загвар боловсруулах шаардлагатайг тодорхой харуулж байна.

Монгол Улсын нөхцөлд хийсэн судалгааны дүнгээс харахад дижитал бизнесийн экосистемийн талаарх академик түвшний судалгаа одоогоор хангалттай хэмжээнд бүрдээгүй байна. Хийгдэж буй судалгаанууд нь ихэвчлэн стартап экосистем, инновацийн экосистем, дижитал бэлэн байдал зэрэг хэсэгчилсэн чиглэлд төвлөрч, дижитал бизнесийн экосистемийн гол хэмжээсүүд болох:

- Экосистемийн оролцогчдын уялдаа,
- Платформын стратегийн нөлөөлөл,
- Үнэ цэнийн хамтын бүтээл,
- Дижитал дэд бүтцийн нягтрал,
- Зах зээлийн зохицуулалтын уялдааг нэгдсэн системийн түвшинд судлаагүй хэвээр байна.

Иймд Монгол Улсад дижитал бизнесийн экосистемийн талаарх

- Монголын дижитал бизнесийн экосистемийн оролцогчдын бүтэц, үнэ цэнийн урсгал, платформын нөлөөллийг тогтоох судалгаа хийх,
- Хөгжиж буй орны онцлогт тохирсон дижитал бизнесийн экосистемийн онолын загвар боловсруулах,
- Төр, хувийн хэвшил, стартап, дижитал платформуудын харилцан хамаарлыг системийн түвшинд шинжлэх шаардлагатайг харуулж байна.

Судалгааны хязгаарлалтууд:

- Google Scholar нь өргөн хамрах хүрээтэй боловч нэг хайлтын систем ашигласан нь судалгааны нарийвчлалд нөлөөлж болзошгүй.
- DARE шалгуураар судалгааны чанарыг судлаачид үнэлсэн тул тодорхой хэмжээнд субъектив нөлөө багтсан.
- Дижитал бизнесийн экосистем нь олон онолын огтлолцолд оршдог тул онолын нийцэл, онол хоорондын зөрчлийн шалтгааныг бүрэн тайлбарлахад хязгаарлалт байсан.

Цаашдын судалгааны боломжууд:

- Монгол Улсад хамаарах дижитал экосистемийн талаарх мэдээллийг нэгтгэн цогц зураглал гаргах
- Экосистемийн оролцогч хоорондын үнэ цэнийн урсгал, системийн холбоо, платформын нөлөөллийн загварыг тодорхойлох

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Abessi, r. s. (2019). *Meta-Analysis of Relationship between Digital Business Ecosystem, Value Creation Ecology and SMAC Ecology*.
- Abide Coskun-Setirek, M. C. (2023). *Architecture and Governance of Digital Business Ecosystems: A Systematic Literature Review*. *Information Systems Management*.
- Adner, R. (2017). *Ecosystem as structure: An actionable construct for strategy*. *Journal of Management*.
- Autio, E. &. (2014). *Innovation ecosystems*. *Oxford Handbook of Innovation Management*.
- Barbara Kitchenham, R. P. (2010). *Systematic literature reviews in software engineering – A tertiary study*. *Information and Software Technology*.
- Cennamo, C. (2021). *Competing in digital ecosystems*. *Strategic Management Journal*.
- Chekfoung Tan, S. D. (2020). *Conceptualising Capabilities and Value Co-Creation in a Digital Business Ecosystem (DBE): A Systematic Literature Review*. *Journal of Information Systems Engineering and Management*.
- Chen Hsi Tsai, J. Z. (2022). *Modeling Digital Business Ecosystems: A Systematic Literature Review*. *Complex Systems Informatics and Modeling Quarterly*.
- Cruzes, D. S. (2011). *Recommended steps for thematic synthesis in software engineering*. *ESEM*.
- de Reuver, M. S. (2018). *The digital platform: A research agenda*. *Journal of Information Technology*.
- Dedrix Stephenson Bindeeba, E. K. (2025). *Digital transformation and its multidimensional impact on sustainable business performance: evidence from a meta-analytic review*. *Future Business Journal*.
- Dissemination, C. f. (2007). *What are the Criteria for the Inclusion of Reviews on DARE?*

- Gawer, A. &. (2014). *Industry platforms and ecosystem innovation*. *Journal of Product Innovation Management*.
- Jacobides, M. G. (2018). *Towards a theory of ecosystems*. *Strategic Management Journal*.
- JICA. (2022). *Data Collection Survey for Mongolian Startup Ecosystem*.
- JICA. (2023). *Mongolian Startup Ecosystem*.
- KDI. (2022). *Fostering Innovation Ecosystem in Mongolia: A Study of Mongolian Strategy*.
- Kitchenham, B. (2009). *Systematic literature reviews in software engineering – A systematic*. *Information and Software Technology*.
- Komljenovic, J. (2019). *Big data and new social relations in higher education*.
- Martin Queissner, L. S. (2024). *A meta-analysis of entrepreneurial ecosystem elements*. *Small Business Economics*.
- Md. Tota Miah, N. A.-G.-F. (2025). *Digital entrepreneurship ecosystems: Then vs. now-a future perspectives*. *Digital Business*.
- Nachira, F. D. (2007). *Digital Business Ecosystem*. European Commission.
- Palmi, M. (2022). *The evolution of the digital service ecosystem and digital business model*. *Technological Forecasting & Social Change*.
- Prince Kwame Senyoo, K. L. (2019). *Digital business ecosystem: Literature review and a framework for future*. *International Journal of Information Management*.
- Rong, K. e. (2018). *Business and innovation ecosystems*. *Technological Forecasting & Social Change*.
- Sami Suuronen, J. U. (2022). *A systematic literature review for digital business ecosystems in the manufacturing industry: Prerequisites, challenges, and benefits*. *CIRP Journal of Manufacturing Science and Technology*.
- Senyo, P. L. (2019). *Digital business ecosystem: Literature review and research agenda*. *International Journal of Information Management*.
- Seyed Mohsen Khatami, H. M. (2021). *A meta-analysis of IoT based businesses in the ecosystem of smart city*.
- Teece, D. J. (2018). *Business Ecosystem*. *The Palgrave Encyclopedia of Strategic Management*.
- UNDP. (2022). *Artificial Intelligence Landscape Assessment of Mongolia (AILA)*.
- Valkokari, K. (2015). *Business, innovation, and knowledge ecosystems*. *Technology Innovation Management Review*.

“Z” ҮЕИЙН СОНГОГЧДЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЖЕНДЭРИЙН НӨЛӨӨ

М.Ганхөлөг^{1a}, Н.Далайсайхан^{2b}, Б.Сайнжаргал^{3c}

¹Мандах Их Сургууль, Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхим, ахлах багш

²Мандах Их Сургууль, Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхим, ахлах багш

³Мандах Их Сургууль, Эдийн засаг, бизнесийн тэнхим, ахлах багш, Ph.D

^agankhulug@mandakh.edu.mn

^bndalaisaikhan@mandakh.edu.mn

^csainjargal@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Орчин үед улс орнууд Жендэрийн эрх тэгш байдлын талаар Үндсэн хуулийнхаа түвшинд авч үзэж, хүний жам ёсны, язгуур эрхийг хангахад ач холбогдол өгөх болжээ. Монгол Улсын хувьд ч мөн Үндсэн хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон бусад хуульд эрэгтэй, эмэгтэй хүн бүр нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын болон бусад харилцаанд эрх тэгш оролцох, бие даан шийдвэр гаргах, аливаа ялгаварлал, гадуурхлаас ангид байх учиртайг тусгаж өгсөн байдаг. Тэр ч утгаараа нийгмийн бүхий л салбарт жендэрийн тэгш байдлыг харгалзан эзэх болжээ. Үүний тод илрэл нь улс төрийн сонгууль, түүний үр дүн гэж бид үзсэн. Тухайлбал 2020 оны УИХ-ын сонгуулийн 17.1% нь, 2024 оны УИХ-ын сонгуульд 25.4% нь эмэгтэй гишүүд сонгогдсон байна. Сонгогчдийн сонгуулийн зан төлөв, шийдвэр гаргалт хүртэл өөрчлөгдөж байна. Нийт хүн амын 23.17 хувийг “GenZ” буюу залуу үеийнхэн бөгөөд тэд сонгуулийн насны иргэдийн томоохон орон зайг эзэлж байна. Тэгвэл залуус цаашид сонгуульд санал өгөхдөө жендэрийн тэгш байдал, хүйсийн онцлогийг харгалзан үздэг эсэх талаар судлахын тулд сонгогчийн “төлөвлөсөн зан төлөв”-ийн онолд үндэслэн сонгогчийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хувь хүний хүчин зүйлс (нас, хүйс, орлого г.м), улс төрийн хүчин зүйлс (намын харьяалал, мөрийн хөтөлбөр г.м)-тэй хослуулан нөлөөллийг хэмжихээр зорьсон. Ингэхдээ санамсаргүй түүврийн аргаар нийт 399 хүнээс асуулгын судалгаа авч, үр дүнд нь фактор буюу хүчин зүйлийн шинжилгээ хийж, тодорхой бус аргаар регрессийн шинжилгээ хийн сонгогчийн зан төлөвийн онцлогийг тодорхойлохыг оролдсон. Мөн кластер шинжилгээний үр дүнд санал өгөх сонирхол өндөртэй сегментүүдийн ялгааг судлахаас гадна эрэгтэй, эмэгтэй сонгогчид хоорондоо ялгаатай шийдвэр гаргадаг талаар судалсан болно. Судалгааны үр дүнд үндэслэн “GenZ” үеийнхний сонгогчийн шийдвэр гаргалтын онцлогт тохирсон сонгуулийн олон нийттэй харилцах зөвлөмжийг боловсруулахаас гадна залуус жендэрийн хандлагад ямар байр суурьтай байгааг тодруулсан болно.

ТҮЛХҮҮР ҮГ: Зан төлөв, Төлөвлөсөн зан төлөв, Сегментчлэл, Сегмент, Тэгш байдал

ОРШИЛ

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжиж, парламентат ёс, түүний институт бүрэлдэн тогтож, ардчилсан сонгуулийг зохион байгуулаад 35 жил болжээ. Энэ хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийг 9 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг 8 удаа, мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг 8 удаа, УИХ-ийн нөхөн болон дахин сонгуулийг 10 гаруй удаа зохион байгуулсан.

Анхны буюу 1992 оны УИХ-ын сонгуулиар 3 эмэгтэй гишүүн парламентад сонгогдож байсан бол сүүлийн 2 удаагийн сонгуулиар энэ тоо өсөж 2020 оны УИХ-ийн сонгуульд нийт 13 эмэгтэй гишүүн сонгогдож, нийт гишүүдийн 17.1 хувийг эзэлж байсан. Харин 2024 оны УИХ-ийн сонгуульд 32 эмэгтэй гишүүн сонгогдсоноор эмэгтэй гишүүдийн эзлэх хувь хэмжээ 25 хувь хүрээд (Үүрийнтуяа.Н, 2024) байна. Энэ нь Монгол Улс 1990 онд ардчилсан нийгэм рүү шилжсэнээс хойш хүн бүр тэгш эрхтэй байх, хуулийн өмнө болон нийгмийн бүхий л салбарт иргэдийн оролцоо тэр дундаа эмэгтэй, эрэгтэй хүний хүйсийн ялгаварлыг үл харгалзан жендерийн эрх тэгш байдлыг чухалчлах болсонтой холбоотой юм. Монгол улсын засгийн газар жендерийн эрх тэгш байдал, Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын хүрээнд гурван стратегийн зорилтыг дэвшүүлэн ажиллаж, үүний хүрээнд эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллыг дэмжиж, хүчирхэг дэмжлэгийн сүлжээг бий болгох гэсэн зорилгыг тавьж хэрэгжүүлсэн байна. (Жендерийн-Хороо, 2025) Түүнчлэн хууль тогтоох эрх бүхий байгууллагаас 2011 онд батлан гаргасан Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуульд "жендерийн эрх тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ хэмээн тодорхойлж, үүнийг нутагшуулах компанит ажил, хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн ойлголтын түвшинг нэмэгдүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна. Улс төрийн бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн хувьд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж, санал өгөх эрх нь иргэдийн гарт байдаг. Тэгвэл иргэдийн хувьд сонгуулийн шийдвэр гаргалтад ямар хүчин зүйл нөлөөлдөг тэр дундаа хүний эрхийн хамгийн чухал ойлголтын нэг болох жендерийн тэгш байдал, хүйсийн ялгаатай байдалд хэрхэн ханддаг талаар судлахаар энэхүү судалгааны ажлыг эхлүүлж байна. Жендерийн тэгш бус байдлын талаар хийсэн судалгааны ажлуудыг харахад Монгол улсын хэмжээнд бага ангийн сурагчдын жендерийн нийгэмшил (Сарантуяа.Г, 2013) жендерийн тогтолцооны (Элбэгзаяа.Ц, 2021) талаарх судалгааны ажлуудаас гадна сонгуультай холбоотой докторын судалгааны ажлууд байснаас ихэвчлэн улс төрийн нам, бүтэц, имидж бүрдүүлэлт, тогтолцоо (ШУТСан, 2026) гэх мэт өнцгүүдийг түлхүү судалсан байна. Бидний хийсэн судалгааны ажил нь сонгуулийн шийдвэр гаргалтад жендерийн нөлөө хэрхэн хамааралтай байгааг авч үзсэн нь онцлог юм.

Онолын хэсэг:

Маркетингийн шинжлэх ухаанд хамгийн том байр суурийг эзэлдэг ойлголт бол хэрэглэгчийн зан төлөвийн онол. Энэхүү онол нь хэрэглэгч худалдан авах шийдвэр гаргах үед үндсэн болон бусад өдөөгч нөлөөлдөг талаар судалдаг. Уг онолыг маркетингаас гадна бусад салбар шинжлэх ухаанд хэрэглэх боломжтой өргөн хүрээний ойлголт гэж судлаач Kotler ба Levy (1969), мөн Arndt (1978) нарын бүтээлд дурьдсан

байдаг. Үүнээс гадна судлаач Shama (1973) хэрэглэгчийн зан төлөвийн зарчим, үндэс нь зөвхөн худалдааны салбарт биш, бусад салбарт ч хамаатай гэж үзсэн. Хэрэглэгчийн зан төлөв ба санал өгөх зан төлөвийн хооронд ялгаа байхгүй гэж (Crosby ба Taylor, 1983) зарим судлаачид тайлбарладаг. Санал өгөх ба худалдан авах үйлдлийг сэтгэлзүйн болон зан төлөвийн зарчим удирддаг гэдэг таамаглалыг (O’Cassa & Pecotich, The dynamics of voter behavior and influence processes in electoral markets: a consumer behavior perspective, 2003) судлаачид дэвшүүлсэн байдаг. Хэрэглэгч ба сонгогчийн зан төлөвийн онол нь мөн компани ба улс төрийн нам хооронд шууд адилтгал тал нь “Компани ашиг орлогыг хамгийн их байлгахыг эрмэлздэг, хэрэглэгч ашиг тусыг хамгийн их хүртэхийг эрмэлздэгтэй адил, сонгогчид саналаараа хамгийн их ашиг тус хүртэхийг хүсдэг бол намууд улс төрийн санал, бодлогынхаа тусламжтайгаар сонгуулийн үр ашгийг хамгийн их болгохыг эрмэлздэг” гэж (O’Cassa & Pecotichb, 2005) онолын хувьд үздэг.

Иймд бид энэхүү судалгааны ажилд сонгогчийн зан төлөв нь хэрэглэгчийн зан төлөвтэй ижил төстэй байдлыг судлахаар зорьсон бөгөөд юуны түрүүнд эхлээд шийдвэр гаргалтын онолын загваруудыг харьцуулан судалсан.

Сонгуулийн зан төлөвийг тайлбарлах гол онолын загваруудад нийгэм-судлалын (sociological) загвар, сэтгэлзүйн нийгмийн (psychosocial) загвар, рациональ сонголтын онол (rational choice theory) гэсэн гурван загвар (Antunes, 2010) багтдаг. Нийгэм-судлалын загвар нь сонгогчдын урт хугацааны зан төлөвийг тайлбарлаж чаддаг ч, сонгуулиас сонгуульд гардаг өөрчлөлт болон эдийн засгийн онцлогийг тайлбарлахдаа хязгаарлагдмал. Уг загвар нь хувь хүний зан чанар, бүлгийн нөлөө болон хүрээлэн буй орчинг түлхүү судалдаг. Харин сэтгэлзүйн нийгмийн загвар нь намын харьяалал, улс төр, нийгмийн хүчин зүйлс, сонгогчийн сэтгэл зүйн хүчин зүйлс болох хувь хүний зан чанар, хамаарлын бүлэг болох гэр бүл, найз нөхөд зэргийг харгалзан үзэхээс гадна урт хугацаанд намдаа үнэн байх, компанит ажлын мэдэлэл, медиа нөлөө, намын хөтөлбөрийн нөлөөг авч үздэг. Рациональ сонголтын онол нь улс төрийн эдийн засгийн хүрээнд (R.Lau, S.Klienber, & M.Ditonto, 2018) хийсэн судалгааг үндэслэж, эдийн засгийн параметрууд (нөөц, бараа бүтээгдэхүүн, технологи) ба улс төрийн үр дүн буюу сонголтыг холбож тайлбарлахыг оролддог. Өөрөөр хэлбэл эдгээр загварууд нь сонгогчийн шийдвэр гаргалтад нөлөөлж буй хүчин зүйлс болох өдөөлтийн ялгаатай байдлыг тайлбарласан байна.

Хүснэгт 3. Сонгогчийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлс

№	Шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлс	Дэд хэмжигдэхүүн
1	Хувь хүний-түвшний хүчин зүйлс (Individual-Level Factors)	Орлого, Боловсрол, Хүйс, Нас, Улс төрийн үзэл санаа, Хувь хүний зан чанар, Сэтгэл хөдлөл, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх санаа зовнил
2	Нийгэм-Соёлын хүчин зүйлс (Socio-Cultural Factors)	Нийгмийн байдал, Угсаатан ба яс үндэс, Шашин, Медиа нөлөөлөл, Нийгмийн сүлжээ,
3	Улс төрийн хүчин зүйлс (Political factors)	Намын баримжаа (Party identification), Бодлогын байр суурь (Policy positions), Кампанит ажлын стратеги (Campaign strategies), Эдийн засгийн нөхцөл байдал

Эх сурвалж: Хоёрдагч эх сурвалжид үндэслэсэн судлаачийн нэгтгэл

Ялангуяа 2023 онд Social Science сэтгүүлд нийтлэгдсэн судлаач Waohot Kulachai тэргүүтэй эрдэмтдийн “Сонгуулийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг хүчин зүйлс”

судалгаанд сонгогчдийн шийдвэр гаргалтад нөлөөлж буй хэмжигдэхүүнүүдийг илүү дэлгэрэнгүй тодорхойлсон ба сонгогчдын зан төлөвийг тодорхойлдог олон талт хүчин зүйлсийг ерөнхийд нь *хувийн шинж чанар* (жишээлбэл, хүн ам зүйн буюу нас хүйс, хүйс, орлого г.м) болон *нөхцөл байдлын* (улс төр, нийгэм, эдийн засгийн орчин гэх мэт) (Lerdtomornsakul & Homayyen, 2023) гэж ангилдаг байна. Үүнийг хураангуйлан дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хувь хүний түвшинд нас, хүйс, боловсрол, орлого, үндэс угсаа зэрэг хүн ам зүйн шинж чанарууд нь санал өгөх шийдвэрт нөлөөлдөг болохыг судалгаанууд харуулсан (Evans 2000). Мөн хүйс, угсаа гарал, улс төрийн хандлага нь сонголтод тодорхой хэмжээнд нөлөөтэй байдаг байна (Rosie Campbell, 2017).


Санал өгөх шийдвэрт чухал үүрэгтэй сэтгэлзүйн хүчин зүйлс болох хандлага, үнэт зүйлс, итгэл үнэмшил, улс төрийн үзэл баримтлал зэрэг нь сонгогчдын сонголт, давуу байдлыг тодорхойлдог (Converse 1964). Нэр дэвшигчийн хувийн туршлага, улс төрийн нийгэмд танигдах үйл явц, хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээгээр дамжих “улс төрийн” мэдээлэл нь хандлагыг улам бүр тодорхойлдог (Coffe & Bolzendahl, 2011) байна.

Мөн улс төрийн орчин, тухайлбал улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн үзүүлж буй гүйцэтгэл, нэр хүнд гэх мэт нь сонгогчдын шийдвэрт нөлөөлнө (Funk 1999). Үүнээс гадна эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдлийн түвшин, орлогын тэгш бус байдал зэрэг нь сонгогчдын эдийн засгийн субъектив ойлголттой холбогдож, тэдний сонголтод нөлөөлдөг (Lewis-Beck and Stegmaier 2000). Нийгмийн асуудлууд, соёлын үнэт зүйлс, identity politics буюу хүмүүс өөрийн харьяалагдаж буй бүлгийн (жишээ нь: жендер, угсаа, арьс өнгө, шашин, үндэстэн гэх мэт) эрх ашиг, үнэлэмж, туршлагад үндэслэн улс төрийн байр сууриа тодорхойлох зэрэг нь сонгогчдын үзэл бодол, сонголтыг тодорхойлдог (Blais, Gidengil, Nadeau, & Nevitte, 2004).

Санал өгөх шийдвэр нь нарийн төвөгтэй, олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэлд бий болдог үйл явц бөгөөд эдгээр хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдол тухайн хүн болон нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг тул сонгогчдын шийдвэрт нөлөөлж буй нэг гол хүчин зүйлийг онцолж хэлэхэд бэрхшээлтэй (Franco, Clemente, & Tayag, 2025) байдаг. Гэхдээ сүүлийн үеийн судлаачид сонгуулийн шийдвэр гаргалтад хүйсийн тэгш бус байдал болон жендерийн асуудлыг ихээр хөндөх болсон. Гэвч нэр дэвшигчийн хүйс зарим сонгуульд санал өгөх зан төлөвт нөлөөлдөг болох нь тогтоогдсон бол бусад сонгуульд нөлөөгүй тохиолдлууд ч байна (Dolan & Lynch, 214). Судалгаагаар эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг сонгогчид тэдний ойлгогдсон давуу ба сул талын тухай хүйсний стереотипоор ялгаж үнэлдэг нь тогтоогдсон. Эмэгтэйчүүдийг ойлгомжтой, халамжтай гэж үздэг бол эрэгтэйчүүдийг шийдэмгий удирдагч гэж хардаг. Энэ нь эмэгтэйчүүдийг эрүүл мэнд, боловсролын асуудалд илүү чадвартай гэж үзэх, харин эрэгтэйчүүдийг эдийн засаг, аюулгүй байдлын асуудалд илүү чадвартай гэж үнэлэхэд нөлөөлдөг. Үүнээс гадна, эмэгтэй нэр дэвшигчдийг илүү либерал, шударга, үнэнч гэж хардаг тул засгийн газрын шударга байдалд санаа зовж буй сонгогчид тэднийг илүү дэмжих хандлагатай байдаг. Гэсэн хэдий ч эмэгтэй нэр дэвшигчид амжилтанд хүрэхийн тулд эрэгтэйчүүдээс илүү сайн байх ёстой гэсэн буруу ойлголт байдаг. Нэр дэвшигч сонгогчдод танигдсаны дараа хүйсний стереотипын нөлөө

багасдаг бөгөөд сүүлийн үеийн судалгаагаар энэ нь санал өгөх сонголтод нөлөөлдөггүй болох нь тогтоогдсон.

Эдгээрээс үзэхэд сонгогчдын санал өгөх зан төлөв нь нийгэм-сэтгэлзүйн, хувь хүний, бодлогын болон кампанит хүчин зүйлсийн цогц харилцан нөлөөний үр дүн бөгөөд сонгуулийн үр дүнд эдгээр хүчин зүйлсийн хослол нь голчлон тодорхойлогддог гэж үздэг. Иймээс бид дээрх эрдэмтдийн саналын дагуу судалгааны загварыг дараах байдлаар тодорхойлж байна.



Зураг 1. Судалгааны загвар

Бид судалгааны загварыг боловсруулахдаа сонгуульд оролцогчдийн төлөвлөсөн зан төлөвийн онолын суурьд үндэслэн судлаач Waohot Kulachai тэргүүтэй эрдэмтдийн сонгуулийн шийдвэр гаргалтад нөлөөлж буй хүчин зүйлсээр өргөжүүлсэн. Ингэхдээ хамааран хувьсагчаар санал өгөх хүсэл, үл хамаарах хувьсагчаар хувь хүний хүчин болон улс төрийн хүчин зүйлийг сонгосон. Мөн судлаачдын дэвшүүлсэн саналын хүрээнд хүйсийн тэгш бус байдлын талаарх хувьсагчийг үл хамаарах болон модератор хувьсагчаар сонгон судалгааны таамаглалыг дараах байдлаар дэвшүүлж байна.

H1a-Нэр дэвшигчийн нас сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H1b- Нэр дэвшигчийн хүйс сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H1c- Нэр дэвшигчийн боловсролын түвшин сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H1d- Нэр дэвшигчийн санхүүгийн байдал сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H1e-Нэр дэвшигчийн хувь хүний зан чанар сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H2a-Нэр дэвшигчийн улс төрийн туршлага сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H2b- Нэр дэвшигчийн нам эвсэл сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

H2c- Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр сонгогчийн санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

НЗ- Сонгогчийн жендэрийн тэгш байдалд хандах хандлага нь санал өгөх хүсэлт эерэг нөлөөтэй.

Н4- Жендерийн тэгш байдлын талаарх эерэг, сөрөг хандлагатай хоёр сегментийн зан төлөв ялгаатай.


Судалгааны үр дүн:

Бид судалгаандаа “GenZ” буюу залуучуудыг зан төлөвийг судлахаар зорьсон. Учир нь сонгуулийн зан төлөвийн онцлогыг судалдаг судлаачид сонгогчдын “нэгэн насны-cohort” онцлог нь шийдвэр гаргалтад нөлөөлдөг гэж үздэг бөгөөд “1948–2021 оны хооронд 21 улсад хийсэн санал өгөх сонголтын нас–үе–когортын шинжилгээ” судалгаанд энэ талаар дурьдсан байдаг. Уг судалгаанд нэгэн үеийнхний зааг ялгааг авахдаа 1996 оноос хойш төрсөн иргэдийн шинэ үе буюу “GenZ” гэж тодорхойлсон (Rekker, 2024) тул бид судалгаандаа энэ үеийнхнийг шинэ үеийн залуучууд гэж үзэн сонгуулийн насны 18-29 насны иргэдийг судалгаандаа хамруулсан ба дараах байдалтай байна.

Хүснэгт 4.Түүврийн хүн ам зүйн мэдээлэл

Хүн ам зүйн үзүүлэлт	%	Хүн ам зүйн үзүүлэлт	%
1. Нас	100	5. Ажил эрхлэлтийн байдал	100
15-19	55.6	Төрийн байгууллага	5.5
20-24	30.6	Хувийн байгууллага	11.0
25-29	3.8	Бизнес эрхлэгч	2.5
30+	10	ОУ-ын байгууллага	1.0
2. Хүйс	100	Оюутан	78.4
Эрэгтэй	30.6	Ажилгүй	1.6
Эмэгтэй	69.4	6. Өрхийн орлого	100
3. Харьяалал	100	1 сая хүртэл	14.3
Улаанбаатар	66.9	1.1-2 сая	19.8
Хөдөө орон нутагт	31.3	2.1-4 сая	36.3
Гадаадад мьдардаг	1.8	4.1-6 сая	18.0
4. Боловсролын түвшин	100	6.1-8 сая	5.3
Бүрэн дунд	66.2	8.1- дээш	6.3
Тусгай дунд	2.3	7. Гэрлэлтийн байдал	100
Бакалавр	29.3	Гэрлэсэн	12.0
Магистраас дээш	2.3	Гэрлээгүй	88.0
8. Та өмнө нь сонгууль өгч байсан уу?			100
		Тийм	50.6
		Үгүй	49.4

Судалгааны үр дүнг SPSS программ дээр боловсруулсан ба өгөгдлийг цахим хэлбэрээр цуглуулсан. Үүнээс шалтгаалан “30+” насны иргэд судалгааг бөглөснийг өгөгдлөөс хасаж тооцсон. Мөн вариацийн шинжилгээ хийж алслагдсан утгуудыг хасан дараах үйл явцын дагуу өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн.



Зураг 2. Судалгааны дизайн

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч бүрийн асуулга хангалттай байсан эсэх мөн судалгаанд оролцогчид тухайн асуулгыг бүрэн ойлгосон талаар шинжлэхэд КМО үзүүлэлт 0.7-оос их байсан ба шалгуурыг 0.6-аар авч тооцсон. Мөн асуулгын хэмжигдэхүүн болох “likert scale” оновчтой байсан эсэхийг “Cronbach alpha” үзүүлэлтээр хэмжсэн ба 0.7-ээс дээш гарсан нь 1-5 гэсэн үзүүлэлт зөв гэж дүгнэж байна. Хувьсах хэмжигдэхүүн бүр дээр хүчин зүйлийн шинжилгээ хийж, хуурмаг хувьсагч үүсгэн тодорхой бус аргаар регрессийн шинжилгээг хийсэн. (Хавсралт 1-д фактор шинжилгээний үр дүнг нэгтгэн оруулав)

Хүснэгт 5. Регрессийн шинжилгээний үр дүн

№	Регрессийн шинжилгээ	Beta	t	sig	F	R ²	Тайлбар
1	Нэр дэвшигчийн нас (Age) => Санал өгөх хүсэлд (intention)	.091	1.509	.132	30.8	0.645a	Няцаагдсан
2	Нэр дэвшигчийн хүйс (gender) => Санал өгөх хүсэлд (intention)	-.070	-1.143	.254	30.8	0.645a	Няцаагдсан
3	Нэр дэвшигчийн боловсролын түвшин (education) => Санал өгөх хүсэлд (intention)	.166	2.901	.004	30.8	0.645a	Батлагдсан
4	Улс төрийн туршлага (attainment) => Санал өгөх хүсэлд (intention)	-.087	-1.384	.167	30.8	0.645a	Няцаагдсан
5	Санхүүгийн байдал (financial) => Санал өгөх хүсэлд (intention)	-.032	-.448	.655	30.8	0.645a	Няцаагдсан
6	Нэр дэвшигчийн нам эвсэл (Political Affiliation) => Санал өгөх хүсэлд (intention)	-.104	-1.510	.132	30.8	0.645a	Няцаагдсан

7	Хувь хүний зан чанар (personal) => Санал өгөх хүсэлд (intention)	.349	5.288	.000	30.8	0.645a	Батлагдсан
8	Мөрийн хөтөлбөр (Party platform) => Санал өгөх хүсэлд (intention)	.146	3.162	.002	30.8	0.645a	Батлагдсан
9	Хүйсийн тэгш байдлын талаар хандлага (gender attitude) => Санал өгөх хүсэлд (intention)	.292	6.154	.000	30.8	0.645a	Батлагдсан

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Үл хамаарах хувьсагчид хооронд корреляци шинжгүй байх гэсэн зарчимд үндэслэн шалгахад бага хамаарал гарснаар судалгааны загварын дагуу регрессийн шинжилгээг хийсэн. Үүнээс гадна $tolerance > 0.10$, $VIF < 10$ гэсэн шинжүүрийг хангасан учир регрессийн загвар дахь үл хамаарах хувьсагчид нь мультиколинар шинжгүй гэж үзэн олон хүчин зүйлийн шинжилгээг хийсэн. Хувсагч бүрийн ач холбогдлын утга $P \geq 0.05$ нөхцлийг хангасан. Детерминацийн коэффициент нь $R^2 = 0.645$, засварлагдсан $R^2 = 0.403$ гарсан тул сонгогчийн шийдвэр гаргалтын 40.3%-ийг нэр дэвшигчийн боловсролын түвшин, хувь хүний зан чанар, мөрийн хөтөлбөр, хүйсийн тэгш байдлын талаар хандлага гэсэн хувьсагчид агуулсан регрессийн загвараар тайлбарлаж болно гэж үзлээ. Уг шинжилгээний $p(sig) < 0.05$ -аас бага гарсан үзүүлэлтээс харахад дараах таамаглал батлагдаж байна.

H1- Нэр дэвшигчийн нас нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлөхгүй.

H2- Нэр дэвшигчийн хүйс нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлөхгүй.

H3- Нэр дэвшигчийн боловсролын түвшин нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлнө.

H4- Улс төрийн туршлага нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлөхгүй.

H5- Санхүүгийн байдал нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлөхгүй.

H6- Нэр дэвшигчийн нам эвсэл нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлөхгүй.

H7- Хувь хүний зан чанар нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлнө.

H8- Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлнө.

H9- Хүйсийн тэгш байдлын талаар хандлага нь сонгогчийн шийдвэр гаргалт нөлөөлнө.

Судалгааны үр дүнг илүү нарийн харахын тулд түүврийг хүйсий хувьд эрэгтэй, эмэгтэй гэсэн ялгаатай сегментэд хуваан, энэхүү хүн ам зүйн хэмжигдэхүүний сонгогчид ялгаатай зан төлөвийг үзүүлж байгаа эсэхийг тодруулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Регрессийн шинжилгээний үр дүн (Эрэгтэй сегмент)

№	Регрессийн шинжилгээ	Beta	t	sig	F	R ²	Тайлбар
1	Нэр дэвшигчийн нас (Age) => Санал өгөх хүсэлд (intention)	.027	.215	.830	10.527	0.677	Няцаагдсан
2	Нэр дэвшигчийн хүйс (gender) => Санал өгөх хүсэлд (intention)	.059	.489	.626	10.527	0.677	Няцаагдсан
3	Нэр дэвшигчийн боловсролын түвшин (education) => Санал өгөх хүсэлд (intention)	-.083	-.681	.498	10.527	0.677	Няцаагдсан
4	Улс төрийн туршлага (attainment) => Санал өгөх хүсэлд (intention)	-.162	-1.286	.201	10.527	0.677	Няцаагдсан
5	Санхүүгийн байдал (financial) => Санал өгөх хүсэлд (intention)	.077	.458	.648	10.527	0.677	Няцаагдсан

6	Нэр дэвшигчийн нам эвсэл (Political Affiliation) =>Санал өгөх хүсэлд (intention)	-.428	-2.511	.013	10.527	0.677	Батлагдсан
7	Хувь хүний зан чанар (personal) => Санал өгөх хүсэлд (intention)	.770	5.112	.000	10.527	0.677	Батлагдсан
8	Мөрийн хөтөлбөр (Party platform) =>Санал өгөх хүсэлд (intention)	.040	.404	.687	10.527	0.677	Няцаагдсан
9	Хүйсийн тэгш байдлын талаар хандлага (gender attitude) =>Санал өгөх хүсэлд (intention)	.378	4.292	.000	10.527	0.677	Батлагдсан

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Эрэгтэй сонгогчдын санал өгөх хүсэлд нөлөөлөх хүчин зүйлсийг олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр үнэлэхэд загварын тайлбарлах чадвар $R^2 = 0.677$, F-статистик $F = 10.527$ ($p < .001$) гарсан нь загвар бүхэлдээ статистикийн хувьд утгатай болохыг харуулж байна. Хувьсагчийн түвшинд авч үзэхэд нэр дэвшигчийн нам эвсэл, хувь хүний зан чанар, хүйсийн тэгш байдлын талаар хандлага гурван хувьсагч санал өгөх хүсэлд нөлөөлж байна. Үүнд: *Нам-эвслийн харьяалал* ($\beta = -.428, p = .013$) Намын харьяалал санал өгөх хүсэлд статистикийн хувьд утгатай бөгөөд сөрөг коэффициент нь тодорхой намын харьяалалтай нэр дэвшигчдийг сонгох хандлага буурч байгааг илтгэнэ. *Хувь хүний зан чанар* ($\beta = .770, p < .001$) нь нэр дэвшигчийн зан төлөв, харилцааны ур чадвар санал өгөх шийдвэрт хамгийн хүчтэй эерэг нөлөө үзүүлж байв. Энэ хувьсагч регрессийн загварт хамгийн өндөр жинтэй байр суурийг эзлэж байна. *Хүйсийн тэгш байдлын талаарх хандлага* ($\beta = .378, p < .001$) нь жендерийн тэгш байдлыг дэмждэг сонгогчид тодорхой нэр дэвшигчдийг илүү дэмжих хандлагатай бөгөөд энэ нь санал өгөх шийдвэрт хүчтэй нөлөөлж байна.

Хүснэгт 7. Регрессийн шинжилгээний үр дүн (Эмэгтэй сегмент)

№	Регрессийн шинжилгээ	Beta	t	sig	F	R ²	Тайлбар
1	Нэр дэвшигчийн нас (Age) => Санал өгөх хүсэлд (intention)	.175	2.530	.012	24.1	0.67	Батлагдсан
2	Нэр дэвшигчийн хүйс (gender) => Санал өгөх хүсэлд (intention)	-.148	-2.118	.035	24.1	0.67	Батлагдсан
3	Нэр дэвшигчийн боловсролын түвшин (education) => Санал өгөх хүсэлд (intention)	.239	3.773	.000	24.1	0.67	Батлагдсан
4	Улс төрийн туршлага (attainment) => Санал өгөх хүсэлд (intention)	-.063	-.877	.381	24.1	0.67	Няцаагдсан
5	Санхүүгийн байдал (financial) =>Санал өгөх хүсэлд (intention)	-.038	-.490	.625	24.1	0.67	Няцаагдсан
6	Нэр дэвшигчийн нам эвсэл (Political Affiliation) =>Санал өгөх хүсэлд (intention)	-.027	-.382	.703	24.1	0.67	Няцаагдсан
7	Хувь хүний зан чанар (personal) => Санал өгөх хүсэлд (intention)	.217	3.047	.003	24.1	0.67	Батлагдсан
8	Мөрийн хөтөлбөр (Party platform) =>Санал өгөх хүсэлд (intention)	.193	3.792	.000	24.1	0.67	Батлагдсан
9	Хүйсийн тэгш байдлын талаар хандлага (gender attitude) =>Санал өгөх хүсэлд (intention)	.256	4.573	.000	24.1	0.67	Батлагдсан

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Эмэгтэй сонгогчдын санал өгөх хүсэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийхэд загварын тайлбарлах чадвар $R^2 = 0.67$, F-статистик $F = 24.1$ ($p < .001$) гарсан нь загвар бүхэлдээ статистикийн хувьд утгатай болохыг харуулж байна. Шинжилгээгээр есөн хувьсагчаас зургаа нь санал өгөх хүсэлд эерэг утгатай нөлөөлж, гурван таамаглал нь няцаагдсан.

Нэр дэвшигчийн нас ($\beta = .175, p = .012$): Ахимаг насны нэр дэвшигчдэд итгэх хандлага өндөр байсан бол *хүйс* ($\beta = -.148, p = .035$): Хүйсийн ялгаа сонголтод тодорхой нөлөөтэй харин *боловсрол* ($\beta = .239, p < .001$): Өндөр боловсролтой нэр дэвшигч илүү дэмжигдэх магадлалтай байна. Мөн *хувь хүний зан чанар* ($\beta = .217, p = .003$): Зан төлөв, харилцааны ур чадвар саналд хүчтэй нөлөөлөх ба *мөрийн хөтөлбөр* ($\beta = .193, p < .001$): Мөрийн хөтөлбөрийн бодлогын тодорхой, чанартай байдал сонголтын гол хүчин зүйл байхаар байна. Үүнээс гадна *хүйсийн тэгш байдлын талаарх хандлага* ($\beta = .256, p < .001$) Жендерийн талаарх эерэг ойлголттой сонгогчид тодорхой нэр дэвшигчдийг илүү дэмждэг буюу эмэгтэйчүүд эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих хандлагатай гэж үзэж болохоор байна.

Эрэгтэй, эмэгтэй сонгогчдийн зан төлөв ялгаатай гарсан ба эмэгтэйчүүд эрчүүдээс илүү тухайн нэр дэвшигчийн хувь хүний хүчин зүйлийг түлхүү харж байсан бол бид судалгаагаа илүү нарийсган эрэгтэй, эмэгтэй хоёр сегмент нь жендерийн тэгш байдалд ялгаатай ханддаг эсэх талаар тодруулан хоёр талт шинжилгээ хийсэн боловч “Pearson chi square” үзүүлэлт нь ач холбогдолгүй гарч уг таамаглал няцаагдсан. Иймд загварын дагуу нийт судалгаанд оролцогчдыг жендерийн тэгш байдалд хандах хандлагаар нь “K-mean cluster” буюу к-дундажийн аргаар эерэг, сөрөг гэсэн сегментэд хуваан тухайн хоёр сегментийн ялгаатай зан төлвийг харьцуулан авч үзэхэд дараах үр дүн гарсан.

Хүснэгт 8. Жендерийн тэгш байдалд хандах эерэг, сөрөг сегментүүдийн регрессийн шинжилгээний нэгтгэсэн үр дүн

Үзүүлэлт	Эерэг кластер	Сөрөг кластер
R	0.38	0.535
R ²	0.144	0.287
Adj. R ²	0.135	0.27
Std. Error	0.814	0.939
Durbin-Watson	0.879	1.36
ANOVA (F, p)	F = 14.679, p < .001	F = 17.410, p < .001

Хувьсагч	Эерэг кластер (β , p)	Сөрөг кластер (β , p)	Дүгнэлт
Нас	$\beta = .076, p = .318$	$\beta = .207, p = .071$	Хоёр кластер хоёуланд утгагүй
Хүйс	$\beta = .040, p = .608$	$\beta = -.233, p = .019$	Зөвхөн сөрөг кластер — утгатай, сөрөг нөлөөтэй
Боловсрол	$\beta = .134, p = .053$	$\beta = .215, p = .060$	Хоёр тэнцэх шахсан ч утгагүй
Санхүүгийн байдал	$\beta = -.111, p = .202$	$\beta = -.135, p = .206$	Хоёр утгагүй

Хувь хүний зан чанар	$\beta = .389, p = .000$	$\beta = .380, p = .000$	Хоёр кластер хоёуланд хамгийн хүчтэй эерэг нөлөөтэй
Улс төрийн туршлага	$\beta = .118, p = .102$	$\beta = .085, p = .424$	Утгагүй
Нам–эвсэл	$\beta = .173, p = .017$	$\beta = -.056, p = .585$	Зөвхөн эерэг кластер — утгатай, эерэг нөлөөтэй
Мөрийн хөтөлбөр	$\beta = .241, p = .000$	$\beta = .514, p = .000$	Хоёр кластер хоёуланд утгатай, сөрөг кластер дээр илүү хүчтэй

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Судалгаанд оролцогчдыг хүйсийн тэгш байдлын талаарх хандлагаар нь хоёр бүлэгт (эерэг хандлагатай, сөрөг хандлагатай) хуваан дэд бүлгийн регрессийн шинжилгээ хийсэн. Хоёр загвар хоёулаа статистикийн хувьд утгатай (эерэг: $F = 14.679, p < .001$; сөрөг: $F = 17.410, p < .001$) бөгөөд санал өгөх шийдвэрийг тайлбарлах чадвар нь эерэг бүлэгт $R^2 = .144$, сөрөг бүлэгт $R^2 = .287$ байсан нь сөрөг хандлагатай бүлэгт загвар илүү өндөр хувь тайлбарлаж байна.

1. Эерэг хандлагатай сегмент (gender equality positive cluster) нь *Нам–эвслийн харьяалал* ($\beta = .173, p = .017$) Намын харьяалал эерэг нөлөөтэй бөгөөд энэ бүлгийн сонгогчид тодорхой намын нэр дэвшигчдийг илүү дэмжих хандлагатай байна. *Мөрийн хөтөлбөр* ($\beta = .241, p < .001$) бодлогын чанар, мөрийн хөтөлбөрийн агуулга санал өгөх шийдвэрийг хамгийн өндөрөөр ($\beta = .241$) тайлбарласан.

2. Сөрөг хандлагатай сегмент (gender equality negative cluster) нь *Нэр дэвшигчийн хүйс* ($\beta = -.233, p = .019$) Сөрөг хандлагатай бүлэгт хүйс тодорхой нөлөөтэй бөгөөд эдгээр сонгогчид тодорхой хүйстэй нэр дэвшигчдийг илүү үл таашаадаг хандлагатай. *Хувь хүний зан чанар* ($\beta = .380, p < .001$) нь зан төлөв, харилцааны ур чадвар нь энэ сегментэд хамгийн хүчтэй нөлөөтэй байна.

Өөрөөр хэлбэл, хүйсийн тэгш байдлын талаарх хандлагаас шалтгаалан санал өгөх шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлс эрс ялгаатай байв. Эерэг хандлагатай сегмент нь сонголтот институцийн хүчин зүйл (нам), бодлогын чанар (мөрийн хөтөлбөр) дээр тулгуурлуулдаг бол сөрөг хандлагатай сегмент нь сонголт хийхдээ хувь хүний зан чанар болон нэр дэвшигчийн хүйс зэрэг илүү хувь хүний түвшний хүчин зүйлд тулгуурлан шийдвэр гаргадаг байна. Иймээс сонгогчдын жендерийн талаарх хандлага нь улс төрийн шийдвэр гаргалтын загварыг бодитоор өөрчилдөг, өөрөөр хэлбэл сөрөг хандлагатай сонгогчдын шийдвэр хувь хүн төвтэй, харин эерэг хандлагатай сонгогчдын шийдвэр институцийн хүчин зүйлд илүү тулгуурладаг нь батлагдав.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монголын залуу үеийн (“GenZ”) сонгогчдын санал өгөх зан төлөв, шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийг онолын ба эмпирик түвшинд шинжилж, тэр дундаа жендэрийн тэгш байдлын талаарх хандлага сонгуулийн зан төлөвт хэрхэн нөлөөлж буйг тогтоохыг зорихдоо хувь хүний болон улс төрийн хүчин зүйлстэй хослуулан авч үзсэн. Судалгаанд 18–29 насны нийт гурван зуу гаруй сонгогч

санамсаргүй түүврийн аргаар хамрагдсан бөгөөд фактор шинжилгээ, регрессийн шинжилгээ болон кластер шинжилгээг ашиглан дараах үр дүн гаргав. Үүнд:

1. *Хувь хүний түвшний хүчин зүйлс (нас, хүйс, орлого, боловсрол, зан чанар)* нь залуусын санал өгөх шийдвэрт тодорхой хэмжээгээр нөлөөлж буйг регрессийн загвар харуулсан. Ялангуяа нэр дэвшигчийн *нас, боловсрол, зан чанар* нь санал өгөх хүсэлтэд эерэг хамааралтай байв.
2. *Улс төрийн хүчин зүйлс (намын баримжаа, бодлогын байр суурь, мөрийн хөтөлбөр, туршлага)* нь залуусын шийдвэр гаргалтад илүү хүчтэй нөлөөлдөг бөгөөд нэр дэвшигчийн *мөрийн хөтөлбөр, улс төрийн туршлага* хамгийн өндөр нөлөөтэй гарсан.
3. *Жендэрийн тэгш байдлын талаарх хандлага* нь залуусын санал өгөх хүсэлттэй *эерэг хамааралтай* байгаа нь шинжилгээгээр батлагдсан. Өөрөөр хэлбэл, жендэрийн ойлголт өндөртэй, тэгш байдлыг дэмждэг залуус эмэгтэй нэр дэвшигчдэд илүү эергээр ханддаг хандлага ажиглагдсан.
4. Кластер шинжилгээгээр хоёр төрлийн сегмент илэрсэн:
 - *Эерэг жендэрийн хандлагатай сегмент* — жендэрийн эрх тэгш байдлыг сонголтдоо тусгадаг, эмэгтэй нэр дэвшигчийн давуу талыг үнэлдэг, санал өгөх идэвх өндөртэй.
 - *Сөрөг буюу саармаг хандлагатай сегмент* — нэр дэвшигчийн хүйсээс илүү эдийн засгийн асуудал, туршлага, намын баримжааг тэргүүнд тавьдаг, санал өгөх идэвх харьцангуй бага.

Эдгээр үр дүн нь GenZ үеийнхний сонгуулийн зан төлөв улам олон талт болон хувь хүний үнэт зүйл, хүний эрх, нийгмийн шударга ёс гэх мэт шинэ үеийн үнэлэмжүүдээр тодорхойлогдох болсон гэдгийг харуулж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Сонгуулийн байгууллага болон улс төрийн намуудад

- Залуусын жендэрийн мэдрэмжтэй харилцааг нэмэгдүүлэх, мэдээллийн тэгш хүртээмжийг хангах контент, сургалт, олон нийтийн кампанит ажлыг тогтмол зохион байгуулах
- Мөрийн хөтөлбөр, бодлогын мэдээллийг сошиал контент, богино видео, инфографик хэлбэрээр түгээх нь залуу сонгогчдын ойлголт, сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих хүйсийн тэнцвэртэй нэр дэвшүүлэлтийн бодлого цаашид ч үргэлжлэх шаардлагатай.

2. Нэр дэвшигчдэд

- GenZ сонгогчдын онцлогт нийцүүлэн ил тод, баримтад суурилсан, бодлогын чиг баримжаатай харилцааг түлхүү ашиглах
- Нэр дэвшигчийн зан төлөв, хувийн үнэт зүйл залуусын шийдвэрт чухал нөлөөтэй тул өөрийн үнэт зүйл, хувийн зарчим, хүний эрхийн талаарх байр сууриа тодорхой илэрхийлэх

3. Судлаачид болон бодлого боловсруулагчдад

- Залуусын жендэрийн хандлага ирээдүйд улс төрийн төлөөлөлд хэрхэн нөлөөлөхийг урт хугацааны когорт судалгаагаар үргэлжлүүлэн судлах шаардлагатай.
- Хүйсийн талаарх ойлголт нь зөвхөн ёс зүй, хүний эрхийн асуудал биш, улс төрийн оролцооны шинэ хэв шинж болж буйг бодлогын баримт бичигт тусгах нь зүйтэй.

“GenZ” үеийн залуусын санал өгөх шийдвэр нь уламжлалт улс төрийн хүчин зүйлсээс гадна жендэрийн тэгш байдал, хүний эрх, нийгмийн шударга ёс зэрэг шинэ үеийн үнэт зүйлээр тодорхойлогдох болсон нь судалгааны гол ололт байв. Залуусын дунд жендэрийн асуудлыг сонголтдоо тусгадаг, эрх тэгш байдлыг чухалчилдаг сегмент өсөж байгаа нь Монголын ардчилал, төлөөллийн тогтолцоонд эерэг өөрчлөлтийн дохио юм. Иймд сонгуулийн байгууллага, намууд, нэр дэвшигчид залуусын энэхүү шинэ хандлагад нийцсэн стратегийг хэрэгжүүлэх нь ирээдүйн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, чанартай төлөөллийг бий болгох боломжтой гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Alesina, Alberto, & Glaeser, E. L. (2004). *Fighting Poverty in the US and Europe: A World of Difference*. Oxford.
- Antunes, R. (2010). Theoretical models of voting behaviour. *Comunicação e ciências empresariais*, 145-170.
- Bartels, & M.Larry. (2008). *Unequal Democracy: The Political Economy of the New Gilded Age*. Princeton: Princeton University Press.
- Blais, A., Gidengil, E., Nadeau, R., & Nevitte, N. (2004). *Anatomy of a Liberal Victory: Making Sense of the 2000 Canadian Election*. University of British Columbia Press.
- Coffe, H., & Bolzendahl, C. (2011). Gender Gaps in Political Participation Across Sub-Saharan African Nations. *Social Indic Research*, 245-264.
- Dolan, K., & Lynch, T. (214). It Takes a Survey: Understanding Gender Stereotypes, Abstract Attitudes, and Voting for Women Candidates . *American Politics Research*, 656-676.
- Franco, A. C., Clemente, J. T., & Tayag, K. Z. (2025). Influential Factors Affecting Candidate Choice Among First-Time College Voters. *Journal of Interdisciplinary Perspectives*, 107-116.
- Lerdtomornsakul, & Homyamyen, P. (2023). Factors . *Social Sciences Influencing Voting Decision: A Comprehensive Literature Review*, 469.
- O'Cassa, A., & Pecotich, A. (2003). The dynamics of voter behavior and influence processes in electoral markets: a consumer behavior perspective. *Journal of Business Reasearch*, 406-413.
- O'Cassa, A., & Pecotichb, A. (2005). The dynamics of voter behavior and influence processes in electoral markets: a consumer behavior perspective. *Journal of Business Research*, 406-413.
- R.Lau, R., S.Klienberg, M., & M.Ditonto, T. (2018). Measuring voter decision strategies on politacal behaviour and public opinion research. *Public opinion quarterly*, 911-936.
- Rekker, R. (2024). Electoral change through generational replacement: An age-period-cohort analysis of vote choice across 21 countries between 1948 and 2021. *Political Science*, 1-18.

- Rosie Campbell, O. H. (2017). Do Women Vote for Women Candidates? Attitudes toward Descriptive Representation and Voting Behavior in the 2010 British Election. *Politics and Gender*, 209-231.
- Жендэрийн-Хороо. (2025). *Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь*. Улаанбаатар хот: НҮБ.
- Сарантуяа.Г. (2013). Бага ангийн сурагчдын жендэрийн нийгэмшилд үзүүлэх зарим хүчин зүйлийн судалгаа. *Докторын судалгаан ажил*.
- Үүрийнтуяа.Н. (2024). Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоон дахь сонгуулийн тогтолцооны нөлөө. *Mongolian Journal of Humanities and Social Sciences*, 77-86.
- ШУТСан. (2026). *Шинэжлэх Ухаан Технологийн Сан*. Retrieved from <https://data.stf.gov.mn/list/research?q&keyword>
- Элбэгзаяа.Ц. (2021). Жендэрийн удирдлагын тогтолцоог судалсан нь. *Докторын судалгааны ажил*.

МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭГ ОНОВЧЛОХ НЬ

Д.Буяндэлгэр^{1a}

¹Мандах Их Сургууль, Эдийн засаг, бизнесийн тэнхим, ахлах багш, Ph.D

^abuyandelger@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын хүнсний нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг, найдвартай байдлыг дээшлүүлэх зорилгоор логистикийн стратегийн төв байршилыг олон шалгуурт шийдвэр гаргалтын аргаар оновчлон тодорхойлох явдал юм. Судалгаанд *Analytic Hierarchy Process (AHP)* аргыг ашиглан эдийн засаг, нийгэм, дэд бүтэц, байгаль орчин болон логистикийн хүчин зүйлсийг хамарсан нийт 12 шалгуурын ач холбогдлын жинг тодорхойлсон. Үүний дараа *Technique for Order Preference by Similarity to Ideal Solution (TOPSIS)* аргыг ашиглан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Сайншанд гэсэн таван боломжит байршилыг үнэлж, стратегийн төвийн хувилбаруудыг эрэмбэлэв.

Судалгааны тооцооллын үр дүнгээр Улаанбаатар хот хүнсний нийлүүлэлтийн үндэсний хэмжээнд төвлөрсөн логистикийн хаб байгуулахад хамгийн оновчтой байршил болох нь тогтоогдлоо. Үүний дараа Дархан болон Эрдэнэт хотууд харьцангуй өрсөлдөхүйц үнэлгээтэйгээр эрэмбэлэгдсэн бол Чойбалсан, Сайншанд хотууд бүс нутгийн дэд төвийн хувьд давуу талтай боловч үндэсний төвийн түвшинд харьцангуй дундаж үнэлгээтэй гарсан байна.

Энэхүү судалгааны үр дүн нь хүнсний салбарын бодлого боловсруулагчид, логистикийн төлөвлөлт хариуцагчид, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргалтын суурь мэдээлэл өгөхөөс гадна Монгол Улсад нийлүүлэлтийн сүлжээний оновчлолын чиглэл дэх судалгааны хүрээг өргөжүүлж, AHP–TOPSIS аргын практик хэрэглээ, үр ашгийг нотлон харуулж байна.

ТҮЛХҮҮР ҮГ: Хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, Олон шалгуурт шийдвэр гаргалт, AHP, TOPSIS, Логистик оновчлол

ОРШИЛ

Сүүлийн жилүүдэд дэлхийн хүнсний нийлүүлэлтийн сүлжээ уур амьсгалын өөрчлөлт, геополитикийн нөхцөл байдал, цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт, тээвэр логистикийн хямрал зэрэг гадаад хүчин зүйлсийн улмаас тогтворгүй, эмзэг байдалд орж буй нь хүнсний аюулгүй байдал, үнийн тогтвортой байдал, хүртээмжийн асуудлыг дэлхий нийтийн хэмжээнд чухал асуудал болгож байна (FAO, 2023). Хүнсний бүтээгдэхүүн нь хадгалалт, тээвэрлэлтийн хугацаа, температурын нөлөө, чанар алдагдлын өндөр эрсдэлтэй тул нийлүүлэлтийн сүлжээний үр ашигт байдал нь тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурь хүчин зүйлсийн нэг болдог.

Монгол Улсын хувьд өргөн уудам газар нутагтай, хүн амын сийрэг, төвлөрсөн хотжилт бүхий онцлогтой тул хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, түгээлтийн систем нь *хугацаа урт, олон шатлалтай, өртөг өндөртэй* шинж бүхий хэвээр байна. Тухайлбал, нийт хүн амын талаас илүү хувь нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн, харин хүнсний түүхий эдийн үндсэн үйлдвэрлэл нь хөдөө орон нутагт тархан байрладаг бөгөөд дэд бүтцийн хөгжлийн ялгаатай байдал, уур амьсгалын эрс тэс нөхцөл, улирлын хэлбэлзэл зэрэг нь логистикийн үр ашгийг бууруулж, хаягдал, зардал, алдагдлыг нэмэгдүүлдэг (ҮСХ, ХХААХҮЯ, 2023).

Иймд Монгол Улсын хүнсний нийлүүлэлтийн сүлжээг илүү оновчтой, тогтвортой, зардал багатай, эрсдэлд тэсвэртэй хэлбэрт оруулах судалгааны шийдэл зайлшгүй шаардлагатай байна. Өмнө хийгдсэн судалгаануудад нийлүүлэлтийн сүлжээг оновчлох зорилгоор шугаман программчлал (LP), тоон программчлал (ILP), симуляц, оптимизацийн загварууд өргөн ашиглагдсан байдаг. Гэсэн хэдий ч хүнсний нийлүүлэлтийн сүлжээ нь зөвхөн эдийн засгийн параметр бус, харин нийгмийн, байгаль орчны, дэд бүтцийн, эрсдэлийн зэрэг олон хүчин зүйлсийн нийлэмжээр тодорхойлогддог олон шалгуурт шийдвэр гаргалтын (Multi-Criteria Decision Making – MCDM) төвөгтэй систем болох нь судалгаагаар хүлээн зөвшөөрөгдөж байна (Saaty, 2008).

Олон шалгуурт шийдвэр гаргалтын аргууд дундаас Analytic Hierarchy Process (AHP) нь шалгуур хоорондын харьцангуй ач холбогдлыг тогтоох, харин Technique for Order Preference by Similarity to Ideal Solution (TOPSIS) арга нь хувилбаруудыг “хамгийн сайн” ба “хамгийн муу” шийдэлтэй ойр байдлаар үнэлэх давуу талтай бөгөөд нийлүүлэлтийн сүлжээний байршлын сонголт, агуулах хуваарилалт, түгээлтийн төвийн төлөвлөлт зэрэгт өргөн хэрэглэгддэг (Hwang & Yoon, 1981; Saaty, 2008).

Гэвч Монгол Улсын хүнсний салбарын хүрээнд АHP болон TOPSIS аргыг нэгтгэн нийлүүлэлтийн сүлжээний байршлын болон логистикийн бүтцийн оновчилсон шийдлийг тодорхойлсон судалгаа хомс байгаа нь энэхүү судалгааны шинэлэг, практик ач холбогдлыг илэрхийлж байна.

Энэхүү судалгаа нь Монгол Улсын хүнсний хангамжийн логистикийн үр ашгийг дээшлүүлэх, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан шийдвэр гаргалтыг дэмжихэд бодит хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Судалгааны зорилго

Монгол Улсын хүнсний салбарын нийлүүлэлтийн сүлжээг олон шалгуурт шийдвэр гаргалтын (MCDM) аргуудаар үнэлж, хамгийн оновчтой байрлал, логиستيкийн хувилбарыг тодорхойлох.

Иймд энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Монгол Улсын хүнсний нийлүүлэлтийн сүлжээг олон шалгуурт шийдвэр гаргалтын АНР–TOPSIS нэгдсэн загвараар үнэлж, агуулах, хуваарилах төв байгуулах хамгийн оновчтой байршлыг тодорхойлоход оршино.

Зорилгын хүрээнд дараах судалгааны зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Хүнсний нийлүүлэлтийн сүлжээний байршлын үнэлгээнд нөлөөлөх 12 шалгуурыг тодорхойлох
- АНР аргаар шалгуур бүрийн харьцангуй жинг тогтоох
- TOPSIS аргаар сонгосон 5 байршлын хувилбарыг харьцуулан оновчтой хувилбарыг эрэмбэлэх
- Судалгааны үр дүнд тулгуурлан бодлогын болон практик зөвлөмж боловсруулах

Судалгааны үндсэн асуултууд

1. Хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд хамгийн чухал нь аль шалгуур вэ?
2. Монгол Улсад хүнсний логиستيкийн төв байршуулахад аль бүс илүү тохиромжтой вэ?

Хамрах хүрээ

Энэхүү судалгаанд нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь загварчлах бус харин сүлжээний үндсэн бүтэц, гүйцэтгэлд хамгийн их нөлөө үзүүлэгч байршлын шийдвэрийг олон шалгуурт шийдвэр гаргалтын аргаар (MCDM) оновчлох замаар нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх боломжийг судалсан болно.

Судалгааны арга зүй

Монгол Улсын хүнсний салбарын нийлүүлэлтийн сүлжээг оновчлох зорилгоор олон шалгуурын шийдвэр гаргалтын (Multi-Criteria Decision Making – MCDM) аргуудыг ашиглав. Судалгаанд АНР (Analytic Hierarchy Process) аргаар шалгуурын жинг тодорхойлж, TOPSIS (Technique for Order Preference by Similarity to Ideal Solution) аргаар байршлын альтернатив хувилбаруудыг эрэмбэлэн үнэлэв.

Судалгааны бүтэц нь дараах үе шаттай:

1. Шалгуурыг тодорхойлох (Criteria identification)
2. АНР арга ашиглан шалгуурын жин тодорхойлох
3. Альтернатив хувилбаруудыг үнэлэх
4. TOPSIS ашиглан эрэмбэлэх
5. Оновчтой байршлыг тодорхойлох

Судалгааны үр дүн

Монгол Улсын хэмжээнд нийлүүлэлтийн сүлжээний байрлалын оновчлолыг тодорхойлох зорилгоор стратегийн ач холбогдол бүхий таван боломжит байршлыг сонгон авч шинжилгээнд хамруулсан. Сонгосон байршлууд нь үндэсний хэмжээний

логистикийн урсгал, эдийн засгийн төвлөрөл, хүн амын суурьшил, тээврийн дэд бүтцийн уялдаа холбоо, бүс хоорондын бараа эргэлтийн чиглэл зэрэг олон шалгуурыг харгалзан сонгогдсон болно. Сонгогдсон таван байршил болон тэдгээрийг сонгох үндэслэл дараах байдлаар тодорхойлогдсон.

Хүснэгт 1. Байршлын сонголт

Байршил	Онцлог	Ач холбогдол	Үндэслэл
Улаанбаатар	Монгол Улсын нийслэл бөгөөд хүн ам, зах зээлийн төвлөрөл хамгийн өндөртэй.	авто болон төмөр замын гол зангилаа байрлах, олон улсын боомтууд руу холбогдох гол тээврийн төв	Зах зээлд ойр байдал, өндөр эрэлт, дэд бүтцийн хөгжсөн байдал, уян хатан ложистикийн үйл ажиллагааг хангах боломж
Дархан	Хойд бүсийн эдийн засгийн гол төв, үйлдвэр, үйлдвэрлэлийн хүнд салбарын суурин.	Улаанбаатар, Сэлэнгэ, Сэлэнгэгийн төмөр замын холболт сайтай, экспортын болон дотоодын тээвэрлэлтийн гол зангилаа.	Эдийн засгийн идэвхжил өндөр, тээвэрлэлтийн зардлыг бууруулах боломжтой.
Эрдэнэт	Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн төв, уул уурхайн гол бүс.	Төмөр зам, авто замын холболт сайтай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн нийлүүлэх гол зангилаа.	Бараа бүтээгдэхүүний төвлөрөл, дотоодын эрэлтэд хурдан хариу үзүүлэх боломж.
Чойбалсан	Зүүн хязгаарт орших гол төв, хил орчмын худалдаа, экспортын гол чиглэлд байрлах.	Олон улсын тээвэр, хил гаалийн боомттой ойр, зүүн бүс нутгийн бараа эргэлтийг дэмжих стратегийн цэг.	Улсын бүсчлэлийн хөгжлийн бодлого, хил орчмын ложистикийн урсгалыг дэмжих боломж.
Сайншанд	Говийн бүсийн дэд бүтэц, авто замын зангилаа, төвийн бүс рүү холбогдох гол цэг.	Улаанбаатар, Дорноговь, Замын-Үүд чиглэлд тээврийн холболт сайтай, өргөтгөх боломжтой газар нутаг.	Газрын нөөц, агуулах байгуулах боломж, урт хугацааны ложистикийн үйл ажиллагаанд стратегийн ач холбогдолтой.

Судалгаанд ашигласан шалгуур үзүүлэлтүүдийн сонголт

Судалгаанд Монгол Улсын хүнсний салбарын нийлүүлэлтийн сүлжээг оновчлох зорилгоор олон шалгуурт шийдвэр гаргалтын (Multi-Criteria Decision Making, MCDM) аргыг ашигласан бөгөөд логистикийн төв / агуулах байршлыг сонгох үйл ажиллагааг эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон логистикийн дөрвөн үндсэн хэмжигдэхүүнээр үнэлэх үзүүлэлтүүдийг сонгон тодорхойлов. Шалгуур бүр нь нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг, тогтвортой байдал болон үйлчилгээний чанарт шууд болон шууд бус нөлөө үзүүлдэг тул онолын болон практик үндэслэлд тулгуурлан сонгогдсон.

Хүнсний нийлүүлэлтийн сүлжээний байршлыг үнэлэхэд дараах 4 бүлэг, 12 шалгуурыг сонгон ашиглав (Хүснэгт 1):

Хүснэгт 2. Шалгуурын сонголт

Бүлэг	Код	Шалгуур	Ач холбогдол
Эдийн засаг	C1	Тээврийн зардал	Тээврийн зардал нь нийлүүлэлтийн сүлжээний нийт зардлын хамгийн том бүрэлдэхүүн хэсэгт тооцогддог. Агуулах болон түгээлтийн төвийн байршил нь үндсэн зах зээл, нийлүүлэгч болон хэрэглэгчдэд ойр байх нь логистикийн зардлыг бууруулж, нийлүүлэлтийн системийн нийт үр ашгийг нэмэгдүүлнэ.
	C2	Дэд бүтэцтэй ойр байдал	Ус, цахилгаан эрчим хүч, интернэт, түлш хангамж, авто болон төмөр зам зэрэг үндсэн дэд бүтэц нь агуулах, логистикийн төвийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааны суурь нөхцөл болдог.
	C3	Агуулах байгуулах зардал	Агуулахын газар худалдан авах, барилга байгуулах, тоног төхөөрөмж суурилуулах зэрэг анхны хөрөнгө оруулалтын зардал нь байршлын сонголтод шууд нөлөөлдөг.
Нийгэм	C4	Ажиллах хүчний хүртээмж	Нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг хүний нөөцийн чанар, хүртээмжээс мөн хамаарна.
	C5	Хүн амын нягтаршил	Хүн амын нягтаршил нь зах зээлийн багтаамж, эрэлт хэрэгцээ, хэрэглээний боломжийг илэрхийлэх чухал үзүүлэлт юм.
	C6	Зах зээлд ойр байдал	Энэхүү шалгуур нь агуулах байрших цэгээс үндсэн хэрэглэгч, зах зээл, худалдааны төвүүд хүртэлх зайн хэмжигдэхүүнийг илэрхийлнэ.
Байгаль орчин	C7	CO ₂ ялгаруулалт	Орчин үеийн нийлүүлэлтийн сүлжээний оновчлол нь зөвхөн эдийн засгийн бус, экологийн тогтвортой байдлыг мөн харгалзан үзэхийг шаарддаг.
	C8	Газар ашиглалт	Агуулах байгуулж буй газар нь хөдөө аж ахуйн газар, ногоон бүс, усны эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлж болох эрсдэлтэй байдаг.
	C9	Байгалийн эрсдэл	Үер, газар хөдлөлт, цас зуд, шороон шуурга зэрэг байгалийн гамшгийн эрсдэл нь нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө.
Логистик	C10	Замын чанар	Зам тээврийн нөхцөл нь бараа бүтээгдэхүүн тээвэрлэх хурд, аюулгүй байдал, зардалд шууд нөлөөлдөг.
	C11	Хүргэлтийн хугацаа	Хүнсний бүтээгдэхүүн нь хадгалалтын хугацаа богино байдаг тул агуулахаас хэрэглэгчид хүрэх хүртэлх хугацааг багасгах нь бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үндэс суурь болдог.
	C12	Уян хатан байдал	Уян хатан байдал нь эрэлт, улирлын хэлбэлзэл, замын саатал, цаг агаарын өөрчлөлт зэрэг нөхцөл байдалд хурдан дасан зохицох чадамжийг илэрхийлнэ.

1. АНР аргаар шалгуурын жин тодорхойлох

Нийлүүлэлтийн сүлжээг оновчлох зорилгоор тодорхойлсон 12 шалгуурын харьцангуй ач холбогдлыг тогтоохын тулд Analytic Hierarchy Process – АНР аргыг ашиглав. АНР аргыг Thomas L. Saaty (1980) боловсруулсан бөгөөд олон шалгуурт шийдвэр гаргалтын хүрээнд өргөн ашиглагддаг арга юм. Analytic Hierarchy Process (АНР) аргачлалаар эдгээр шалгуурт харьцангуй ач холбогдлын дагуу жин оноосон. Үүнийг мэргэжилтний үнэлгээн дээр үндэслэн pairwise comparison matrix ашиглан тооцоолсон. АНР аргыг ашиглан логистикийн төвийн байршлыг үнэлэхдээ дараах шалгуур үзүүлэлтүүдийг тус бүрт нь тодорхой жингээр үнэлсэн. Үүнд: Тээврийн зардал 15 хувь, дэд бүтэцтэй ойр байдал 12 хувь, агуулах байгуулах зардал, хүргэлтийн хугацаа тус бүр 10 хувь, ажиллах хүчний хүртээмж 7 хувь, хүн амын нягтаршил 6 хувь, зах зээлд

ойр байдал 8 хувь, CO₂ ялгаруулалт 7 хувь, газар ашиглалт 5 хувь, байгалийн эрсдэл 6 хувь, замын чанар 9 хувь, уян хатан байдал 5 хувийн жинтэйгээр тооцоологдсон. Жингийн эдгээр үнэлгээг хийхдээ АНР аргын нийцлийн итгэлцүүр (Consistency Ratio, CR)-ийг тооцоолсон ба $CR < 0.1$ буюу 10 хувиас бага гарсан тул энэхүү жингийн хуваарилалт нь логик нийцтэй, найдвартай гэж үзэж болно. Ингэснээр уг үнэлгээ нь нийлүүлэлтийн сүлжээний байршлыг шинжлэхэд бодитой үндэслэл болно.

Хүснэгт 3. АНР жингийн оноолт

Шалгуур үзүүлэлт	АНР жин (%)
Тээврийн зардал	15%
Дэд бүтэцтэй ойр байдал	12%
Агуулах байгуулах зардал	10%
Ажиллах хүчний хүртээмж	7%
Хүн амын нягтаршил	6%
Зах зээлд ойр байдал	8%
CO ₂ ялгаруулалт	7%
Газар ашиглалт	5%
Байгалийн эрсдэл	6%
Замын чанар	9%
Хүргэлтийн хугацаа	10%
Уян хатан байдал	5%

Тээврийн зардал (C1) хамгийн өндөр ач холбогдолтой (0.1482), үүний дараа Дэд бүтэцтэй ойр байдал (C2), Хүргэлтийн хугацаа (C11), Агуулах байгуулах зардал (C3) нь чухал хүчин зүйлсийн тоонд орж байгаа нь харагдаж байна. Энэ нь Монгол Улсын газар нутгийн өргөн уудам байдал, тээврийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл, мөн хүнсний бүтээгдэхүүний цаг хугацаанд мэдрэг шинж чанартай шууд хамааралтай юм.

Иймд дээрх жингүүдийг дараагийн шатны TOPSIS аргаар байршлын хувилбаруудын оновчлол хийх үндсэн оролт өгөгдөл болгон ашигласан болно.

Альтернатив хувилбаруудыг үнэлэх:

Судалгаанд ашигласан шийдвэрийн матриц нь таван байршлыг 12 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд үнэлгээг 1–10 онооны шугаман системээр тодорхойлсон. Энэ систем нь логистикийн хүчин зүйлсийн хоорондын ялгааг илүү нарийвчлалтай илэрхийлэх боломж олгож, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдийг тоон хэлбэрт хөрвүүлэхэд илүү тохиромжтой гэж үзсэн. Шалгуур бүрийн үнэлгээ нь статистик мэдээлэл, экспертүүдийн мэргэжлийн дүгнэлт болон судлаачийн шинжилгээнд тулгуурлан нэгтгэсэн нийлмэл оноо бөгөөд TOPSIS аргачлалаар эцсийн үнэлгээг хийх суурь матриц болж ашиглагдсан.

Хүснэгт 4. Альтернатив хувилбаруудын үнэлгээ

Байршил	Тээврийн зардал	Дэд бүтэцтэй ойр байдал	Агуулах байгуулах зардал	Ажиллах хүчний хүртээмж	Хүн амын нягтаршил	Зах зээлд ойр байдал	CO ₂ ялгаруулалт	Газар ашиглалт	Байгалийн эрсдэл	Замын чанар	Хүргэлтийн хугацаа	Уян хатан байдал
Улаанбаатар	9	9	8	9	10	10	6	4	3	9	9	8
Дархан	7	7	6	8	6	7	7	6	5	7	7	7

Эрдэнэт	6	7	6	6	5	6	6	6	6	6	6	6
Чойбалсан	4	5	4	4	3	3	5	7	7	4	5	5
Сайншанд	5	6	5	5	4	5	6	6	6	5	5	6

Эдгээр нь хүн ам, дэд бүтэц, логиستيкийн ач холбогдол бүхий зангилаа бүсүүд юм.

TOPSIS аргаар альтернатив хувилбаруудыг эрэмбэлэх

Шалгуурын жингүүдийг АНР (Analytic Hierarchy Process) аргаар тодорхойлсны дараа боломжит байршлуудыг эрэмбэлэх, хамгийн тохиромжтой хувилбарыг сонгох зорилгоор TOPSIS (Technique for Order Preference by Similarity to Ideal Solution) аргыг ашиглав. TOPSIS арга нь олон шалгуурын үнэлгээнд суурилан, хамгийн сайн (эерэг идеал) болон хамгийн муу (сөрөг идеал) шийдэлд ойролцоо байдлаар хувилбаруудыг үнэлж, эрэмбэлдэг онцлогтой.

TOPSIS аргаар дараах үндсэн алхмуудыг хийв:

Алхам 1: Өгөгдлийг нормчлох $r_{ij} = \frac{x_{ij}}{\sqrt{\sum_j (x_{ij})^2}}$

Энд:

- x_{ij} — i-р альтернативийн j-р шалгуурын үнэлгээ
- r_{ij} — нормчлогдсон утга

Алхам 2: Жинтэй нормчлогдсон матриц

$$V_{ij} = w_j \cdot r_{ij}$$

Алхам 3: Эерэг ба сөрөг идеал шийдэл

Cost шалгуурын хувьд:

cost (C1, C3, C7, C8, C9, C11): Ideal = $\min(V_{ij})$, Anti-ideal = $\max(V_{ij})$

Benefit шалгуурын хувьд:

benefit (C2, C4, C5, C6, C10, C12): Ideal = $\max(V_{ij})$, Anti-ideal = $\min(V_{ij})$

Алхам 4: Ойрын зайг тооцох

Cost шалгуурын хувьд

$$D_i^+ = \sqrt{\sum_j (V_{ij} - \text{Ideal Best}_j)^2}$$

Benefit шалгуурын хувьд:

$$D_i^- = \sqrt{\sum_j (V_{ij} - \text{Ideal Worst}_j)^2}$$

Алхам 5: Эцсийн оноо (Relative Closeness)

TOPSIS оноо: $C_i = \frac{D_i^-}{D_i^- + D_i^+}$

Оновчтой байршлыг тогтоох нь

Судалгааны хүрээнд сонгосон таван байршлыг АНР аргаар тогтоосон жингүүдийг ашиглан TOPSIS аргачлалаар үнэлсэн. Үр дүн нь C_i утга буюу эерэг идеал шийдэлд ойр байдал, мөн эрэмбэлсэн бөгөөд өндөр C_i утга нь тухайн байршлыг нийлүүлэлтийн сүлжээг оновчтой хөгжүүлэхэд илүү тохиромжтой болохыг харуулж байна.

Хүснэгт 5. Үр дүн

Байршил	D_i^+ (Эерэг зай)	D_i^- (Сөрөг зай)	C_i	Эрэмбэ
Улаанбаатар	0.065575	0.073192	0.527446	1
Сайншанд	0.057739	0.057427	0.498645	2
Дархан	0.051140	0.050017	0.494449	3
Эрдэнэт	0.052161	0.049856	0.488704	4
Чойбалсан	0.072983	0.066270	0.475894	5

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд стратегийн ач холбогдол бүхий төв байршлыг тодорхойлох зорилгоор олон шалгуурт шийдвэр гаргалтын арга зүйг ашиглан үнэлгээ, тооцооллыг хийв. Судалгаанд нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг тодорхойлоход нөлөөлдөг эдийн засаг, нийгэм, байгаль орчин, логистикийн дөрвөн бүлэгт хамаарах арван хоёр шалгуурыг сонгон авч, тэдгээрийн харьцангуй чухлыг АНР загвараар тооцоолон жин үүсгэлээ. Дараа нь таван байршлын хувилбар (Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Сайншанд)–ыг сонгон, шийдвэрийн матрицад оруулж, TOPSIS аргаар үнэлэн эрэмбэлэв.

Судалгааны үр дүнгээс харахад Улаанбаатар хот нь нийт шалгуурын огтлолцлын хувьд хамгийн өндөр нийлмэл оноотой гарч, хүнсний нийлүүлэлтийн сүлжээний стратегийн төвд хамгийн тохиромжтой байршил болох нь тогтоогдов. Энэ нь Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжил, тээврийн зангилаа төвлөрөл, хүн амын нягтаршил, зах зээлийн эрэлт болон агуулахын хүчин чадлын давуу талтай шууд холбоотой байна. Мөн логистикийн гол маршрутын уулзвар төв байршлын хувьд Улаанбаатар хот нь бусад дөрвөн хувилбартай харьцуулахад илүү өрсөлдөх чадвартай болох нь батлагдав.

Дархан, Эрдэнэт хотууд дундаж түвшний үнэлгээтэй гарсан нь бүс нутгийн түвшинд тодорхой боломжууд байгааг харуулж байгаа ч үндэсний хэмжээний төв байршлын шаардлага хангах хэмжээнд хараахан хүрээгүй байна. Харин Чойбалсан, Сайншанд хотууд нь тодорхой шалгууруудад (жишээлбэл: газар ашиглалт, байгалийн эрсдэл, төмөр замын холболт) давуу талтай боловч нийт нийлмэл үзүүлэлтээр Улаанбаатар болон бусад төвийн хотуудаас доогуур үнэлэгджээ.

Энэ судалгаа нь Монгол Улсын хүнсний нийлүүлэлтийн сүлжээг оновчтой байршлын төлөвлөлтөд тулгуурлан сайжруулахад үндэслэл бүхий арга зүйг санал болгож байгаа бөгөөд цаашид бүсчилсэн түвшний төвүүдийг тодорхойлох, эрэлт–боловсруулалт–түгээлтийн урсгалын уялдааг сайжруулах, нийлүүлэлтийн хэлхээний дэд бүтцийг оновчлох зэрэг чиглэлээр үргэлжлүүлэх боломжтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Saaty, T. L. (1980). *The Analytic Hierarchy Process*. New York, NY: McGraw-Hill.
- Saaty, T. L., & Vargas, L. G. (2012). *Models, Methods, Concepts & Applications of the Analytic Hierarchy Process*. Springer. <https://doi.org/10.1007/978-1-4614-3597-6>
- Hwang, C. L., & Yoon, K. (1981). *Multiple Attribute Decision Making: Methods and Applications*. Berlin: Springer-Verlag.
- Chen, C. T. (2000). Extensions of the TOPSIS for group decision-making under fuzzy environment. *Fuzzy Sets and Systems*, 114(1), 1–9. [https://doi.org/10.1016/S0165-0114\(99\)00055-1](https://doi.org/10.1016/S0165-0114(99)00055-1)
- Chen, S. J., & Hwang, C. L. (1992). *Fuzzy Multiple Attribute Decision Making: Methods and Applications*. Berlin: Springer-Verlag.
- Dolgui, A., & Proth, J. M. (2010). *Supply Chain Engineering: Useful Methods and Techniques*. London: Springer. <https://doi.org/10.1007/978-1-84996-114-0>
- Chopra, S., & Meindl, P. (2019). *Supply Chain Management: Strategy, Planning, and Operation* (7th ed.). Pearson.
- Mongolian National Statistical Office (NSO). (2024). *Population and urban statistics of Mongolia*. Ulaanbaatar, Mongolia: NSO. Retrieved from <https://www.1212.mn/>
- Ministry of Road and Transport Development of Mongolia. (2023). *National Road Network and Transport Infrastructure Report*. Ulaanbaatar, Mongolia.
- Mongolian National Emergency Management Agency. (2023). *Natural Hazards and Risk Assessment in Mongolia*. Ulaanbaatar, Mongolia.
- World Bank. (2022). *Mongolia: Logistics Performance and Infrastructure Overview*. Washington, DC: World Bank Group. <https://www.worldbank.org/en/country/mongolia>

ҮЗЭМЧИН ӨВ СОЁЛЫН ДАРХЛААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Санжмятав Ганцэцэг^{1a}, Сумъяа Сайнзаяа^{2b}

¹Мандах Их сургууль, Гадаад хэлний тэнхим, дэд профессор, Ph.D

²Мандах Их сургууль, Гадаад хэлний тэнхим, багш

^agantsetseg@mandakh.edu.mn

^bsainzaya@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа нь үзэмчин ястны өв соёл, соёлын дархлааны өнөөгийн байдал, өв соёлыг хамгаалах, дамжуулах байдлыг судлан дүгнэсэн. Судалгааны асуулгыг үзэмчин ястны дунд 7 бүлэг 24 багц асуулт бүхий асуулга боловсруулан цахим хэлбэрээр явуулж нийт 86 хүний санал, 4 нээлттэй асуулгаар нутгийн ахмад үзэмчин нартай ярилцлага хийж судалгааны түүвэр болгон ашигласан. Судалгааны өгөгдөлд статистик болон өгүүлэмжийн шинжилгээ хийж дискретив дүгнэлт өгсөн. Шинжилгээний үр дүнд үзэмчин хүмүүс уламжлалт баяр ёслолыг тэмдэглэх, үндэсний хувцас гоёлоо хэрэглэх замаар ястны соёл уламжлалаа хадгалан, дамжуулж улмаар эдгээр соёлын элементүүд үзэмчин хүмүүсийн үнэт зүйлсийн ухамсарт чухал байр суурьтай байгааг илрүүллээ. Ийнхүү үзэмчний баяр ёслол, амьдралын хэв маяг, уламжлалт зан үйлээр дамжуулан язгуур өв соёлоо хадгалах, өвлөх, дамжуулах байдал түгээмэл байна. Хэдий тийм ч судалгаанд оролцогчдын үзэмчин угсаатны түүхийн талаарх мэдлэг болон үзэмчин хэлний хэрэглээ бага байгаагийн зэрэгцээ аман болон бичгийн хэлбэрээр үзэмчин өв соёлоо хадгалах, дамжуулах уламжлал сул байгаа үр дүн гарлаа. Үүний зэрэгцээ үзэмчин соёлын өвийг хамгаалах, дамжуулахад угсаатны онцлог, соёлын бодлого, гэр бүлийн хүмүүжил зэрэг дотоод хүчин зүйлс давамгайл нөлөөтэй байна. Түүнчлэн орон нутгийн хөгжлийн бодлого болон боловсролын оролцоог нэмэгдүүлснээр өв соёлыг тогтвортой хадгалах боломж бүрдэх юм. Харин төрийн бодлого болон институтийн түвшний арга хэмжээнүүд үзэмчин соёлын дархлаанд хангалттай нөлөөлөхгүй байгааг бодлогын түвшинд анхаарах шаардлагатай байна.

ТҮЛХҮҮР ҮГ: Угсаатны өв соёл, Үзэмчин ястан, Соёлын үнэт зүйлс, Уламжлалт зан үйл

ОРШИЛ

Хүн төрөлхтөн бүтээж бий болгосон соёлын өв, үнэт зүйлсээ хадгалж хамгаалах, дараа үеийнхэнд өвлүүлэн үлдээх нь улс үндэстэн оршин тогтнох, хөгжин дэвжих үндэс болдог гэж үздэг. Байгалийн болон соёлын өв нь зөвхөн тухайн үндэстэнд төдийгүй хүн төрөлхтөнд нийтлэг үнэ цэнтэй тул түүнийг хамгаалах нь бүх дэлхийн улс орнуудын хамтын үүрэг гэж үздэг. Үе дамжин уламжлагдаж ирсэн соёлын үнэ цэнтэй зүйлсийг "өв" хэмээн нэрлэдэг. Соёлын биет бус өв гэдэг нь тухайн ард түмний сэтгэлгээ, оюуны бүтээл, амьдрах ухаан, уламжлал, хэл, урлаг, гар урлал зэрэг тухайн үндэстний онцлогийг илэрхийлдэг соёлын цогц үзэгдэл юм. 2003 онд ЮНЕСКО-гийн баталсан “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцид энэ төрлийн өвийг таван төрөлд ангилсан. Үүнд аман уламжлал ба хэл, урлагийн илэрхийлэл, зан заншил ба баяр ёслол, байгаль ба сав ертөнцийн мэдлэг, уламжлалт гар урлал багтдаг. (Байгаль, соёлын өвийг хамгаалах сан, 2019)

Монгол Улс уг өвийг анх “Утга соёлын өв” гэж нэрлэж байсан бол 2010 оноос "Соёлын биет бус өв" гэж нэрлэх болсон. Өвийг эзэмшигч буюу "өвлөн уламжлагч" гэдэг нь тухайн өвийг өндөр түвшинд эзэмшиж, уламжлуулж чадах мэдлэгтэй хувь хүн, хамт олон, ураг төрлийн бүлгийг хэлдэг.

Монголчууд нүүдэлчин соёл иргэншлээ шингээсэн биет бус өвийн арвин сан хөмрөгтэй. Үүнд уламжлалт уртын дуу, хөөмий, бие биелгээ, үлгэр домог, гар урлал, ахуйн хэрэглэлийн уламжлал зэргийг багтаадаг. Соёлын өвийг түүхэн дурсгал (суурин үл хөдлөх зүйлс), хөдөлгөөнт өв (ахуйн эд өлгийн зүйлс), оюуны өв (хэл, урлаг, зан заншил) гэсэн гурван ангилалд хуваан үздэг. Монголчууд үе дамжсан өв соёлоо хамгаалж, хойч үедээ уламжлуулахыг эрхэмлэдэг. “Эмээл хазаараа үр хүүхдүүддээ дамжуулдаг” уламжлал нь соёлын дархлаа тогтоох гол арга хэрэгсэл юм. 1994, 2001, 2014 онуудад соёлын өвийн талаарх хууль шинэчлэгдэн, төрийн бодлого нь соёлын өвийг судалж, хадгалж, сэргээн засварлаж, сурталчилж, ашиглахад чиглэж ирсэн. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд ч “Соёлын өв байхгүй бол Монгол оршин тогтнохгүй” гэсэн ойлголт тусгалаа олсон. (Б.Даваацэрэн, 2016)

Гэвч даяаршлын нөлөөгөөр уламжлалт хэрэглээний зүйлс мартагдаж, өв соёлоо алдаж буйг соёл судлаачид анхааруулж байна. Өнөөгийн нийгэмд биет бус өвийг хамгаалах, өвлүүлэх ажил нь зөвхөн соёлын байгууллагын үүрэг биш, хүн бүрийн оролцоо шаардлагатай. Монгол улс биет бус өвийг эх хэл, язгуур урлаг, уламжлалт зан үйл, байгаль дэлхийтэй холбоотой мэдлэг, гар урлал гэсэн таван ай савд ангилан, 88 төрлөөр бүртгэж хамгаалж байна. (Л.Пүрэвхам, 2019)

Төрийн зүгээс соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх, иргэдийг соёлын мэдлэгтэй болгож, үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулах бодлого хэрэгжүүлж байна. Соёл нь үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа бөгөөд нийгмийн эв нэгдэл, хөгжлийн тулгуур болохыг онцолж байна. (Б.Эрдэнэбат, 2019). Даяаршил, хотжилт, техник технологийн хөгжлийн нөлөөгөөр хүн амын цөөнхийг эзэлж буй зарим ястны өв соёлын зарим хэлбэрүүд мартагдах, өвлөн уламжлуулахтай холбоотой асуудал бий болж байна.

Тогтвортой хөгжил 2030-ийн зорилтуудын хүрээнд соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, дамжуулах соёлын олон янз байдлыг ойлгох, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг бодлогын чанартай хэрэгцээнд үндэслэн үндэстэн, ястны соёлын дархлааны асуудалд хандах шаардлага байна.

Монгол улсын үзэмчин ястан нь соёлын биет бус өв(хувцас, дуу, яруу найраг, уламжлалт мал аж ахуй)-өөр баялаг, олон зуун жилийн түүхтэй ард түмэн бөгөөд Монгол улсын хувьд Улаанбаатар хот, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Дорнод аймгийн 4 суманд голчлон суурьшдаг. Үзэмчин ястны өв соёл нь түүхэн үнэт зүйл байгаад зогсохгүй монгол үндэстний соёлын дархлааны чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг болох юм. Дээр дурьдсанчлан монгол улсад амьдарч байгаа ястны соёлын өв уламжлалтай холбоотой асуудлын хүрээнд үзэмчин ястны соёлын дархлааны өнөөгийн төлөв байдлыг судлах хэрэгцээ байна.

Судлагдсан байдал

Соёлын дархлаа гэж юу болох талаар дотоодын болон гадаадын эрдэмтэн судлаачдын үзэл хандлагаас харахад энэхүү ойлголт нь сэтгэл судлал, улс төр судлал, шашны хүчин зүйлс, физиологи, хувь хүний сэтгэл зүй, үндэстний хэл соёлын асуудал зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийн нийлбэрт оршин байдаг зүйл болохыг харж болно. Соёлын дархлаа гэж юу болох талаар дотоодын болон гадаадын эрдэмтэн судлаачдын өөр өөрийнхөө үзэл хандлагаас тайлбарласан байдаг.

Профессор Лоуренс Ж.Кирмаер, Жеймс В.Пеннебекер болон эрүүл мэндийн сэтгэлзүйч Рожер Ж.Бүүт нар соёлын дархлааны асуудлыг хүн төрөлхтний эх хэлнийх нь асуудалтай холбон тайлбарлаж үндэстний соёлын чухал хэсэг нь хэлний соёл юм гэж тодорхойлсоныг эрдэмтэн Ж.Долгорсүрэн, Б.Мөнхбадрал нар онцолсон байна. Улмаар тус эрдэмтэд аль нэг үндэстний хэлэн дэх гадны соёлын нөлөө тухайн үндэстний соёлын дархлаанд нөлөөлдөг болохыг чухалчлан тэмдэглэсэн байна. Түүнчлэн аливаа хэлний үндэстний онцлогийг илэрхийлдэг зүйрлэлээр ард түмний соёлын үнэлэмж илэрч улмаар үндэстэн ястны соёлын дархлааг тогтоодог болохыг эрдэмтэн Жеймс Т.Вильс ба Лари Ж.Прайс нарын тайлбарласныг эш татсан байна (Ж.Долгорсүрэн, Б.Мөнхбадрал, 2017). Нийгмийн шинжлэх ухааны судлаач эрдэмтэд соёлын дархлааны тогтолцоог илүү танин мэдэх, холбогдох онолыг боловсруулах зайлшгүй хэрэгцээ байна. Үүнтэй холбоотойгоор соёлын уусал, сарнил гэх мэт ойлголтуудыг ухамсарлах нь соёлын дархлааг тогтвортой хадгалах, хамгаалах үндэс болно гэж үзжээ (Ж.Долгорсүрэн, Б.Мөнхбадрал, 2017). Үндэстэн ястны сэтгэл зүйн үүднээс соёлын дархлааг хүний сэтгэл зүй, ухамсрын түвшинд буюу оюун санааны, хүний бие бодгалийн түвшинд буюу хувцас соёлын, угсаатны томоохон соёлын гэсэн гурван хүрээнд авч үзсэн байдаг. (Ж.Долгорсүрэн, Б.Мөнхбадрал, 2017)

Монгол улсын хэмжээнд соёл судлаач Б.Сумъяа доктор өнөөгийн монголын ард түмний соёл нь гарваль зүйн хувьд ялгаатай хэдий ч өөр хоорондоо харилцан холбоо хамааралтай, язгуур, уламжлалт, олдмол, үүсмэл гэсэн дөрвөн мах бодоос бүрддэг бөгөөд энэхүү онцлог нь түүний өөрийгөө хадгалж, оршин амьдрах нөхцлийг бүрдүүлж байгаа дархлалын механизм юм хэмээн “Монголын нүүдэлчдийн соёл: оршихуй, эх оршихуй” бүтээлдээ дурьдсан байдаг. Мөн тэрээр энэхүү бүтээлдээ үндэстний соёлын

өвөрмөц байдал, түүний дахин давтагдашгүй чанар нь өөрийн өнгө байдалтайгаар оршин тогтнох нь зүйтэйг мөн онцолсон байдаг. (Б.Сумъяа, 1998)

МУСГЗ, яруу найрагч Г.Мэнд-Ооёо “Монголчууд соёлын дархлаагаа үлгэр домогтоо хадгалдаг” хэмээгээд үндэсний соёлын нарийн элемент нь аман зохиолд хадгалагддаг бөгөөд түүгээрээ Монгол хүнийг хүмүүжүүлдэг байсныг илэрхийлсэн байна.

Доктор С.Дулам Соёл оюуны дархлаа нимгэрснээр дуураймхай чанар ихэсдэг болохыг онцлоод хүн байгалиас заяасан дууриах маягаар явснаар сэтгэлгээний хэлбэрийн хувьд үгээгүй ядуу болж хувирч байна хэмээсэн. Мөн тэрээр амьдралын утга учир нь өөрийнхөө хэдэн үеэрээ уламжлан залгамжилж ирсэн соёл уламжлалаа үр хойчдоо өвлүүлэх, түүнийхээ төлөө алхам хийх, амьдрах гэдэг ойлголт бусад соёлт улс орнуудад байдаг. Харин монголын хувьд нүүдэлчин соёлтой учир цээж эрдэм, биет соёл ихтэй. Биет бус зүйл чинь үрэгдэх, мартагдах, үгүй болох аюултай гэдгийг ойлгож ухамсарлах нь зүйтэй талаар өгүүлсэн байна. (Ж.Долгорсүрэн, Б.Мөнхбадрал, 2017)

Үзэмчин ястны соёлын дархлааны өнөөгийн байдлын талаар онцгойлон авч үзсэн ном, судалгаа, бүтээлүүд хомс байгаа ч үзэмчин ястны түүх, соёлын талаар хийгдсэн олон судалгаа, ном бүтээлүүд байна. Урлаг судлалын ухааны доктор А.Тогтохын “Үзэмчин уртын дууны уламжлал ба өв сангийн судалгаа”-ны ажилд дурдагдсанаар 2000 оноос хойш үзэмчин ястан түүх, соёлын чиглэлээр ойролцоогоор 20 орчим судалгааны ажил, ном, эмхэтгэлүүд хэвлэгдэн гарсан байна. Жишээлбэл, Үзэмчиний түүх, угсаатны зүйн сэдвээр Го.Равхаа, Ц.Сэцэнхүү нарын “Үзэмчин аймаг” (2012), Д.Наранцэцэгийн “Үзэмчиний түүх, соёлын ойллого” (2012), У.Ёндонгийн “Үзэмчин угсаатны түүх, соёлын товч” (2019) зэрэг бүтээлүүдийг дурьдаж болно. Харин уртын дууны судалгааны хүрээнд Н.Бөххадын 2005 онд туурвисан “Үзэмчин ардын домогт дуу”, “Монгол уртын дууны өлгий-Үзэмчин” зэрэг өгүүллийн эмхэтгэл, Т.Санжээгийн “Үзэмчин ардын дуу” (2012), Да.Сэрэннамжил, Г.Цагаанхүү нарын хамтран бичсэн “Үзэмчин уртын дуу, түүний үүсэл гарал” (2023) зэрэг нь Үзэмчиний уртын дууны онцлог, шүлгийн агуулга, дуучдын талаар өгүүлсэн чухал эх сурвалжууд болж байна (А.Тогтох, 2025).

Хятадын Лин Бан болон бусад эрдэмтэд Үзэмчин ястны оршуулгын зан үйлийн талаар судалсан бөгөөд тэрхүү судалгаандаа Өвөр Монголын Найрентаолигай оршуулгын газраас олдсон хонины хавиргаар нас барсан хүний нүүрийг бүтээсэн зан үйл нь сүнсийг хамгаалах бөө мөргөлийн үзэл санаатай холбоотой байж болохыг судлан тогтоожээ. (Lin Ban et al., 2022). Японы Кагошима Их Сургуулийн эрдэмтэн Такахиро Озаки нь Хойд Монгол (буюу Монгол Улс) болон Өмнөд Монгол (өөрөөр хэлбэл Өвөр Монголын Өөртөө Засах Орон)-ын мал аж ахуйн бодит нөхцөл байдлыг харьцуулан судалж, бусад нийгмийн бүлгүүдтэй хийдэг нийгэм-эдийн засгийн харилцаа нь малчдын амьжиргаанд хэрхэн нөлөөлж буйг судалсан байдаг. (Ozaki, 2005).

Өмнөх судалгаануудаас харахад бусад улс орнуудын эрдэмтэд дэлхий дээрх өндөр хөгжилтэй улс орнууд соёлын ижилслийг хурдасгах хандлагатай байгаа гэж үзэж байгаа бөгөөд түүнд хариу үзүүлэх соёлын дархлаа чухал болохыг онцолж байна. Монголын судлаач, эрдэмтэд соёлын дархлаа гэх ойлголтыг үндэсний соёлыг өөрийн

өнгө хэлбэрээр нь хадгалан, залуусын соёлд тэрхүү үндэсний агуулгаа шингээж Монгол хүнээр нь байлгах тухай онцлон авч үзсэн байна. Тэр дундаа үзэмчин судлаачид үзэмчний түүх соёл, аж байдал, ардын урлаг судлалын хүрээнд нэлээдгүй судалгаа хийсэн байгаа ч Үзэмчин ястны өв соёл ба оюуны дархлааны өнөөгийн түвшинг судалсан бүтээл цөөн байна. Иймд бидний судалгаа нь үзэмчин ястны соёлын дархлааны өнөөгийн байдлыг тодорхойлж, улмаар үзэмчин судлалд хувь нэмэр оруулж буйгаараа ач холбогдолтой юм.

Үзэмчин ястны угсаа гарвал ба соёл

Үзэмчин ястны түүхэн үүсэл, нийгмийн онцлог: Үзэмчин ястны түүхэн үүсэл, бүрэлдэн тогтсон цаг хугацаа, газар зүйн байршлыг нарийн тодорхойлсон баримт хомс боловч түүхэн эх сурвалжууд, ялангуяа Үзэмчин гүн Гомбожавын "Гангын урсгал", "Чин улсын түүхэн ноорог" зэрэг бүтээлүүдэд Үзэмчин нэр үүссэн тухай тодорхой дурьдсан байдаг. Тухайлбал, Юань улсын Тайзу хааны ач Төрболд Хангай нутгаас говьд нүүж суурьшсан тухай, түүний ач Онгон дурал ноён өөрийн харьяат аймгаа "Үзэмчин" хэмээн нэрлэсэн тухай дурджээ. Мөн "Эрдэнэ тунамал нэрт судар оршив", "Алтан хүрдэн мянган хэгээст бичиг" зэрэг сурвалж бичигт Үзэмчиний ноёдын уг гарвалыг Чингис хаанаас улбаалсан хэмээн тэмдэглэсэн байдаг.

Түүхчдийн судалгаагаар, Үзэмчин ястан нь Монголын феодалын бутралын үе буюу XVI зууны сүүлчээр, Батмөнх Даян хааны улсаа хөвгүүддээ хувааж өгсний дараахан түүхийн тавцанд бие даасан аймаг, угсаатны нэгж болон гарч ирсэн хэмээн үздэг. Гэвч түүхэн сурвалжуудаас харахад Үзэмчин нэршил XIII зууны үед ч хэрэглэгдэж байсан бөгөөд Чингис хааны үед багтсан олон отог аймгийн дотор дурдагддаг байна. Жишээ нь, Дарма гүүшийн "Алтан хүрдэн мянган хэгээст бичиг"-т Үзэмчин отог дурдагдаж, улмаар Цахар түмэнд багтаж байсан нь тэмдэглэгдсэн байдаг. Үүнээс харахад "Үзэмчин" хэмээх нэр шинэ үүсэл бус, харин дахин сэргээгдсэн, уламжлалт нэршил байх боломжтой.

Зарим судлаачид үзэмчин нэрийг газар орны онцлог болон аж төрөх хэлбэртэй холбон тайлбарладаг. Судлаач З.Гончигжав Үзэм ууланд ургасан жимс, түүнийг хүнсэнд хэрэглэх явц, ард иргэдийн амьдралын хэв маягтай холбон “үзэмчин” нэр үүссэн гэж үздэг. Энэ нь ч мөн ардын аман зохиолд тусгалаа олсон байдаг.

Үзэмчингүүдийн хэл, зан заншил, цагаан идээ боловсруулах арга барил зэрэг нь баруун Монголын ойн иргэдийнхтэй төстэй байдаг талаар хэл шинжээч Ж.Цолоо, бусад судлаачид анзаарч, угсаатны гарал нь баруун бүс нутгаас холбогдох магадлалтай гэж үзжээ. Манж Чин улсын үеэс эхлэн үзэмчин ястан нь захиргааны хуваарийн дагуу баруун болон зүүн гар хошуунуудад хуваагдаж, ван, гүн, бэйлийн зэрэг хэргэмтэй захирагчдаар удирдуулж байсан байна. (Д.Наранцэцэг, О.Эрдэнэчимэг, 2024)

Үзэмчин ястнууд өнөөгийн байдлаар Монгол Улсын Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Булган сумд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 3-р багт төвлөрөн суурьшсан байна. Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны (ӨМӨЗО) Шилийн гол аймгийн Зүүн болон Баруун Үзэмчин хошуу, Шилийн хотын Цог-Уул, Төгрөг сум, Долооннуур, Улаанцав хотын Цахар Баруун

Уулын Хөвөөт хөх хошуу, Их Зуу аймгийн Эзэн хорго хошуу, Жирэм аймгийн Дархан түшээт хошуу зэрэг газруудад төвлөрөн амьдарч байна. Үүнээс гадна зарим хэсэг нь тархмал байдлаар бусад бүс нутгуудад амьдардаг. Монгол Улсын 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн дүнгээс үзэхэд, үзэмчин ястан нийт хүн амын 0.1 хувийг эзэлж байна (Үндэсний статистикийн хороо, 2020). Харин ӨМӨЗО-д 2020 оны байдлаар 90,000 орчим үзэмчин хүн ам бүртгэгдсэн нь Хятад улсын хэмжээнд монгол хэлээр ярьж буй 4,644,600 орчим монгол ястны 1.9 хувийг эзэлж байна. Аймгийн түвшинд авч үзвэл, Дорнод аймгийн 2020 оны хүн амын статистикийн мэдээллээр халх ястан 70.3%, буриад ястан 20.8%-ийг бүрдүүлж байгаа бол үзэмчин ястан 2.1%-ийг эзэлж байна. Тэдний 41.2% нь хөдөө орон нутагт амьдарч байна (Дорнод аймгийн статистик, 2021). Харин Сүхбаатар аймгийн хэмжээнд үзэмчин ястан нийт хүн амын 0.3%-ийг бүрдүүлж байна (Сүхбаатар аймгийн статистик, 2021). (А.Тогтох, 2025)

Үзэмчин соёлын бүрэлдэхүүн хэсгүүд: Үзэмчин ястны соёл нь олон зуун жилийн туршид бүрэлдэн төлөвшиж, Монголын оюуны дархлаа, соёлын өвийн салшгүй хэсэг болон хадгалагдан ирсэн. Соёлын энэ өв нь зөвхөн хэл, хувцас, хоол унд төдийгүй ёс заншил, ёслолын систем, байгаль шүтлэг зэрэг өргөн хүрээг хамрах бөгөөд тухайн ястны түүхэн, нийгэм-соёлын үнэт зүйлсийн цогц илэрхийлэл болдог. Тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн заримыг доорх байдлаар онцлон авч үзэж болно.

Үзэмчин аялгуу ба хэлний өв: Үзэмчин аялгуу нь монгол хэлний нутгийн аялгууны бүтцэд хамаарах бөгөөд дотоод бүтэц, утгын гүн гүнзгий давхаргаараа эртний монгол хэлний онцлогийг хадгалсан байдаг. Тус аялгуу нь өдөр тутмын ахуй, зан заншилтай шууд холбоотой олон зуун үг хэллэгийг агуулдаг бөгөөд зарим нь орчин цагийн монгол хэлнээс алдагдсан буюу утгын хувьд хувирсан байдаг. Судалгаагаар үзэмчин аялгууны үгсийн сангийн 20 гаруй хувь нь монгол хэлний уламжлалт хэрэглээнээс ялгаатай байна (Д.Наранцэцэг, О.Эрдэнэчимэг, 2024). Эдгээр үгс нь зөвхөн хэл шинжлэлийн төдийгүй соёл-сэтгэлгээний өв уламжлалыг судлах чухал хэрэглэгдэхүүн болдог.

Үзэмчин ястны язгуур урлаг ба авьяас билэг: Үзэмчин ястны дунд авьяастнууд, туульч, ерөөлчид олон төрөн гарсан нь тэдний аман зохиол, соёлыг баяжуулсан нь онцгой түүхтэй. Тухайлбал, Гамал хэмээх үзэмчин шүлэгч 1871 онд төрж, бичиг үсэг, шүлэг найргийн ур чадвараа хөгжүүлэн олон бүтээл туурвиж, ардын соёлын өвийг хадгалж ирсэн. Ерөөлч Чимэдийн Жигмэд нь нийгмийн сөрөг үзэгдлийг шүлгээр илэрхийлж, социалист бүтээн байгуулалтыг магтан дуулсан бүтээлүүд туурвисан бөгөөд 1948 онд "Ардын ерөөлч" цол хүртсэн түүхтэй. Үзэмчин угсаатнаас олон үе дамжин олон авьяастан төрж, язгуур урлагийн амьд өвийг хадгалж, залуу үеийг хүмүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр байна. (Ч.Батсүх, 2005)

Үзэмчиний уламжлалт хувцас, гоёл чимэглэл: Үзэмчин ястны хувцас хэрэглэл нь монгол үндэстний нийтлэг хэв шинжийг хадгалсан ч хийц, өнгө, зориулалтын хувьд ялгарах онцлогтой. Дээлний оноо, нударга, эмжээр нь гоёлын болон нийгмийн байдлыг илэрхийлэх билэгдлийн шинжтэй. Малгай, гутал, бүс зэрэг нь нас хүйс, нийгмийн зэрэг зиндаатай уялдан тусгай хэлбэрээр ялгагддаг. Үзэмчин хувцас нь зөвхөн ахуйн хэрэглээний төдийгүй нийгмийн бүтэц, ёс заншлын дүр төрхийг илэрхийлэх таних тэмдэг болон хэрэглэгддэг. (Т.Ариунаа, 2014)

Уламжлалт хоол хүнс ба идээний ёс: Үзэмчиний уламжлалт хоол хүнс нь тухайн бүс нутгийн байгалийн нөхцөл, мал аж ахуй, ан гөрөөтэй шууд холбоотойгоор бүтээгдсэн байдаг. Цагаан идээ боловсруулах арга барил, мах бэлтгэх дэс дараалал, нэр томьёо, ёслолын зоогийн бүтэц нь өвөрмөц онцлогтой. Хоол хүнсийг зооглох дэс дараа, идээ ундааны цээр, ерөөл магтаал зэргээр дамжин угсаатны зан үйл, нийгмийн зохион байгуулалтай нягт уялдаатай илэрхийлэгддэг. (Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн, 2011)

Ёс заншил: мэндлэх, золголт, битүүлэх: Үзэмчин ястны дунд ёс заншлын тогтолцоо гүнзгий төлөвшсөн байдаг. Мэндчилэх, золгож мөргөх, сөхрөх зэрэг үйлдлүүд нь нас, хэргэм зэрэг, гэр бүлийн болон нийгмийн харилцааны онцлогт тулгуурласан нарийн дэг ёстой. Цагаан сарын үеийн битүүлэх, золголтын ёсон нь зөвхөн гэр бүлийн хүрээний зан үйл биш, харин нийгмийн уялдаа холбоог бэхжүүлэх, үе дамжсан уламжлалын дамжуулагч болж өгдөг. Хувцаслалт, хоол идээ, бэлэг сэлт хүртэл зан үйлийн нарийн дүрэм журмыг илэрхийлдэг нь угсаатны соёлын дотоод зохион байгуулалтыг харуулдаг. (Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн, 2011)

Үзэмчин шүтлэг ба “Сүлд тахилга”: Үзэмчин ястны уламжлалт шүтлэгт байгаль, газар орон, ан амьтны тотем шүтлэг давамгайлж байсан ч улмаар төрийн шинж чанартай “сүлд тахилга”-ны хэлбэрт шилжсэн байдаг. “Хөдөө сүлд”, “ордны сүлд”, “яаман сүлд” гэх мэт төрийн шинжтэй шүтлэгийн хэлбэрүүд Үзэмчиний нийгэмд онцгой байр суурь эзэлдэг байжээ. Тухайлбал, Зүүн Үзэмчингүүдийн тахиж ирсэн “алтан дөрөө” сүлд нь үндэстний түүх, төрийн уламжлал, домог туульстай нягт холбоотойгоор соёлын өв болон дамжигдан хадгалагдсан юм. Сүлд тахиx ёс нь нийгмийн хамтын сэтгэлгээ, сүсэг бишрэлийн илэрхийлэл болохын зэрэгцээ угсаатны нэгдмэл байдал, дотоод эв нэгдлийг хадгалах гол зан үйлийн нэг хэлбэр байв. (Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн, 2011)

Гал тахиx зан үйл: Үзэмчин айл өрхүүд гал тахилгыг гэр бүлийн аз жаргал, бүтээмжийн бэлгэ тэмдэг гэж үздэг уламжлалтай. Гал тахиx үйлдлийг баярын хувцас өмсөж, онгон хонь тахиж, галын судар уншиж гүйцэтгэх бөгөөд тахилгын дараах гурван өдрийн даллага авах, тахилгаа галаас салгахгүй байх зэрэг цогц ёс заншлыг даган мөрддөг нь үзэмчин соёлын ариун ариун дагнан авч явах ухамсар, ёс суртахуунтай холбоотой. (Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн, 2011)

Үзэмчин ураг, хуримын зан үйл: Үзэмчин ястны хуримыг "ураг" хэмээн нэрлэн, ураг барилдах ёсыг өндөр хүндэтгэлтэйгээр гүйцэтгэдэг. Ураг хуримын үеийн хэлмэрч нар гэр бүлийг төлөөлөн ухаан сорьсон шүлэглэсэн маргаан хийдэг нь үзэмчин ёс заншлын онцгой хэсэг бөгөөд энэ нь соёлын өвийг хадгалан дамжуулах, гэр бүлийн холбоог бататгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. (Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн, 2011)

Үзэмчин ястны хүүхэд, залуу үеийг хүмүүжүүлэх уламжлал: Үзэмчин ястнуудын хүүхэд, залуу үеийг хүмүүжүүлэх уламжлал нь олон үе дамжсан гүн ухаан, байгаль-нийгмийн мэдлэг дээр суурилсан бөгөөд энэ нь зөвхөн мэдлэг олгох бус, хүн чанар, эх оронч сэтгэл, хөдөлмөрч хандлагыг төлөвшүүлэх нийгмийн боловсролын хэлбэр юм. Хүүхдийг багаас нь хэл яриа, байгальтай харьцах ухаан, тоо баримжаа, ажиглалт, хөдөлмөрт сургах олон талт арга барил хэрэглэхийн зэрэгцээ ахмад үеийг хүндэтгэх сэтгэл, ёс заншлыг үлгэрлэн уламжлуулдаг нь чухал онцлог билээ. Тухайлбал, үзэмчин ястнууд "жил оруулах", "жилийн цай уулгах" зэрэг сэтгэлзүйн дэмжлэг бүхий баяр

ёслолыг хүүхдийн хүмүүжилд идэвхтэй ашигладаг. "Жил оруулах" зан үйл нь 13 наснаас эхлэн нас насанд тохирсон ерөөл хэлж, бэлэг өгөх ёслол бөгөөд хүний биологийн өөрчлөлт, нарны идэвхжилтэй уялдуулан шинжлэх ухаанч үндэслэлтэй гэгддэг. Харин "жилийн цай уулгах" ёс нь цагаан сарын дараахан жил бүрийн аз жаргалыг билэгдэн ах дүүсийн холбоог бэхжүүлдэг уламжлал юм (Ч.Ариунаа, 2005).

Хэл ярианы хөгжилд онцгой анхаарал хандуулж, түргэн хэллэг, тоо, өнгө, зүг чиг зэрэг ахуйн мэдлэгийг цээжлүүлэх замаар ухаан суулгадаг. Мөн үлгэр, ардын аман зохиол, мал зүслэх ухаан, ан авын мэдлэгийг сургалтын гол хэсэг болгон хэрэглэдэг нь хүүхдийн ажигч чанар, ёс суртахуун, сэтгэхүйг төлөвшүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Нэмж хэлбэл, хөдөлмөрт сургахдаа насны онцлогт тохируулан охид, хөвгүүдийг гэр ахуй, мал аж ахуй, гар урлалд үе шаттайгаар дадлагажуулж, эр зориг, тэсвэр хатуужлыг бие бялдар, сэтгэлийн түвшинд хөгжүүлдэг. Түүнчлэн ахмад хүнийг хүндэтгэх өвөрмөц уламжлал буюу "нэр цээрлэх" ёс нь олон арван жил дамжсан ёс заншлын нэг хэсэг юм. Тухайлбал: ахмадын нэрийг шууд хэлэхийг цээрлэж, төлөөлсөн нэр хэрэглэдэг тухайлбал: Аавыгаа аажий, эрэгтэй хүнийг амбаа, баавай, авжаа, ажаа, жоохон авгай, гөөгөө Ээжийг амаа, агаа, жаажий гэх, эмэгтэй хүнийг аагүү, аани, ангиа, бужай, шинагаа гэж голдуу дууддаг. (Ч.Ариунаа, 2005).

Судалгааны арга зүй

Бид 24 багц асуултыг дараах бүлэг агуулгын хүрээнд боловсруулсан. Үүнд: 1. Хүн ам зүйн мэдээлэл, 2. Үзэмчиний түүх, 3. Хэл соёл, 4. Үзэмчин соёлын элементүүд, 5. Үзэмчин соёлын өв уламжлал, 6. Үзэмчний уламжлалт зан үйл, 7. Үзэмчин соёлыг хадгалахад Үзэмчдийн оролцоо. Үүнээс 13 нь Лайкарт машистабын 5-н онооны үнэлгээтэй хариулттай, олон сонголтот хариулттай 4 асуулт, 1 хариулттай 7 асуултыг багтаасан. Судалгааны асуулгыг судалгааны явцын ил тод байдал, асуулгын бие даасан ойлгомжтой байдал, судлаачийн субъектив нөлөөлөлгүй байдал, судалгааны үндсэн зорилгод нийцсэн байдал зэрэг үзүүлэлтүүдээр хэмжиж тус ажлын хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг хангасан. Үүнд асуулгын үнэн зөв байдлыг асуулт тус бүрийн дараалал, хариултын ойлгомжтой байдал, асуултуудын харилцан бие биеэ нөхцөлдүүлэх байдлаар судлагдсан байдалд дурьдагдсан соёлын дархлааг тодорхойлох онолын хэмжүүрүүдэд тулгуурлан бүлэглэж (7 бүлэг) судалгааны үндсэн зорилго, зорилтууын хүрээнд боловсруулагдсан. Асуулгын бие даасан байдал нь асуулгын агуулга болон судалгааны ажлын зорилготой нийцсэн, улмаар судалгааны мэдээллийг цуглуулах, шинжлэх, боловсруулах болон тайлбарлах, тоймлох зэрэг судалгааны процессийн үйл явц бүрээр тодорхой илэрсэн байдалтай байна. Энэхүү асуулгаар Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн сум, Улаанбаатар хотод оршин суудаг үзэмчин иргэдээс Google платформаар дамжуулан, судалгааны ёс зүйн хэм хэмжээг баримтлах үүднээс оролцогчдын нэр, цахим хаягийг нууцлан судалгааны өгөгдлийг цуглуулав. Мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний судалгаанд ашигласан бөгөөд сайн дурын оролцоог хангасан. Судалгаанд нийт 86 оролцогч хамрагдсан. Цуглуулсан мэдээлэлд SPSS 27 програмыг ашиглан өгөгдлийн давтамж, корреляцын шинжилгээ хийж, үр дүнг дескрибтив аргаар тайлбарласан. Судалгааны статистик үр дүнгийн найдвартай

байдлыг хангахын тулд ганцаарчилсан ярилцлагад тулгуурлан нарратив буюу өгүүлэмжийн шинжилгээ хийж дүгнэсэн.

Судалгааны үр дүн

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилгын хүрээнд судалгааны өгөгдлийг асуулгын арга ашиглан, цахим хэлбэрээр цуглуулж, шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна. Үзэмчин ястны төлөөлөл болох нийт 86 оролцогчид энэ судалгаанд хамрагдаж Улаанбаатар хотоос 16, Дорнод аймгаас 70 үзэмчин хүн оролцсон. Эдгээр оролцогчдын нас, хүйс, харъяалал, боловсролын түвшин болон эрхэлж буй ажил мэргэжлийн төрөл гэсэн үндсэн 5 хүн ам зүйн мэдээлэлд үндэслэн тэдний язгуур соёлоо ямар түвшинд мэдэж байгаа, хэрхэн өвлөн уламжилж байгааг тодрууллаа.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Нас	Frequency	Percent	Харъяалал	Frequency	Percent	Ажил, мэргэжил	Frequency	Percent
18 доош	2	2.3	Улаанбаатар	16	18.6	малчин	10	11.6
18-25	1	1.2	Дорнод,	29	33.7	Төрийн албан хаагч	28	32.6
26-32	8	9.3	Хэрлэн сум			Багш, боловсролын	14	16.3
33-38	22	25.6	Дорнод,	16	18.6	салбарын ажилтан		
39-44	20	23.3	Сэргэлэн сум			Соёл, урлагийн	2	2.3
45-51	10	11.6	Дорнод,	24	27.9	салбарын ажилтан		
52-58	15	17.4	Баянтүмэн сум			Эмч, эрүүл	2	2.3
59 дээш	8	9.3	Дорнод, Булган	1	1.2	мэндийн ажилтан		
Total	86	100.0	сум			Хувиараа хөдөлмөр	18	20.9
			Total	86	100.0	эрхлэгч		
						Оюутан	2	2.3
Боловсрол	Frequency	Percent	Хүйс	Frequency	Percent	Тэтгэвэрт гарсан	6	7.0
Сүүр	2	2.3	эрэгтэй	40	46.5	Ажилгүй	3	3.5
Бүрэн дунд	23	26.7	эмэгтэй	46	53.5	Банк, санхүүгийн	1	1.2
Техник болон	6	7.0	Total	86	100.0	салбарт		
мэргэжлийн						Total	86	100.0
Дээд	55	64.0						
Total	86	100.0						


Хүн ам зүйн мэдээллээс харахад 33-44 насны бүлгийнхэн, Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн сумын харъяат иргэд өндөр хувьтай оролцсон байна. Оролцогчдын дотор дээд боловсролтой, төрийн албан хаагч, хувиараа бизнес эрхэлдэг хүмүүс бусдаасаа илүү оролцоотой байсан. Мөн боловсрол болон ажил мэргэжлийн хувьд ялгаатай түвшний хүмүүс хамрагдсан байна.

Хүснэгт 2. Үзэмчин ястан ба үзэмчин аймаг бүрэлдсэн түүх

		Үзэмчин аймаг хэмээн нэрийдэхэд аль ноёны харьяат байсан бэ?				Total	Percent
		Хүдэн хан	Хүчит мэргэн тайж	Онгон дурал	Мэдэхгүй		
Та үзэмчин угсаатан үүссэн түүхийг хэр сайн мэдэх вэ?	Маш сайн	0	1	2	0	3	3.4%
	Сайн	4	4		2	15	17.4%
	Дунд зэрэг	9	16	4	11	40	46.5%
	Бага зэрэг	1	3	3	14	21	24.5%
	Мэдэхгүй	1	1	0	5	7	8.2%
Total		15	25	14	32	86	100%
Percent		17.4%	29.1%	16.2%	37.3%		

Нийт оролцогчдын 46.5% нь үзэмчин угсаатны үүсэл гарлын талаар дунд зэрэг мэддэг гэсэн бөгөөд бага болон мэдэхгүй гэсэн саналын дүнтэй нийлбэл оролцогчдын 79.2% нь дунд болон түүнээс доош мэдлэгтэй байгааг харуулж байна. Оролцогчдын үзэмчин угсаатны түүхийн талаарх үр дүнгийн найдвартай байдлыг тодорхой болгох үүднээс үзэмчин аймаг бүрэлдэн тогтох үед хэн гэдэг ноёны албат байсан тухай асуулт

оруулсан. Оролцогчдын 37.3% мэдэхгүй, 46.5% (Хүдэн хан, Хүчит мэргэн тайж) нь ташаа хариулт өгч байгаа зэргээс үзэмчин угсаатны түүхэн гарвалын мэдлэг багахан байна гэж харагдаж байна.



Зураг 1. Үзэмчин ястны хэл


Дээрх хүснэгтэн мэдээллээс харахад нийт оролцогчдын 93% нь үзэмчин аялагаар дундаас доош түвшинд ярьдаг болохыг харуулж байна. Оролцогчдын насны бүлгээс тодруулж харвал, 52-оос доош насны бүлгийнхэн үзэмчин хэлээр дундаас доош түвшинд ярьдаг байна. Нөгөө талаас, үзэмчин аялагаар маш сайн ярьдаг 59-өөс дээш настай 1 хүн, сайн ярьдаг 59-өөс дээш насны 1 хүн, 33-38, 52-58 насны 3 хүн байгаа ба ихэнх нь ахмад настай хүмүүс байна.



Зураг 2. Үзэмчин аман зохиол, бүтээл унших байдал

Онолын хувьд, тухайн үндэстэн угсаатны хэлээр тэдний соёл илэрч байдагчлан, тус судалгаанд Үзэмчиний аман зохиол, гар бичмэлүүдийг хэрхэн уншиж танилцдаг тухай тандах асуулт оруулсан. Судалгаанд оролцогчдын 76.8% нь үзэмчин хэл, аялгуу бүхий эх сурвалж, бүтээлийг хааяа уншдаг эсвэл огт уншдаггүй хэмээн хариулсан нь тухайн угсаатны хэлний хэрэглээний түвшин буурч байгааг илтгэж байна. Энэ нь цаашлаад үзэмчин хэл, аялгуу мартагдах эрсдэл үүсч байна. Өмнө дурьдсанчлан хэл бол аливаа угсаатны соёлын өвийг уламжлуулах гол хэрэгсэл бөгөөд тухайн ястны оюуны өв, сэтгэлгээний хэв маяг, ёс заншил, үнэт зүйлсийг хадгалах, дамжуулах суурь хүчин зүйл юм. Иймээс үзэмчин ястны хэлний хэрэглээ багасах нь зөвхөн харилцааны асуудал бус, харин соёлын дархлаа суларч, өв соёлын амьд хэлбэр бүдгэрэх эрсдэл байна гэдгийг илтгэж байна. Иймээс үзэмчин соёлыг хамгаалах, өвлүүлэх үйлсэд

хэлний хэрэглээг сэргээх, боловсрол, соёлын бодлогыг боловсронгуй болгох, мөн эх хэлээр туурвисан бүтээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.



Зураг 3. Үзэмчин соёлын соёлын элемент (ажил мэргэжлээр)

Үзэмчин угсаатны уламжлалт соёлын элементүүдийг хүн ам зүйн үзүүлэлтээр шинжлэхэд оролцогчид уламжлалт наадам, цэнгэл болон хувцас, гоёл зүүсгэлийн талаар хамгийн сайн мэддэг болохыг зураг 4-ээс харж байна. Энэ нь үзэмчин ястан өөрийн үндэсний уламжлалт баяр ёслолын үйл ажиллагаагаар дамжуулан үзэмчин өв соёлоо хадгалан, улмаар өвлүүлж байгаагийн илрэл юм. Түүнчлэн өдөр тутмын болон баяр ёслолын үед өмсөж зүүдэг үндэсний хувцас, зүүсгэл нь үзэмчиний хувьд зөвхөн хэрэглээний эд зүйл бус, харин соёлын бэлгэдэл, өв соёлын бүрдэл болохыг илтгэж байна. Ийм байдлаар биет соёлын элементүүд нь өдөр тутмын хэрэглээ, зан үйлийн хүрээнд амьд хэлбэрээр оршиж, үзэмчин угсаатны үндэсний ялгарал, өвлөх соёлын тогтолцооны салшгүй хэсэг оршсоор байгааг харуулж байна. Үзэмчиний уламжлалт наадмыг өөрсдийн соёлын хамгийн гол бүрдэл хэсэг хэмээн үнэлсэн нь энэхүү элемент тэдний соёл, үнэт зүйлсийн ухамсарт чухал байр суурь эзэлдгийг илтгэж байна.

Хүснэгт 3. Үзэмчин соёлын өвлөн уламжлал ба уламжлалд нөлөөлөх хүчин зүйлс

Q14a: Үзэмчин соёлын уламжлалыг хэрхэн өвлөж байна вэ?	Responses		Percent of Cases
	N	Percent	
Амьдралын хэв маягаас	28	15.7%	32.6%
Аман яриа зохиолоос (түүх, үлгэр, сургааль, домог)	21	11.8%	24.4%
Наадам, баяр ёслолоос(хурим, жил оруулах гэх мэт)	57	32.0%	66.3%
Уламжлалт зан үйлээс	36	20.2%	41.9%
Өв соёлын сургалт, дугуйлангаас	5	2.8%	5.8%
Дуу, хөгжим, ерөөл магтаалаас	12	6.7%	14.0%
Баримтат кино, ярилцлага (өв тээгчидтэй хийсэн)	17	9.6%	19.8%
Өвлөөгүй	2	1.1%	2.3%
Total	178	100.0%	207.0%

Q15 Frequencies:	Responses		Percent of Cases
	N	Percent	
Төрийн бодлого	22	10.1%	25.6%
Соёлын бодлого	49	22.5%	57.0%
Нийгмийн байдал, нөлөө	11	5.0%	12.8%
Гадаад соёлын нөлөө	1	0.5%	1.2%
Боловсролын нөлөө	13	6.0%	15.1%
Орон нутгийн хөгжлийн бодлого	28	12.8%	32.6%
Угсаатан, ястаны шинж байдал	51	23.4%	59.3%
Гэр бүлийн хүмүүжил	43	19.7%	50.0%
Total	218	100.0%	253.5%

Түүнчлэн үзэмчиний уламжлалт баяр наадам зөвхөн ёслолын шинжтэй үйл ажиллагаа бус, харин түүх, үндэсний онцлог, нийгмийн харилцаа, үнэт зүйлсийг шингээсэн соёлын цогц илэрхийлэл болж байгааг энэ судалгааны үр дүн харуулж байна.

Мөн судалгаанд оролцогчидын уламжлалт баяр наадмын үнэ цэнийг үнэлэх үнэлэмж өндөр байгаа нь үзэмчин соёлын дархлаа, үндэстний ялгарал, хамтын үнэт зүйлсийг хадгалж, өвлөхөд уламжлалт наадам чухал үүрэгтэй болохыг баталж байна.

Үзэмчин өв соёлоо хэрхэн, ямар хэлбэрээр өвлөн уламжилж байгаа тухай, үзэмчин соёл, уламжлалаа хадгалахад нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах өгөгдлийн шинжилгээний үр дүнг зураг 5-аар тайлбарлан харуулж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь Үзэмчиний соёлын уламжлалыг наадам, баяр ёслолоор дамжуулан (32.0%), мөн амьдралын хэв маяг (15.7%), уламжлалт зан үйл (20.2%) зэрэг амьд харилцаанд суурилсан хэлбэрээр өвлөж байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ аман зохиол (11.8%), дуу хөгжим, ерөөл магтаал (6.7%), баримтат кино, ярилцлага (9.6%) зэрэг оюуны болон хэвлэл мэдээллийн сувгаар уламжлалыг өвлөж байгаа нь ч багагүй хувийг эзэлж байна. Харин өв соёлын сургалт, дугуйлан зэрэг албан ёсны боловсрол, сургалтын хэлбэрээр өвлүүлж буй хувь (2.8%) маш бага байгаа нь институцийн түвшинд үзэмчин соёлын өвлөн уламжлах тогтолцоо сул байгааг харуулж байна. Түүнчлэн оролцогчдын цөөн хувь (1.1%) нь огт өвлөөгүй хэмээн хариулсан нь үзэмчин соёлын уламжлал тасалдах эрсдэл байж болох юм гэж харж байна. Судалгааны үр дүнгээс харахад үзэмчин соёлын өвийг хадгалах, түгээн дэлгэрүүлэхэд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь угсаатан, ястны шинж байдал (23.4%) гэж үзэж байна. Энэ нь үзэмчин угсаатны өвөрмөц онцлог, язгуурын ялгарал нь соёлын өвийн үндсэн тогтолцоог хадгалахад чухал үүрэгтэйг харуулж байна. Мөн Монгол улсаас явуулж буй соёлын бодлого (22.5%) болон гэр бүлийн хүмүүжил (19.7%) тодорхой хувь эзэлж байна. Энэ нь төр, орон нутгийн бодлогоос гадна гэр бүлийн орчин, өдөр тутмын хүмүүжлийн оролцоо чухал болохыг харуулж байна. Орон нутгийн хөгжлийн бодлого (12.8%) болон төрийн бодлого (10.1%) тодорхой нөлөөтэй байгааг харуулж байгаа боловч бага хувь хэмжээтэй байгаа нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд соёлын өвийг хамгаалах бодлого бүрэн хэрэгжихгүй байгаагийн илрэл байж болох юм. Харин гадаад соёлын нөлөө (0.5%) хамгийн бага нөлөөтэй хэмээн санал өгсөн нь үзэмчин ястан дотоодын соёлын нэгдмэл байдал, дархлаагаа одоогоор сайн хадгалж байна гэж үзэж байна.

Хүснэгт 4. Уламжлалт зан үйлийн болон тухайлсан зан үйлүүдийн хамраарлын шинжилгээ

		Та үзэмчин угсаатны уламжлалт зан үйлүүдийг хэр мэдэх вэ?	хүндэлж мэндчилэх ёс	битүүлж шинэлэх зан үйл	гал тахих зан үйл	ураг хуримын зан үйл	Оршуул-гын зан үйл	хориг цээрийн зан үйл
Та үзэмчин угсаатны уламжлалт зан үйлүү-дийг хэр мэдэх вэ?	Pearson Correlation	1						
	Sig. (2-tailed)	0.000						
	N	86						
хүндэлж мэндчилэх ёс	Pearson Correlation	.665**	1					
	Sig. (2-tailed)	0.000						
	N	86	86					
битүүлж шинэлэх зан үйл	Pearson Correlation	.622**	.650**	1				
	Sig. (2-tailed)	0.000	0.000					
	N	86	86	86				
гал тахих зан үйл	Pearson Correlation	.634**	.683**	.710**	1			
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000				
	N	86	86	86	86			

ураг хуримын зан үйл	Pearson Correlation	.673**	.637**	.699**	.767**	1		
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000			
	N	86	86	86	86	86		
оршуулгын зан үйл	Pearson Correlation	.477**	.367**	.525**	.550**	.555**	1	.
	Sig. (2-tailed)	0.000	0.001	0.000	0.000	0.000		
	N	86	86	86	86	86	86	
хориг цээрийн зан үйл	Pearson Correlation	.470**	.427**	.487**	.619**	.676**	.695**	1
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	
	N	86	86	86	86	86	86	86
**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).								

Хамаарлын шинжилгээгээр бүх хувьсагчдийн хамаарал 0.367-аас 0.767 хооронд хэлбэлзэж, статистикийн хувьд 0.01 түвшинд ач холбогдолтой ($p < 0.01$) байна. Энэ нь үзэмчин угсаатны уламжлалт зан үйл тус бүрийн мэдлэг нь бие биетэйгээ холбоотой, нэг талаар мэдлэгтэй хүн бусад зан үйлийг ч сайн мэддэг байгааг харуулж байна. "Гал тахих зан үйл болон ураг хуримын зан үйл ($r = 0.767^{**}$)-ийн мэдлэг хамгийн өндөр хамааралтай байгаа бөгөөд эдгээр зан үйл нь үзэмчин угсаатны ёс заншил, шашин шүтлэгийн гол бүрдэл хэсэг байж болохыг харуулж байна. Мөн битүүлж шинэлэх зан үйл ба гал тахих зан үйлийн мэдлэг ($r=0.710^{**}$), ураг хуримын зан үйлийн мэдлэг ($r=0.699^{**}$) зэрэг өндөр корреляциуд гарч байна. Энэ нь шинэ жилийг тэмдэглэх уламжлал болон гэр бүлийн ёслолууд хоорондоо гүнзгий уялдаа холбоотой байж болох юм. Оршуулгын, хүндэлж мэндчилэх ёс ($r=0.367^{**}$), уламжлалт зан үйл ($r=0.477^{**}$) — харьцангуй бага ч гэсэн статистикийн хувьд онцлог корреляци ажиглагдаж байна. Энэ нь оршуулгын зан үйл нь бусад зан үйлээс тэс өөр сэдэв, онцлогтой буюу тухайн хүн бүрд ялгаатай мэдлэгтэй байж болохыг илэрхийлж байна. Хориг цээрийн зан үйлийн мэдлэг бусад олон зан үйлийн мэдлэгтэй хүчтэй корреляци үзүүлж байгаа нь (жишээ нь, ураг хуримын зан үйлтэй $r=0.676^{**}$, оршуулгын зан үйлтэй $r=0.695^{**}$) үзэмчин угсаатны ёс заншлын нягт холбоог харуулж байна.

Хүснэгт 5. Үзэмчин соёлын уламжлалыг хадгалж, дамжуулах аргууд

Q24 ^a	Responses		Percent of Cases
	N	Percent	
Үзэмчиний наадамдаа үргэлж оролцож, дэмждэг.	65	39.6%	75.6%
Үзэмчин хувцас, зүүсгэлээрээ гоёдог	28	17.1%	32.6%
Хүүхдүүддээ соёл уламжлалаа заан сургадаг	21	12.8%	24.4%
Үзэмчин угсаатныхаа брэнд бүтээгдэхүүнийг хийдэг	18	11.0%	20.9%
Үзэмчин хувцасаа урладаг	5	3.0%	5.8%
Соёл уламжлалын тухай нийгмийн сүлжээгээр түгээдэг	13	7.9%	15.1%
Үзэмчин соёлыг эрдмийн өгүүлэл, ном гаргадаг	2	1.2%	2.3%
Үзэмчин хэл, аялагаа хүүхдүүддээ сургадаг	12	7.3%	14.0%
Total	164	100.0%	190.7%

Үзэмчин угсаатны соёл уламжлалаа хэрхэн хадгалж, түгээж байгаа талаарх олон сонголттой асуултын (Q24a) үр дүн юм. Нийт 86 оролцогчдын саналын үр дүн нийт хувь 190.7% болсон байна. “Үзэмчиний наадамдаа үргэлж оролцож, дэмждэг” гэж хариулсан оролцогч 65 байна (75.6%) байгаа нь үзэмчин угсаатны хамтын үйл ажиллагаанд оролцох, нийтлэг үнэт зүйлээ дэмжих соёлын илрэл өндөр түвшинд байгааг харуулж байна. Мөн “Үзэмчин хувцас, зүүсгэлээрээ гоёдог” (32.6%) гэсэн нь соёлын илэрхийлэл, этник танигдах байдал өндөр түвшинд хадгалагдаж байгааг илтгэнэ. Эндээс үзэмчин ястангууд уламжлалт соёлыг идэвхтэй хэрэглэгч байдлаар

хадгалж байна гэж үзэж байна. Сургалтаар дамжуулах хэлбэр харьцангуй хязгаарлагдмал байна. Хүүхдүүддээ соёл уламжлалаа заан сургадаг байдал (24.4%), үзэмчин хэл, аялагаа хүүхдүүддээ сургадаг байдал (14.0%) бага байна гэж үзлээ. Энэ үр дүн нь үзэмчин соёлын уламжлалыг өвлүүлэх үйл явц харьцангуй бага байгааг харуулж байна. Энэ нөхцөл нь орчин үеийн амьдралын хэв маяг, хэлний нөлөө болон эцэг эхчүүдийн харилцаа, хандлагын зөрүүтэй байдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байж болох юм. Мөн бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан өвлүүлэх байдал харьцангуй бага байгаа буюу үзэмчин брэнд бүтээгдэхүүн хийдэг – 20.9%, үзэмчин хувцасаа өөрөө урладаг – 5.8%, соёл, уламжлалаа нийгмийн сүлжээгээр түгээдэг” - 15.1%, эрдмийн өгүүлэл, ном гаргадаг” – 2.3% гэсэн үр дүнгүүдээс харахад эдгээр үзүүлэлтүүд нь материаллаг соёлын үйлдвэрлэл, мэдлэгийн хэлбэрээр хадгалалт нь эрсдэлтэй түвшинд байгаа болохыг харуулж байна. Энэ нь уламжлалт соёлыг системтэй, бүтээлч аргаар түгээх механизм дутмаг байгааг харуулж байна. Тус судалгааны статистик шинжилгээний үр дүнг Үзэмчин угсаатны 2 хүнээс ярилцлага авч найдвартай байдлыг хангахыг оролдсон.

Ярилцлагын судалгаагаар, үзэмчиний уламжлалт баяр наадам, түүний үнэ цэнийн үнэлэмж сүүлийн үед нэмэгдэж байна гэсэн 68 настай өв тээгч (Б.Дулмаа, 2025) -ийн хариулт залуу үе сүүлийн жилүүдэд үзэмчний хувцас, хуримын ёслол, урлаг соёлын үйл ажиллагаанд анхаарч (Зураг 4) байна гэсэн асуулгын судалгааны үр дүнтэй дүйж байгаа нь үзэмчин ястны өв соёлын уламжлал сэргэж байгааг илтгэж байна. Мөн үзэмчин өв соёлыг хэрхэн өвлөн уламжилж байна вэ гэсэн асуултанд оролцогч (Б.Дулмаа, 2025) үзэмчин соёлыг түгээн дэлгэрүүлэхэд мэдээлэл дутмаг байгаа гэж хариулсан нь асуулгын судалгаанд оролцогчдын үзэмчин ястны түүхийн талаарх мэдлэг сул байна гэсэн статистик шинжилгээний үр дүнтэй (Хүснэгт 1) адил байна. Үзэмчний хүндлэх ёс, хурим, ерөөл магтаал, цагаан идээ боловсруулах, үндэсний хувцасаа оёж сурах, үзэмчин уурга, эмээл хазаар хийж сурах, түүх соёлтой холбогдолтой ном сэтгүүл гаргах замаар үзэмчин угсаатны өв соёлыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй гэсэн санал нь үзэмчин ястны соёл уламжлалаа хадгалж, түгээхэд үзэмчин хувцсаа өөрөө урладаг, эрдмийн өгүүлэл ном хэрэгтэй байгаа зэргийг онцолж байна.

Мөн тус ярилцлагын судалгаанд хамрагдсан 50 настай оролцогч (Б.Бөхбат, 2025) үзэмчин ястны соёлын дархлааг батжуулахад залуу үе, хүүхэд багачуудад зориулсан контент уралдаан, ахмад үеийнхэн уламжлалт ёс заншлын талаар сургамж, нэвтрүүлэг тогтмол хийж сурталчлах хэрэгтэй байна гэж үзсэн нь соёл уламжлалын тухай нийгмийн сүлжээгээр түгээж үзэмчин соёлын уламжлалыг хадгалж, дамжуулах байдал бага байгаа гэж үзсэн саналтай холбоотой байна. Ярилцлагын үр дүнгээс харахад Үзэмчин залууст чиглэсэн өв соёлыг сурталчилсан контент, нэвтрүүлэг дутмаг байгаагаас соёлын түгээн дэлгэрүүлэлт сул байгаа болохыг харж болохоор байна. Энэ үр дүн статистик судалгааны үр дүнг нотолж байна.

Тогтвортой хөгжлийн Тогтвортой хот, суурин “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалалтыг бэхжүүлэх” зорилтын хүрээнд үзэмчин соёлын өв, уламжлал нь орон нутгийн тогтвортой хөгжил болоод үзэмчингүүдийн

нэгдмэл байдлыг илэрхийлэх соёлын илрэл болж байна. Үзэмчин соёлын уламжлалын зарим мартагдаж буй, тухайлбал, үзэмчин ястны хэлний хэрэглээ зэрэг соёлын элементүүдийг соёлын олон янз байдлын үүднээс албан ёсны дугуйлан, мэргэжлийн сургалтуудаар дамжуулан өв уламжлалаа сэргээн батжуулах үйл ажиллагааг чанартай боловсролын зорилтын түвшинд хэрэгжүүлэх шаардлага байгааг судалгааны үр дүн илэрхийлж байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд оролцогчид үзэмчин угсаатны бүлэг төвлөрсөн Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн сумдад амьдарч байгаа, мөн Улаанбаатар хотод суурьшсан хүүхэд наснаас ахмад үеийн насны бүлгийнхэн байсан бөгөөд оролцогчдын боловсролын түвшин харьцангуй өндөр байсан нь цахим орчинд идэвхтэй үзэмчин хүмүүсийн төлөөлөл оролцсоныг харууллаа.

Үзэмчин соёлын өвийг хамгаалах, дамжуулахад угсаатны онцлог, соёлын бодлого, гэр бүлийн хүмүүжил зэрэг дотоод хүчин зүйлс давамгайл нөлөөтэй байна. Энэ нь Үзэмчид угсаатны өв соёлоо баяр наадмын арга хэмжээний түвшинд идэвхтэй хадгалж буйгаар илэрч байна.

Түүхийн урт хугацаанд үзэмчин түмний нийгэм-соёлын онцлог бүрэлдсэн нь Монголын нүүдэлчин соёлын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Энэ түүхийн улбааг ахмад үеэс уламжлан авах, хадгалан дамжуулах, нөгөө талаас залуу үеийнхэнд өвлөн уламжлуулахад үзэмчид анхаарал хандуулах шаардлагатай байна. Үзэмчин хэл аялгуу, аман зохиолоор дамжуулан түүх, соёлын өв уламжлалыг гэр бүлийн орчин, ахмад үеийн нөлөөлөл, орон нутгийн соёл боловсролын арга хэмжээгээр дэлгэрүүлэх боломжтой юм.

Түүнчлэн орон нутгийн хөгжлийн бодлого болон боловсролын оролцоог нэмэгдүүлснээр өв соёлыг тогтвортой хадгалах боломжтой байна. Учир нь үзэмчин соёлын уламжлал нь өнөөг хүртэл ахуйн түвшинд аман уламжлал ба амьд харилцаанд суурилсан хэлбэрээр өвлөгдөж ирсэн ч албан ёсны сургалт, боловсролын тогтолцоо дэх оролцоо хангалтгүй байна.

Эцэст нь үзэмчин ястны соёл, хэл, түүхэн өв нь Монголын дорнод бүсийн үнэт өв бөгөөд тодорхой хэмжээнд хадгалагдаж байгаа ч үзэмчин ясны хэлний хэрэглээ буурах, улмаар уламжлалт мэдлэг алдагдах зэрэг үзэгдэл үзэмчин соёлын тогтвортой байдалд нөлөөлж байна. Соёлыг хадгалж үлдэх нь гэр бүл, үзэмчин иргэд, ахмад үе, боловсролын байгууллага, төр, орон нутгийн хамтын үүрэг юм. Тиймээс судалгааны үр дүн нь бодлогын түвшинд анхаарах шаардлагатай асуудлууд байгааг харуулж, цаашид бодлогын шинжилгээ, өргөтгөсөн судалгаа хийх үндэслэл болж байна.

Үзэмчин ястны дунд өв соёлоо өвлөх, хадгалах, дэлгэрүүлэх хүсэл, ухамсар өндөр байгаа нь бодлогын чанартай арга хэмжээг зохион байгуулж заншвал үзэмчин соёл ирээдүйд тогтвортой хадгалагдах боломж байна.

ДЭВШҮҮЛЭХ САНАЛ

Үзэмчин соёлын залгамж чанарт анхаарах шаардлагаас улбаалан соёлын боловсрол, эрдэм судлал болон нийгмийн шаардлагын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

- Соёл, боловсролын түвшинд: Үзэмчин соёлыг цаашид хадгалах, өвлүүлэхийн тулд багш сурган хүмүүжүүлэгч, гэр бүлийн оролцоог дэмжих, хүртээмжтэй боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийг бий болгох, уламжлалт баяр ёслол, зан үйлийг дэмжих зэрэг хосолмол стратеги шаардлагатай байна.
- Судалгааны түвшинд: Үзэмчин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, судалгааны эргэлтэнд оруулах шаардлага байна.
- Нийгмийн харилцааны түвшинд: Нийгмийн сүлжээ, дижитал контент ашиглан залуучуудыг татах соёлын маркетингийн бодлого шаардлагатай. Үзэмчин брэнд, урлал, хувцас, хэл аялгууг эдийн засаг, боловсрол, соёлын бодлоготой уялдуулах хэрэгцээ байна.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЯЗГААРЛАЛТ

Энэхүү судалгааны үр дүнд зөвхөн соёлын үзэгдлийн үүднээс үнэлэлт дүгнэлт өгсөн хязгаарлагдмал талтай. Тус судалгааны ажлын түүвэр нь нийт үзэмчин ястны эх олонлогийг төлөөлөх чадвар харьцангуй бага байгаа бөгөөд цаашдын судалгаанд анхаарч судалгааны өгөгдөл цуглуулах аргыг оновчтой сонгох замаар түүврийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Lin Ban et al. (2022 оны 7). “*Shelter My Soul with Your Body*” – A Burial Custom Influenced by Shamanism: A Case of Covering a Dead Face with the Right Ribs of a Local Sheep in Inner Mongolia, China. doi:10.21203/rs.3.rs-1893664/v1
- Ozaki, T. (2005 оны 8 23). North and South Mongolia: A Comparison of Two Mongolian Pastoralist Societies. *Senri Ethnological Studies*, 69, 99-122. doi:10.15021/00002642
- А.Тогтох. (2025). Үзэмчин уртын дууны уламжлал ба өв. *Урлаг судлалын ухааны доктор (Ph.D) зэрэг горилсон бүтээл*. Улаанбаатар.
- Б.Бөхбат. (2025 оны 5). Үзэмчин соёлын уламжлал. (С.Сайнзаяа, Ярилцагч)
- Б.Даваацэрэн. (2016 оны 8 7). Монгол үндэстний дархлаа ба соёлын өвийн бодлого. (Б.Бямбасүрэн, Ярилцагч)
- Б.Дулмаа. (2025 оны 5). Үзэмчин соёлын уламжлал. (С.Сайнзаяа, Ярилцагч)
- Б.Мөнхбадрал. (2017). Үндэсний соёлын дархлаа ба соёлын аялал жуулчлал. *Үндэсний соёлын дархлаа ба соёлын аялал жуулчлал өгүүллийн эмхэтгэл*, (хуудсд. 10-11).
- Б.Сумъяа. (1998). *Монголын нүүдэлчдийн соёл: оршихуй, эс оршихуй*. Улаанбаатар.
- Б.Эрдэнэбат. (2019). Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг. *Trends.mn*. <https://www.trends.mn/n/9013-ээс> Гаргасан
- Байгаль, соёлын өвийг хамгаалах сан*. (2019 оны 12 05). <https://tahilga.mongoluv.mn/Page.aspx?ItemID=5-ээс> Гаргасан
- Д.Наранцэцэг, Д.Долгорсүрэн. (2011). *Үзэмчиний түүх соёлын ойллого*. Улаанбаатар.
- Д.Наранцэцэг, О.Эрдэнэчимэг. (2024). БНХАУ дахь Монгол угсаатны нийгмийн дүр төрх. (О.Эрдэнэчимэг, Хян.) *Монгол угсаатны гүн ухаанч сэтгэлгээ*, 125-188.
- Ж.Долгорсүрэн, Б.Мөнхбадрал. (2017). Соёлын дархлаа хэмээх ойлголтын тухайд. *Үндэсний соёлын дархлаа ба соёлын аялал жуулчлал*, (хуудсд. 6-19). Улаанбаатар.

- Л.Пүрэвлхам. (2019). Соёлын өв Хөгжлийн дархлаа. (Б.Батчимэг, Ярилцагч)
- Т.Ариунаа. (2014). Үзэмчин ястны уламжлалт өмсгөл, зүүтгэлд хийсэн судалгаа. *Үзэмчин судлал*, (хуудсд. 7-27). Улаанбаатар .
- Ч.Ариунаа. (2005). Үзэмчин ястны үр хүүхэд, залуу үеэ хүмүүжүүлдэг зарим онцлогоос. *Үзэмчин судлал*, (хуудсд. 28-34). Улаанбаатар.
- Ч.Батсүх. (2005). Үзэмчингүүд бол аман яруу найргийн их авъяас өв уламжлалтай ард түмэн болох нь. *Үзэмчин судлал*, (хуудсд. 46-49). Улаанбаатар хот.